

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
2015 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ, хувиар**
/Жилийн эцсийн байдлаар/

2015 оны 12 сарын 03

Бүлэг/зорилт/	ҮАХ-ын зорилтын тоо	ЭЗНЗ-ийн нийт заалт	Биелсэн	Тасарсан	Үүнээс :		Хэрэгжих шатандаа	ҮҮНЭЭС :					Хэрэгжилт, хувиар
					Хөрөнгө санхүүгийн улмаас	Дүүргээс үл хамаарах шалтгаанаар		90%	70%	50%	30%	10%	
1.Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлж, өөрийгөө тэтгэх эдийн засагтай болгох	18	47	19	2		2	26	23	2		1		92.0
2. Ажлын байрыг нэмэгдүүлэн нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ	29	100	81				19	10	5	1	2	1	94.7
3. Дэд бүтцийг хөгжүүлэх, иргэдийнхээ ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ	20	39	11	3	1	2	25	11	7	-	5	2	74.0
4.Экологи-байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана	8	27	7	3	-	3	17	11	3	2	1	-	84.6
5. Нутгийн захиргааны байгууллагын ажлыг боловсронгуй болгох талаар	14	49	22	-	-	-	27	19	5	-	2	1	88.4
Нийт	89	262	140	8	1	7	114	74	22	3	11	4	89.4

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2015 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ
/Жилийн эцсийн байдлаар/

Д/д	Дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн явц	Хувь
Нэг. Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ. 1.1. Бизнес эрхлэгчдийг дэмжих талаар				
1	1.1.1. Зээлийн барьцаа, батлан даалтын хуулийг хэрэгжүүлэхэд дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн үйл ажиллагааг чиглүүлнэ.	Өрхийн болон бичил бизнес эрхлэгчдэд бизнесээ тогтвортой эрхлэх чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.	Бизнесээ тогтвортой эрхлэх нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах зорилгоор анхан шатны сургалтанд хамрагдаж, бүлэг байгуулсан өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 31 иргэнд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 30.0 гаруй сая төгрөгийн үнэ бүхий оёдол, сүлжмэл, эсгий, гар урлалын төрөлжсөн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж олгон, өрхийн үйлдвэрлэгч 54 иргэнийг Драгон худалдааны төвд байнгын борлуулалтын 4 цэгээр хангасан. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төв “Өрхөөс өөдлөн дэвших” төсөл боловсруулсан. Төслийн хүрээнд сонгосон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэнээс бойжуулах байраар 2 иргэнийг хангаж, санхүүгийн дэмжлэгт 1, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн 50.0 сая төгрөгийн зээлд 1 иргэнийг уламжилж шийдвэрлүүлсэн. Шинээр бизнес эрхлэх, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 16 иргэдийг оролцуулсан бизнесийн танилцах аялал зохион байгууллаа. Аяллын хүрээнд томоохон үйлдвэрийн дэвшилтэт технологитой танилцаж, санал бодол, туршлага солилцлоо. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилан борлуулах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Сонгинохайрхан дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа”-г дүүргийн “Иргэдийн баяр”-ын арга хэмжээний үеэр өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 60 гаруй, улсын баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэнд 20, “Даншиг наадам-хүрээ цам” шашин соёлын арга хэмжээний өдрүүдээр Хүй 7 худагт 5 асарт 10 иргэнийг тус тус оролцуулан зохион байгууллаа.	100.0

2		<p>Үйлдвэрлэл эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн зөвөлгөөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлгөөнийг 2015.03.31-нд Драгон төвийн их танхимд зохион байгууллаа. Зөвлөлгөөнд нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газраас “Нийслэлийн үйлдвэр хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, Зээлийн батлан даалтын сан, дүүргийн Татварын хэлтэс “Цахим тайлангийн систем” сэдвүүдээр мэдээлэл хийж, санал бодлоо солилцлоо. Монголын үндэсний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ шат дамжлагагүйгээр хэрэглэгчдэд хүргэх, үйлчилгээг ойртуулах зорилгоор Тамгын газрын даргын 2015 оны А/07 дугаар тушаалаар “Цагаан сар-2015” үзэсгэлэн худалдааг 2015 оны 1-р сарын 30-наас 2-р сарын 18-ны өдрүүдэд Силвэр худалдааны төвд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдааны талаар ТВ-5 телевиз болон FM, радиооор сурталчилгааг явуулж, дүүргийн вэб сайтад мэдээллийг байршуулсан. Тус үзэсгэлэн худалдаанд 34 аж ахуйн нэгж, 12 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид оёмол, сүлжмэл, гар урлал болон хүнсний бараа бүтээгдэхүүнээ худалдаалж, 98,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p>	100.0
3	<p>1.1.2. Аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалт, бизнес инкубаци болон төсөл хөтөлбөр боловсруулах зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг мэргэшүүлэх шатны сургалтанд хамруулж, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах, инкубатор төвд бойжигчдын тоог нэмэгдүүлнэ.</p>	<p>Мэргэжлийн болон бизнесийн шат дараалсан 27 удаагийн сургалтанд нийт 771 иргэнийг хамруулсан. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл, сургалтын төвд аж ахуйн болон бизнес хөгжүүлэх, жижиг зээлийн төсөл боловсруулах 10 удаагийн сургалтанд 298 иргэнийг хамруулж, сертификат олгосон. Дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 5 удаагийн сургалтанд 113 иргэн, Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны оёдол, сүлжмэл, монгол гутал урлалын анхан шатны 12 удаагийн сургалтанд 360 гаруй иргэдийг хамруулж, мэдлэг, мэдээллийг олголоо. Дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл, сургалтын төвд 12, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвд 12 идэвхитэй бойжигч иргэн үйл ажиллагаагаа явуулж байна. “Шинэ зуун гэр хороолол” ТББ-ын байранд 1 ээлжээр 5 үйлдвэрлэгчийг түрээсийн хөнгөлттэй байраар хангасан байна.</p>	100.0

4	1.1.3. Дүүргийн эдийн засгийн тэргүүлэх 5 чиглэл болох сүү, мах, барилгын материал, сүлжмэл, оёдол, гар урлалын	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих салбар зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/458 дугаар захирамжийн дагуу “Дүүргийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын зөвлөл”-ийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зөвлөлийн хурлаар дотоод журмыг хэлэлцэн баталлаа. Тус салбар зөвлөл дүүргийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг холбогдох хууль, журам, хөтөлбөрийн хүрээнд чиглүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.	70.0
5	үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг дээрх салбарт чиглүүлж, дүүргийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно	Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулж, дүүргийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулаж сурталчилна.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг 10 аж ахуйн нэгж байгууллагын ЖДҮ-ийн зээлд /10.0 саяаас 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай/ хамрагдах хүсэлтийг “Хувираа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 5.0, 10.0 сая төгрөг хүртэлх жижиг зээлийн төсөлд хамрагдсан нийт 54 иргэнд 281.8 сая төгрөгийн зээл олгогдсон байна. 3.0 сая хүртэлх төгрөгийн “Санхүүгийн дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 123 иргэнд 144.7 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. 2012-2014 онд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 99 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ажлын явц, зээлийн зориулалтанд АҮЯамтай хамтран хяналт тавин ажиллаж байна. Засаг даргын 2015 оны А/461 дүгээр захирамжийн дагуу 2015 оны дүүргийн “Брэнд бүтээгдэхүүн” шалгаруулах үзэсгэлэн худалдааг 11-р сарын 27-ны өдөр Драгон бустерминал төвд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд томоохон үйлдвэрлэгч Мах импекс ХК, Талх чихэр ХК, Сүү ХК, Тесо корпораци болон дүүргийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг 20 гаруй аж ахуйн нэгж байгууллагууд бараа бүтээгдэхүүнээ сурталчилан, сугалаатай, бэлэгтэй, урамшуулалтай, хямдралтай худалдаа үйлчилгээ гаргалаа. Арга хэмжээний үеэр 2015 оны “Дүүргийн брэнд бүтээгдэхүүн”-ээр Сүү ХК-ны “Миний Монголын сүү”, “Дэвшилтэт технологиор үйлдвэрлэсэн шилдэг бүтээгдэхүүн”-ээр Тесо корпорацийн “Зөв аарцны ундаа” бүтээгдэхүүн, “Эрүүл мэндэд ээлтэй шилдэг бүтээгдэхүүн”-ээр Хөвсгөл их тайга ХХК-ны “Цайны үрэл” бүтээгдэхүүн, “Өргөн хэрэглээний шинэлэг шилдэг бүтээгдэхүүн”-ээр “Ховор угалз” ХХК-ны “Эсгий монгол гутал” бүтээгдэхүүнийг тус тус шалгаруулж, дүүргийн Засаг даргын “Батламж”, цом, үзэсгэлэн худалдаанд	100.0

			идэвхи санаачлагатай оролцсон 25 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагад дүүргийн Засаг даргын “Талархал” гардууллаа. Үзэсгэлэн худалдааны арга хэмжээг ТВ-9, eagle, НТВ, V-TV зэрэг телевизүүдээр сурталчилж, мэдээллийг олон нийтэд хүргэлээ.	
6	1.1.4. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.	Үйлдвэрлэл эрхлэгчдийг хамтын ажиллагаатай улсуудын бизнес эрхлэгчидтэй холбох үйл ажиллагаа зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/262 дугаар захирамжийн дагуу харилцаа, хамтын ажиллагаатай Хайлаар хотод зохион байгуулагдсан Хятад, Монгол, Орос гурван улсын Эдийн засгийн форум, үзэсгэлэн яармаг худалдаанд жижиг, дунд үйлдвэрлэгчдийн төлөөлөл 15 иргэнийг оролцуулсан. Оролцогчид 48.0 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүний борлуулалт хийсэн байна. Арга хэмжээний үеэр жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг Хайлаар хотод борлуулах “Сонгинохайрханд үйлдвэрлэв” худалдааны цэг нээх тухай Санамж бичигт гарын үсэг зурлаа. “Санамж бичиг”-ийн хүрээнд дүүргийн үйлдвэрлэгчид Хайлар хотын Нантун худалдааны төвд 9-11-р сард ноос, ноолуурын чиглэлээр 1 лангуу ажиллуулан бараа бүтээгдэхүүнээ худалдаалсан. 11-р сараас эхлэн Манжуур хотын худалдааны төвд байнгын борлуулалтын цэг нээн ажиллуулж байна.	100.0
7	1.1.5. Газар тариалан, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	Чацаргана бусад жимс жимсгэнэ тариалах, хөрс ургамал хамгааллын цогц сургалт зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/83 дугаар захирамжаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг газар тариалангийн мэдлэгтэй болгох практик сургалт, чацаргана, жимс жимсгэнэ, таримал ургамлуудад түгээмэл хэрэглэгдэж буй усалгааны системийг хэрхэн ашиглах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх тухай танхимын, 21-р хорооны Их булагийн аманд иргэн н.Дашжавын тариалангийн талбайд талбайн сургалтыг 60 гаруй иргэдийг хамруулан тус тус зохион байгууллаа. Хүнс, Хөдөө аж ахуйн яам, нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газартай хамтран өрхийн тариаланг механикжуулах зорилгоор жимс, жимсгэнэ, хүнсний ногооны иж бүрдэл техникийн үзүүлэх сургалтыг 21-р хорооны Их булагийн аманд хүлэмжийн аж ахуй эрхлэгч иргэн н.Наранбаатарын талбай дээр зохион байгууллаа. Сургалтанд 9 дүүргийн 140 иргэн хамрагдлаа.	100.0
8		Хаврын тариалалт, намрын ургац хураалтын дүн мэдээг	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 150 га-д тэжээлийн ургамал тариалж 1500 тн ургац, 180 га-с 2030 тн төмс, 175 га-с 1720 тн	90.0

		нэгтгэн хяналт, шалгалт хийнэ.	хүнсний ногоо, 30 га-с 112.5 тн жимс жимсгэнэ хураан авсан дүнтэй байна. Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газартай хамтран хаврын тариалалт, намрын ургац хураан авалтын явцад тус бүр 1 удаа хяналт шалгалт явуулсан.	
9		Намрын ногоон өдрүүд арга хэмжээг зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/380 дугаар захирамжийн хүрээнд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоотой хамтран зохион байгуулж 5 цэгт худалдаа үйлчилгээг гаргалаа. Тус арга хэмжээнд 50 иргэн төмс 75.0 тн, хүнсний ногоо 102.0 тн, бусад ногоо 52тн-г худалдаалж, нийт 350.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	100.0
10	1.1.6. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	“Эрчимжсэн мал аж ахуй” дэд хөтөлбөр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны А/80 дугаар тогтоолоор дүүргийн Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг батлуулсан. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд 2015 онд хийж гүйцэтгэх 9 зүйл заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулж, 94.1 хувийн гүйцэтгэлтэй ажиллаа.	90.0
11		Зам тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод ажиллаж буй улсын байцаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	Шалган нэвтрүүлэх товчоодод ажиллаж байгаа улсын байцаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 1.2 сая төгрөгийн хөрөнгө гарган ажлын байрыг тохижууллаа. Хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мал амьтан, хорио цээр, чанарын чиглэлээр 98 иргэнийг хамруулан сургалт зохион байгууллаа. Дүүргийн нутаг дэвсгэрт халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хавар, намрын вакцинжуулалтанд нийт 234 мянган толгой /давхардсан тоогоор/ мал, амьтанг вакцинжуулж 21.6 сая төгрөг зарцуулсан байна.	100.0
12		Зөвшөөрөгдөөгүй цэгт мал худалдаалдаг асуудлыг таслан зогсооно.	Засаг даргын 2015 оны А/170 дугаар захирамжийн хүрээнд 32-р хороонд мал эмнэлгийн хяналтанд мал худалдаалах, төхөөрөх нэгдсэн цэгийг бий болгон байнгын хяналт тавьж ажилласан. Хөдөө орон нутгаас орж ирсэн 1600 толгой хонь, 1400 ямааны гарал үүслийн баталгаажилтыг хянан шалгаж, Эмээлт зах ХХК-ийн мал худалдаалах нэгдсэн цэгт оруулж, захын үйл ажиллагааг тогтмолжуулав. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд байгаа 2 аж ахуйн нэгжид малыг хотоос гаргах тухай тус бүр 2 заалттай албан шаардлага хүргүүлж биелэлтийг тооцож ажиллаа.	90.0

13	<p>1.1.7. Худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.</p>	<p>Худалдаа, нийтийн хоол, зочид буудал, дэн буудлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа газруудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.</p>	<p>Худалдааны салбарын чиглэлээр: “Сар шинэ”, “Хяналт”, “Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт”, ТҮЦ” зэрэг удирдамжит, төлөвлөгөөт, түүвэрчилсэн 6 удаагийн хяналт шалгалтыг 532 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан явууллаа.</p> <p>Илэрсэн зөрчил: Хяналт шалгалтаар цаг хэтрүүлэн ажилласан, зохих зөвшөөрөлгүй согтууруулах ундаа худалдсан, ЕБС-с 500м-ийн тойрогт үйл ажиллагаа явуулж буй хүнсний мухлаг, дэлгүүр, түргэн үйлчилгээний цэгүүдэд зохих зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулсан, ширхэглэсэн, насанд хүрээгүй хүүхэд худалдаа эрхэлсэн зэрэг зөрчлүүдийг илрүүлж ажилласан.</p> <p><u>Авсан арга хэмжээ:</u> Зөрчил бүхий 94 аж ахуйн нэгж, иргэний 1506ш тамхи, 248.5 мян төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн 35 шил архи согтууруулах ундааг хурааж, дүүргийн Засаг даргын дэргэдэх Орон тооны бус зөвлөлд шилжүүлэн, “Захиргааны хариуцлагын тухай” хуулийн 42 дугаар зүйлийн 42.2, Тамхины хяналтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.6 дахь заалтын дагуу 94 иргэн, хуулийн этгээдэд нийт 4,6 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулан, 12 заалт бүхий 8 албан шаардлага өгч зөрчлийг арилгуулж ажиллалаа. Цагдаагийн хэлтсээс шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Тамхины хяналтын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хууль зөрчихгүй байх, насанд хүрээгүй хүнд тамхи худалдан борлуулахыг хориглосон тухай 30 албан мэдэгдлийг хүргүүлж, биелэлтэнд хяналт тавьж ажилласан.</p> <p><u>Зочид буудал, аялал жуулчлалын чиглэлээр:</u> Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан 25 аж ахуйн нэгжийг хамруулан 5 удаагийн стандартын үзлэг шалгалтыг явуулж, стандартын шаардлага хангасан 24 зочид буудал, 18 дэн буудалд зөвшөөрөл олгосон.</p> <p><u>Нийтийн хоолны салбарын чиглэлээр</u> Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 3 удаагийн удирдамжит хяналт шалгалтыг 151 хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газруудыг хамруулан явууллаа. Хяналт шалгалтын</p>	90.0
----	---	--	--	------

			<p>явцад 53 албан шаардлага өгч, зөрчил гаргасан 15 аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэнд нийт 4.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг авлаа. БСШУ, ЭМ сайдын хамтарсан 379/3410 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 дугаар тушаалын хэрэгжилт, хоол хүнсний хангамж эрүүл ахуй, чанарт шинжилгээ үнэлгээ хийх зорилгоор хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын 12, 36, 65, 67, 81, 82, 83, 86, 74, 76, 105-р сургуулийн цайны газрууд хамрагдлаа. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар 12 байгууллагад 108 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 2 байгууллага, аж ахуй нэгжид 726.0, 1 албан тушаалтанд 384.0, нийт 1110.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.</p>	
14	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран аттестатчилал явуулж, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгийн тоог бууруулна.	Улаанбаатар хотын Ерөнхий Менежерийн баталсан удирдамжийн дагуу тус дүүрэгт согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон худалдааны 500, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ресторан 27, баар 44, кафе 11 нийт 82 газруудыг аттестатчиллаа. Аттестатчиллаар стандартын шаардлагыг 85%-иас дээш хангасан, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан, тохижилт, ногоон байгууламжийг тодорхой түвшинд нэмэгдүүлсэн худалдааны 429, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 75 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн эрхийг сунгах, худалдааны 3 байгууллагын нэр шилжүүлэх, шинээр олгох 16, эрх сэргээх 2, дээрх шаардлагууд хангагдаагүй 24, үйл ажиллагаагаа зогсоосон 9, нийт худалдааны 33, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 7 байгууллагын тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлах саналыг ажлын хэсгийн тэмдэглэл, холбогдох баримт, материалын хамт дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2015 оны 7-р сарын 28-ны өдрийн 02/1604 тоот албан бичгээр Захирагчийн ажлын албаны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэст уламжлан шийдвэрлүүлээ.	100.0	

15		<p>Согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр хууль эрх зүйн уралдаан тэмцээн, зөвлөн туслах сургалт сурталчилгаа зохион байгуулна.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдааны байгууллагуудын зөвлөгөөнийг 2015.03.31-нд Драгон төвийн их танхимд 200 гаруй аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан зохион байгууллаа. Зөвлөлгөөнд нийслэлийн Үйлдвэр Хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, МУИС-ийн Бизнесийн сургууль, Зээлийн батлан даалтын сан, дүүргийн Татварын хэлтэс мэдээлэл хийж, санал бодлоо солилцлоо. Зөвлөгөөний үеэр амжилт бүтээлээр дүүрэн хөдөлмөрлөж, дүүргийнхээ хөгжил, бүтээн байгуулалтанд хувь нэмэр оруулан, худалдаа үйлчилгээний дэвшилтэт хэлбэрийг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж буй 9-р хорооны Шар нуурын мандал ХХК, 4-р хорооны ХКҮ ХХК-иудыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр, дүүргийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр 7-р хорооны Ханхөхий Хархираа Түргэн ХХК, 29-р хорооны СҮҮ ХК-иудыг шагнаж урамшууллаа. Зөвлөлгөөнд оролцогсдод өгөгдсөн мэдээллээр бэлтгэсэн 200ш зөвлөмж хэвлүүлэн тараасан. Аж ахуйн нэгж байгууллагыг аттестатчилах хяналт шалгалтыг угтан мэдээ мэдээлэл олгох, мэргэжлийн үнэмлэхтэй болгох ажлыг зохион байгуулж, Бизнесийн сургуультай хамтран 7-р хорооны Сувдан, Тумбааш, Нарханд төвийн болон бусад хүнсний дэлгүүрүүдийн 115 худалдагч нарын дунд 4 удаа сургалт хийж, 64 худалдагчийн мэргэжлийн зэрэг ахиулах, 51 хүнд худалдааны ажилчны мэргэжлийн үнэмлэх олголоо. Нийслэлийн 2015 оны шилдэг тохижилт, ногоон байгууламжтай цэмцгэр байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах болзолт уралдаан зарласантай холбогдуулан дүүргийн худалдаа, үйлчилгээний 350 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудад семинар зохион байгуулж, удирдамж танилцуулга ном тараан, мэдээлэл хийж, тохижилтын шинэлэг санаа, санаачлагын талаар аргачлал, зөвлөлгөө өгч ажиллав. Монголын Жижиг дэлгүүрүүдийг дэмжих холбоотой хамтран худалдааны салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх гарц, салбарын бодлогын талаар санал бодлоо солилцсон хэлэлцүүлгийг худалдааны 100 гаруй байгууллагыг хамруулан 2015.11.12-ны өдөр Драгон терминалын танхимд зохион байгууллаа. Худалдааны салбарын 94 жилийн ойн баярыг угтаж, 80 гаруй байгууллагыг</p>	90.0
----	--	---	---	------

			хамруулан, бүсчилсэн 9 багийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд Толгойт-2 баг түрүүлж, Өнөр бүс, Баруун бүс ХХК-1 багууд удааллаа.	
16		Зочид буудал, дэн буудлын үйлчилгээний ажилтнуудын дунд холбогдох хууль тогтоомж, стандартын чиглэлээр сургалт зохион байгуулна.	Аялал жуулчлалын ур чадварын төвтэй хамтран “Зочлох үйлчилгээний ур чадвар” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд дүүргийн нутаг дэвсгэрийн томоохон 11 зочид буудлын ажилчдыг хамруулж сертификат олгосон. “100% бэлгэвч” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн Аялал жуулчлалын газар, ХӨСҮТ-тэй хамтран БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар мэдлэг олгох, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх, тухайн байгууллага бэлгэвчийг тогтмол байршуулж хэвших тухай мэдээлэл өгөх сургалтыг 17 зочид буудал дэн буудлын ажилчдыг хамруулан зохион байгуулсан.	90.0
17		Зөвшөөрөгдсөн цэгээс бусад нийтийн эзэмшлийн гудамж, талбайд нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа машинт чингэлгийн худалдаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийнэ.	Дүүргийн Засаг даргын А/180 дугаар захирамжийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбай, явган зорчигчийн зам дээр зөвшөөрөлгүй байрлах нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан ТҮЦ, чингэлэг, павилонуудыг албадан чөлөөлөх хяналт шалгалтыг явуулж, 23 иргэнд албан шаардлага хүргүүллээ. Дүүргийн 18-р хорооны Залуус хороололд зөвшөөрөлгүй байрлах 3, 21-р хорооллын автобусны буудлын дэргэдэх 2, Өнөр хорооллын Замын цагдаагийн тасгийн дэргэд байрлах 1, Драгон төвийн дэргэдэх 4, Саппоро, Цамбагарав үйлчилгээний төвийн урд байрлах 4 нийт 14 чингэлэгийг нүүлгэн газрыг чөлөөллөө.	70.0
18	1.1.8. Толгойт, Баянхошуу, Өнөр бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулах санаачлагыг дэмжинэ.	Худалдаа, үйлчилгээний төв байгуулах, цэг салбараа өргөжүүлэх санал, санаачлага гаргасан аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Сайхан монгол ХХК нь 20-р хорооны нутаг дэвсгэрт Толгойт бүсийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад худалдаа, үйлчилгээг ойртуулж, 500 гаруй хүнийг ажлын байраар хангасан, орчин үеийн шийдэлтэй хүнс, барааны Сэлэнгэ захыг, 22-р хорооны нутаг дэвсгэрт Хос ай таг ХХК, Анхны хишиг ХХК, Энх мөнх хүсэл ХХК-иуд 80 гаруй хүнд ажлын байр бий болгож, орчны тохижилт, үйлчлүүлэгчийн тав тух, стандартын шаардлагыг хангасан худалдааны цогцолбор төвүүдийг ашиглалтанд оруулсан үйл ажиллагааг дэмжин холбогдох зөвшөөрлийг олгож, гэрээ байгуулан ажиллаа.	90.0

19	1.1.9. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хүнсний аюулгүй байдал, зөв зохистой хооллолт, шим тэжээлийн мэдлэг олгох сургалт зохион байгуулна.	Дэлхийн банк групптэй хамтран “Аюулгүй хүнс-Сайн бизнес” сэдэвт хүнсний аюулгүй байдлын тухай сургалтыг хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг 34 аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан зохион байгууллаа. Сургалтын үеэр хоол үйлдвэрлэлийн бизнес эрхлэгчдэд зориулсан ном болон багц зөвлөмжийг тараалаа. Технологийн дээд сургууль, Хүнс хангамж улсын үйлдвэртэй хамтран 105, 106-р цэцэрлэгийн тогооч, багш нар болон 150 гаруй эцэг эхчүүдийн төлөөллийг оролцуулан “Хүүхдийн хоол тэжээл-Эрүүл мэнд” сэдэвтэй сургалт, амталгаат хоолны өдөрлөгийг зохион байгууллаа. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/439 дүгээр захирамжийн дагуу “Эрүүл зөв хооллолт” сэдэвт сургалтыг хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 28 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулан Эрүүл мэндийн төвийн Хоол шим тэжээлийн танхимд зохион байгуулав. Сургалтаар хоол хүнсний давс, өөх тос, сахарын агууламжийг бууруулах, ногоон жор, органик болон цагаан хоолны цэс оруулж шинэчлэл хийх, зөв зохистой хооллолт, шим тэжээлийн мэдлэг олгох талаар мэдээ мэдээллийг хүргэлээ.	90.0
20		Хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хүлэмж, зоорины ашиглалт, хамгаалалтанд хяналт шалгалт хийнэ.	Хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хүлэмж, зоорины ашиглалт, хамгаалалтанд хяналт тавих шалгалтыг 2 удаа зохион байгууллаа. Хяналт шалгалтанд нийт 42 /давхардсан тоогоор/ иргэн, аж ахуйн нэгж хамрагдсанаас зөрчил дутагдалтай аж ахуйн нэгжүүдэд 8 заалт бүхий 12 зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт хийснээр 3 аж ахуйн нэгж ихээс дунд, 5 аж ахуйн нэгж, иргэн дундаас бага эрсдэлтэй рүү шилжсэн ба улсын байцаагчийн хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь ирүүлээгүй 2 албан тушаалтанд тус бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх торгуулийн арга хэмжээ, шийтгэвэр ногдуулан бүрэн барагдуулсан байна.	100.0
21		Нөөцийн махны худалдааг зохион байгуулна.	Хүн амын төвлөрөлт, хэрэглэгчдэд ойр дөт байршилтай, нөөцийн махыг хангалттай хэмжээгээр худалдаалах санхүүгийн чадамжтай, стандартын шаардлага хангасан 32 хорооны 81 аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон, нэрсийг ЗАА-ны ХХҮХ-т хүргүүлсэн. Сонгогдсон цэгүүдээр нийт 653,5 тн нөөцийн мах худалдаалагдсан байна.	100.0

22		Эмээлтэд мал нядалгааны жишиг газар байгуулна.	Дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт Саян уул ХХК мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан мал нядалгааны жишиг газрыг бий болгосон үйл ажиллагааг дэмжин холбогдох зөвшөөрлийг олгосон.	100.0
23	1.1.10. Архи, тамхины болон эрүүл бус хүнсний хэрэглээг бууруулах бүх нийтийн аян өрнүүлэх замаар эрүүл, соёлтой үйлчилгээ үзүүлдэг бизнесийн байгууллагыг дэмжинэ.	Согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран архи, тамхины хор, хөнөөлийг ойлгуулан таниулах аян зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/183 дугаар захирамжийн дагуу “Архи, тамхины хор хөнөөл”-ийг сурталчлах аяны хүрээнд дүүргийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газруудад “Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах болон Аюулгүй хүнс зөв зохистой хооллолт” сэдэвт сургалтыг Драгон болон Одод ресторанд тус тус зохион байгууллаа. Сургалтанд нийт 255 нийтийн хоолны газрын төлөөлөл хамрагдлаа. Архи, тамхины хор хөнөөлийг хүүхэд, залуучуудад ойлгуулан таниулах зорилгоор Толгойт, Төв, Өнөр, Баянхошуу бүсүүдийн 12, 65, 86, 105-р ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 563 сурагчдад “Архи, тамхины хор хөнөөл”-ийг сурталчлах аяныг зохион байгууллаа. Аяны үеэр “Архины хор нөлөө”, “Спиртлэг бус Спортлог” амьдралын төлөө хамтдаа, “Тамхи таны эрүүл мэндийн дайсан” сэрэмжлүүлэг, гарын авлага материал хэвлүүлэн тарааж, дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран сургалт зохион байгууллаа.	90.0
24		Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хууль, журмыг сурталчлах зорилгоор сэрэмжлүүлэг хэвлүүлж, сургалт зохион байгуулна.	Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах болон “Аюулгүй хүнс зөв зохистой хооллолт” сэдэвт сургалтыг Эрдэнэчулуут ХХК-ий Одод ресторанд СХДЭМТөвтэй хамтран зохион байгууллаа. Сургалтанд хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын 70 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл хамрагдлаа. Сургалтын үеэр архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах зорилгоор “Архины хор нөлөө”, “Спиртлэг бус Спортлог” амьдралын төлөө хамтдаа “Тамхи таны эрүүл мэндийн дайсан” сэрэмжлүүлэг хэвлүүлж тарааллаа.	90.0
25	1.1.11. Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэн өмчилсөн газраа эдийн засгийн эргэлтэнд	Иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын А/41, А/187, А/257, А/353, А/440, А/496, А/586, А/651, А/770, А/794, А/853 дугаар захирамжаар 5750 иргэнд шинээр газрыг өмчлүүлж, урьд нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан 973 хүсэлтийг шийдвэрлэж гэр бүлийн нэг гишүүнд өмчлүүлсэн. 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан тус дүүргийн 21 хороодын хуучин суурьшлын бүсэд үргэлжлүүлэн өмчлүүлэхээс НЗД-ын 9	100.0

	оруулахад дэмжлэг үзүүлнэ.		удаагийн захирамжаар 611 иргэнд 31.8 га газрыг шинээр өмчлүүлсэн.	
26		СХД-ийн 22-р хороо Баянголын ам, 24-р хороо Баруун салаа, 25-р хороо Зүүн салаанд зуслангийн зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эхлүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 21 өдрийн ХЕТ-2011/12 тоот захирамжаар Улаанбаатар хотын зуслангийн амуудын ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Тус дүүрэг нь батлагдсан байршилд ороогүй тул зуслангийн зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эхлүүлээгүй байна.	-
27	1.1.12. Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг ойртуулна.	Үсчин, гоо засалчдын дунд үйлчилгээний соёл, стандартын чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулна.	Монголын үсчин гоо засалчдын холбоотой хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй үсчин гоо засалчдын дунд Драгоны их танхимд сургалт зохион байгууллаа. Сургалтаар үсчин, гоо сайхны өнөөгийн чиг хандлага, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн чиглэлээр мэдээлэл хийсэн. Мэргэжлийн чиглэлээрээ амжилттай ажиллаж байгаа 4 үсчнийг дүүргийн ИТХ-ын “Өргөмжлөл”-өөр, МҮГЗХ-ны шагналаар 3 үсчнийг шагнаж урамшууллаа. Сургалтанд 48 үсчин гоо засалчид хамрагдсан. Дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй 12 иргэнийг Цэнгэл сор ХХК-ий “Зулаа сургалтын төв”-ийн үсчин гоо засалчийн мэргэжлийн сургалтанд хамруулж мэргэшүүлэн, ажлын байраар хангасан.	90.0
28		Ахуй үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ явуулах санал санаачлага гаргасан аж ахуйн нэгжийг дэмжин мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	3, 7, 22-р хорооны нутаг дэвсгэрт шинээр халуун усны газар байгуулж, үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан 3 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, гэрээ байгуулан ажиллаа. Дүүргийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн дунд Захирагчийн ажлын албаны ХХҮХэлтэс, дүүргийн ХЭАХНийгэмлэг, СХЗГ-ын Баталгаажуулалтын газар, АҮЯ-ны ЖДҮБХЗ-ын газруудтай хамтран “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”, ахуйн үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй журам, стандартыг сурталчилан таниулах чиглэлийн сургалтыг 30 гаруй аж ахуйн нэгжийг хамруулан, дүүргийн Иргэний танхимд зохион байгууллаа. Санхүүгийн дэмжлэг олгох төсөл хөтөлбөрийн хүрээнд алт мөнгөний дархан 2, авто засварын 4, бусад үйлчилгээний чиглэлээр 5, нийт 11 иргэний төсөлд 10,0 гаруй сая төгрөгийн санхүүжилт олголоо.	90.0

29		<p>Дүүргийн нутаг дэвсгэрт ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулж байгаа үсчин, гоо сайхны газруудад ХЭАХН-тэй хамтран Монгол Улсын “Үс засах үйлчилгээ” MNS 5160:2002, “Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага” MNS 5567:2006 стандартын хэрэгжилтийг хянах чиглэлээр хяналт шалгалтыг 7 сарын 25, 26-ны өдрүүдэд явууллаа. Шалгалтанд нийт 22 үсчин, гоо сайхны газрыг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарсан зөрчлийг арилгуулахаар 8 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран 3 сарын 10-наас 25-ны өдрүүдэд хяналт шалгалтыг бассейн 1, саун 3, халуун усны газар 18-ыг хамруулан зохион байгуулж, илэрсэн зөрчлийг үндэслэн нийт 5 улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Нийслэлийн 2015 оны шилдэг тохижилт, ногоон байгууламжтай цэмцгэр байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах болзолт уралдааны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн ахуйн үйлчилгээний 200 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд удирдамж, ном тарааж, мэдээлэл хийж, тохижилтын шинэлэг санаа, санаачлагын талаар аргачлал, зөвлөлгөө өгч ажиллалаа. Болзолт уралдааны хүрээнд аж ахуйн нэгж, иргэдийн 60 гаруй хувь нь тохижилт бүтээн байгуулалтыг сайн хийж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна. Нийслэлийн шилдэг тохижилттой халуун усны газар номинацид 5-р хорооны “Чандмань” халуун усны газар шалгаран өргөмжлөл 5.0 сая төгрөгөөр шагнагдсан.</p>	90.0
30		<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний газруудад холбогдох байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт зохион байгуулж, хууль, дүрэм журмыг мөрдүүлж ажиллана.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газартай хамтарсан, удирдамжит хяналт шалгалтуудыг 2 удаа зохион байгууллаа. Хяналт шалгалтанд авто машин угаалга, авто засвар, вьетнам засвар, дугуй засварын үйлчилгээ эрхлэгч 68 иргэн, аж ахуйн нэгжүүдийг хамрууллаа. <u>Илэрсэн зөрчил дутагдал:</u> Байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулсан, нэгдсэн хогийн цэггүй, хог хаягдлын гэрээ байгуулаагүй, авто угаалгын газрууд нь ажлын байрны стандартын шаардлага, галын аюулгүй байдлыг хангаагүй, бохир усаа ил үерийн суваг руу урсгасан зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрлээ. <u>Авсан арга хэмжээ:</u> Илэрсэн зөрчилд “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн дагуу 2 иргэнд нийт 960.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, вьетнам авто засварын үйлчилгээ эрхлэгч 1 аж</p>	90.0

			ахуйн нэгж, 2 иргэний үйл ажиллагааг түр зогсоон, гарсан нийтлэг зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч худалдаа, үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан ажиллаа.	
1.2. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын талаар				
31	1.2.1. Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, дүүргийн эдийн засгийн хөгжлийг сайжруулна.	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.	2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр: Орон нутгийн төсөвт 7843,8 сая төгрөг оруулахаас 7183,2 сая төгрөг төвлөрүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг 92,0, улсын төсөвт 26216,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 23590,8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 90,0, нийслэлийн төсөвт 23399,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 21069,4 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 90,0-иар тус тус биелүүлж байна.	90.0
32		Улсын төсвийн болон орон нутгийн байгууллагуудын төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулан, оновчтой хуваарилах замаар зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж төсвөөс төлөх өргүй ажиллах чиглэл баримтлан ажиллана.	Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг батлагдсан төсвийн хүрээнд жигд ханган биелүүлэхэд чиглэсэн ажлыг хийж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн байгууллагуудын хувьд эхний 10 сарын байдлаар 49168,6 мянган төгрөгийн төсвөөс төлөгдөх өртэй ажиллаж байна. 2015 оны эхний 10 сарын байдлаар Орон нутгийн төсвийн байгууллагуудад 10.4 тэрбум төгрөгийн зардал, улсын төсвөөс тусгай шилжих эрхээр боловсролын салбар буюу сургууль, цэцэрлэгүүдэд 36.5 тэрбум, биеийн тамир спортын салбарт 136.1 сая, Соёлын төвд 120.6 сая, эрүүл мэндийн салбарт 3.3 тэрбум төгрөгийн зардал тус тус гарсан байна. 2015 оны 10 дугаар сарын байдлаар улсын төсвийн байгууллагууд 1.0 тэрбум төгрөгийн төсвөөс төлөгдөх өртэй байна. Улс, нийслэл, дүүргийн татварын орлогын тасалдал, эдийн засгийн хүндрэлтэй байдалтай уялдуулан байгууллагуудын төсөв зарцуулах эрхийг Сангийн яамнаас хязгаарлалттай өгч байгаа, мөн санхүүжилт 7 сараас эхлэн сар бүр 5-10 хувиар буурч орж ирж байгаагаас үүдэн төсвийн байгууллагууд төсвөөс төлөгдөх өглөгтэй ажиллаж байна. Цаашид тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигддэг байгууллагууд болон орон нутгийн байгууллагуудын төсвийг бууруулж тодотгол хийх замаар төсвийн өрийг арилган ажиллахаар тооцоо судалгаа хийж байна.	90.0

33		Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнуудад орлогын төлөв-лөгөө хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана.	Торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтны судалгааг холбогдох байгууллагуудаас авахад нийт торгох эрхтэй улсын байцаагч 106 ажиллаж байна. Хүү торгуулийн орлогод 2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 600,9 сая төгрөг төвлөрүүлэн ажиллахаар байна.	90.0
34		Хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн сан байгуулж, дүүргийн ойрын болон дунд хугацааны төлөвлөлтөд тусган ажиллана.	Дүүргийн хэмжээнд 2013-2015 онуудад улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалт гарган мэдээллийн сан үүсгэн ажилласан. Үүнд: улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 93,0 тэрбум төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 103,9 тэрбум төгрөг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 5,0 тэрбум төгрөг, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,4 тэрбум, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн дүн мэдээтэй байна. 2013-2015 онуудад хийгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг хороо тус бүрээр гаргаж мэдээллийн сан үүсгэсэн. Төр захиргааны байгууллага 80, сургууль, цэцэрлэг 6, СӨХ 8, нийт 94 байгууллагаас хөрөнгө оруулалтын ажлын санал хүлээн авч мэдээллийн сан үүсгэн ойрын болон хэтийн төлөвлөлтөнд ашиглаж байна. Уг хөрөнгө оруулалтын ажлын санал дээр үндэслэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2016 оны хөрөнгө оруулалтын ажлын санал, дүүргийн нутаг дэвсгэрт 2016-2020 онуудад улс, нийслэл, бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 18 ажлын саналыг нэгтгэн гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Улс, нийслэлээс 3.7 тэрбум төгрөгийн 22 ажлын эрх шилжиж ирсний 15 ажлын /зам/ тендерийг зарлан, замын ажил бүрэн хийгдэж дууссан. 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 нэр төрлийн 8,1 тэрбум, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 нэр төрлийн 11,7 тэрбум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 19 нэр төрлийн 710.0 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2531.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 51 ажил, нийт 23.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.	90.0

35	1.2.2. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, цаашдаа төсвөөс авах татаасыг бууруулах чиглэлд бодлогыг уялдуулна.	“Дүүргийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/43 дугаар захирамжаар дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын орлогч Ганаагаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Мандах нягтлан бодох дээд сургуулийн эрдэмтэн багшийг оруулан суурь судалгааны ажил хийгдсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 3 удаа хуралдаж дүүргийн ИТХ-н дэргэд байгуулагдсан ижил чиг үүрэгтэй ажлын хэсэгтэй хамтран боловсруулахаар ажиллаж байна.	30.0
36	1.2.3. Төсвийн болон Татварын хууль тогтоомжийг сурталчлах, байгууллага, иргэнийг татварт бүрэн хамруулах, татварын хяналт шалгалтын үр	Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил төлбөрт тогтоосон актыг барагдуулах, шаардлагатай тохиолдолд энэ талаар олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулна.	2014 оны жилийн эцсийн өр барагдуулах ажлын хүрээнд Хяналт шалгалтын тасаг өр барагдуулахаар өрийн насжилтын судалгааг шинэчлэн гаргаж, эрчимжүүлсэн ажлын төлөвлөгөөг гарган ажилласан. 2015 онд шалгалтанд 344 аж ахуйн нэгж хамрагдаж 1,1 тэрбум төгрөгийн төлбөр тавигдсан. Үүнээс 707,3 сая төгрөгийг барагдуулаж, хүү торгуульд 349,5 сая төгрөгний акт тавигдсанаас 242,5 сая төгрөгийг барагдуулсан болно. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль батлагдсантай холбоотойгоор татварын хяналт шалгалтын ажил түр хугацаагаар зогссон байна.	90.0
37	нөлөөг дээшлүүлэх, өр барагдуулах менежментийг боловсронгуй болгоно.	Татварын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, татварт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авна.	Татвар төлөгчдийг төлөвшүүлэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтууд зохион байгууллаа - 2015 оны 03-р сарын 31-ний өдөр Драгон худалдааны төвд зохион байгуулагдсан "Үйлдвэр, худалдаа эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн"-ий үеэр 220 гаруй татвар төлөгчдөд цахим тайлангийн мэдээллийн системд нэвтрэх, тоон гарын үсэг авах, тайлан илгээх, хүсэлт гаргах, хуулийн хугацаа эхлүүлэх талаар хичээл зааж, татвар төлөгчдийн сонирхсон асуултад зөвлөгөө өглөө. -Татвар төлөгчдийг төлөвшүүлэх, татварын хуулийг сурталчлан таниулах зорилгоор хэрэгжүүлж буй Инновацийн хөтөлбөрийн хүрээнд 2015 онд шинээр Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон Цахим тайлангийн систем	90.0

			<p>сэдэвт сургалтыг сар бүрийн 5-ны өдөр зохион байгуулж хэвшин нийт 4 удаагийн сургалт зохион байгууллаа.</p> <p>-2015 онд шинээр албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Цахим тайлангийн систем" сэдэвт сургалтыг сар бүрийн 10-ны өдөр зохион байгуулж хэвшин нийт 4 удаагийн сургалт зохионбайгууллаа.</p> <p>-Мэргэшсэн нягтлан бодогчдын институттай хамтран Япон улсын 23 мэргэжилтнүүдэд "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг хэрхэн бүртгэх" талаар сургалтыг 2015 оны 03-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Сургалтанд мэргэжилтнүүдээс гадна их дээд сургуулийн багш нар хамрагдан харилцан санал солилцож, тэдний сонирхсон асуутанд хариулт өглөө.</p> <p>-Татварын ерөнхий газартай хамтран татварын тайлангаа хоцроосон, татварын албанаас тайлан нь буцаагдсан татвар төлөгчдөд зориулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар 210 татвар төлөгчийг сургалтанд хамрууллаа. Татвар төлөгчдийн өдрүүдээр дүүргийн 32 хорооны Иргэний танхимаар дамжуулан "Иргэдээ сонсьё" сургалтууд зохион байгуулж 920 гаруй татвар төлөгчдийг хамран тэдний гаргасан санал хүсэлтийг ил захидалаар хүлээн авч нэгтгэн Нийслэлийн Татварын Газарт хүлээлгэн өгч санал бодлоо солилцлоо. 2015 оны 06 сарын 20-нд "Иргэдийн баяр"-аар АТБӨЯХАТ хураах ажил зохион байгуулж 38 иргэн хамрагдаж 3.0 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлэн ажилласан.</p>	
38		<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн томоохон зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдийг татварт бүрэн хамруулна.</p>	<p>Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх, тэдгээрийн хяналтыг сайжруулах үүднээс Эмээлт, Хангай зах, Шөнийн зах, Драгон зах, Эгүшин, Жанцан, Сувдан худалдааны төвүүдэд 2015 оны 3-р сараас 11-р сарын 25 хүртэл татварт хамрагдаагүй иргэдийг татварт хамруулах ажлыг зохион байгуулж ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд 144 иргэнээс 21989,0 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.</p>	90.0

39	1.2.4. Аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан тушаалт, тендерийн сонгон шалгаруулалт, үр дүн зэрэгт хүний оролцоог багасгаж, 100 хувь цахим тогтолцоог нэвтрүүлнэ.	Байгууллага, аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан гаргах, мэдээлэх ажлыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ.	Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулж 7687 тайлан хүлээн авч, түүнээс 93.5 хувь буюу 7184 тайланг баталгаажуулсан. 2015 оны 1,2,3-р улирлын тайланг цахим хэлбэрээр хүлээн авч, тайлан тушаалт дунджаар 85.9 хувьтай байна. Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн дагуу дүүргийн харъяа аж ахуйн нэгж байгууллагуудын шинэчлэн гаргаж буй тайланг чирэгдэлгүй хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	90.0
40		Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, шударга зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг худалдан авах ажиллагааны талаар мэдлэг, мэдээллээр хангаж ажиллана.	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа худалдан авах ажиллагааны ил, тод, нээлттэй байдлын хангах үүднээс дүүргийн www.shd.mn сайт, Засгийн газрын худалдан авах ажиллагааны газрын e-procurement.mof.gov.mn сайт, Өдөр тутмын сонин болох Үндэсний Шуудан сонинд худалдан авах ажиллагааны урилга, явцын талаар нийтлэн ажилласан. 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг 400 ширхэг, 2014 оны ажлын тайланг 2000 ширхгийг хэвлүүлэх хороод, Нээлттэй хаалганы өдрөөр иргэдэд сурталчилж ажилласан. Мөн “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа” зөвлөгөөн зохион байгуулж, 45 аж ахуй нэгж байгууллагын 66 төлөөлөгч оролцож худалдан авах ажиллагааны талаар санал солилцож ажилласан. “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан ба 45 Иргэний бүлгийн 61 иргэнтэй 2015 онд хэрэгжүүлэх ОНОХАА-д анхаарах зүйлс, шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлтийг хэрхэн бүрдүүлэх болон Иргэний бүлгүүдийн гаргадаг нийтлэг алдааг сануулан ажилласан.	100.0
41		Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлнэ.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт ажлын 20 хувьтай тэнцэхүйц хэмжээний ажлыг цахим худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулан ажилласан. Тендерийн баримт бичгийг боловсруулан захиалагчаар батлуулах ба батлуулсан баримт бичгийг CD-нд хуулбарлан оролцогч компаниудад тарааж ажилласан.	90.0
42		Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, ажлын явц, үр дүнг 100 хувь	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа худалдан авах ажиллагааг ил, тод, нээлттэй байдлын хангах үүднээс дүүргийн www.shd.mn сайт, Засгийн газрын худалдан авах	100.0

		цахим хэлбэрээр мэдээлж ажиллана.	ажиллагааны газрын e-procurement.mof.gov.mn сайт, өдөр тутмын сонин болох Үндэсний Шуудан сонинд худалдан авах ажиллагааны урилга, явцын талаар хэвлүүлэн, шилэн данс.mn сайтад оруулан ажиллаж байна.	
43	1.2.5. Орон нутгийг хөгжүүлэх сангийн орлогыг нэмэгдүүлэх менежментийг боловсронгуй болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжинэ.	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын явцад хяналт тавьж, ажлын явц, үр дүнг иргэд олон нийтэд тогтмол мэдээлнэ.	Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны А/32, А/58 дугаар тогтоол, Засаг даргын Б/07 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд улс, нийслэл, дүүргийн төсөв, зээл, тусламж, төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд болон дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг тооцох, техникийн нөхцөл авах, ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, захиалагчийн хяналтыг мэргэжлийн чиг үүргээр хэрэгжүүлэх, өдөр тутмын инженерийн хяналт тавих, улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэн ажиллах чиг үүрэг бүхий ОНӨААТҮГ Захиалагчийн албыг 9 хүртэлх хүний орон тоотойгоор байгуулсан. 2015 оны 11 дугаар сарын 27-ны байдлаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 2 тэрбум 339.0 сая төгрөгийн төсөвтэй 48 ажил, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 452 сая төгрөгийн төсөвтэй 3 ажил нийт 2 тэрбум 791.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 ажилд инженерийн хяналт тавин ажилласнаас 37 ажлыг ашиглалтанд хүлээж авч, 25 ажил он дамжин хийгдэхээр гэрээ сунгасан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай Засаг даргын А/11 дүгээр захирамжийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган дүүргийн цахим хуудас болон мэдээллийн самбараар иргэдэд сурталчилсан. Хөрөнгө оруулалтын ажлын явцын талаар мэдээ, мэдээллийг дүүргийн болон Захиалагчийн албаны цахим хуудасаар тогтмол мэдээлсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажлын жагсаалтад өөрчлөлт оруулах болон дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын задаргааны санал боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн А/44 дүгээр тогтоолоор батлуулж дүүргийн Засаг даргын А/118, А/199 захирамжаар хөрөнгө оруулалтын ажлын өөрчлөлт, задаргааг батлан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу	100.0

			зохион байгуулсан. Хэрэгжиж дууссан 2197.4 сая төгрөгийн төсөв бүхий 44 хэрэгжиж дууссан, 629.1 сая төгрөгийн төсөв бүхий 11 ажил дуусах шатанд, 385.8 сая төгрөгийн төсөв бүхий 10 ажил гэрээ байгуулсан, 754.2 сая төгрөгийн төсөв бүхий 15 ажлын гүйцэтгэгч тодрхой шалтгааны улмаас шалгараагүй байна.	
44		Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хийх хөрөнгө оруулалтын ажилд иргэдийн саналыг авч, орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан нэгдсэн жагсаалт боловсруулна.	Урьд онуудад хийгдсэн ажлын мэдээлэл бүхий 77.2 мянган ширхэг саналын хуудас хэвлүүлэн өрх бүрт тарааж 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал асуулга зохион байгуулсан. Хороодын Засаг дарга нарт Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн төсөл боловсруулах журам”-ын талаар зөвлөгөө өгч, санал асуулга зохион байгуулах заавар, зөвлөмж бүхий гарын авлага боловсруулан тараасан. Дүүргийн хэмжээнд нийт 42150 иргэнээс 205 төрлийн ажилд 257482 санал ирүүлснийг дүүргийн Засаг даргын А/106 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг хороо тус бүрээр нягтлан шалгаж дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулан зөвлөмж гарган хороодын ИНХ-аар хэлэлцүүлсэн. Хороодын ИНХ-аар хэлэлцэн батлан ирүүлсэн төсөл арга хэмжээний саналыг нэгтгэж 6,400.0 сая төгрөгийн өртөг бүхий 156 ажлын нэгдсэн жагсаалт боловсруулсан. Нэгдсэн жагсаалтыг нийслэлийн ЗДТГ, ЕТГ-т тус тус хүргүүлэн зөвшилцсөн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 32-р хуралдаанаар дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд 3.2 тэрбум төгрөг хуваарилсны дагуу 2016 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт боловсруулан дүүргийн ИТХ-д өргөн барих бэлтгэл ханган ажиллаж байна. Санал асуулгын явцад төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын талаар 57704 иргэдээс судалгаа авахад 43383 иргэн буюу 78.2 хувь нь дүүрэг, хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг хангалттай гэж, 37025 иргэн буюу 68.1 хувь нь урьд жилүүдэд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудтай өгсөн санал нийцэж байна гэж, 35881 иргэн буюу 62.2 хувь нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын чанарыг хангалттай гэж тус тус үнэлсэн байна.	100.0

45		Дүүргийн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулах замаар олон нийтийн оролцоог хангаж ажиллана.	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажлаас иргэдийн бүлгээр хийлгүүлэх 14 ажлын жагсаалтыг гарган, хамтран ажиллах гэрээний маягтыг шинэчлэн боловсруулж Тамгын газрын даргын 03/212 тоот албан бичгээр хороодод хүргүүлсэн. Тайлант хугацаанд иргэдийн бүлгийг бүртгэх талаар 108 иргэнд заавар, зөвлөгөө өгч, нийт 74 иргэдийн бүлгийг бүртгэж цахим хуудсанд байршуулаад байна. Дүүргийн Худалдан авах ажиллагааны албатай хамтран 5-р сарын 7-ны өдөр Иргэний танхимд 45 бүлгийг 61 иргэнийг хамруулан “Чанартай хөрөнгө оруулалт-олон нийтийн оролцоо” сэдэвт сургалт зохион байгуулав. Сургалтаар олон нийтийн оролцооны эрх зүйн үндэс болон 2015 онд олон нийтийн оролцоотойгоор хийгдэх ажлуудыг танилцуулж, 2014 онд тохижилтын ажил хийсэн 2 иргэний бүлэг туршлагаа хуваалцлаа. Дүүргийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулан гүйцэтгэгчийг шалгаруулж, ажлын явцад Захиалагчийн албанаас хяналт тавин, ашиглалтад хүлээн авсан ба санхүүжилтийг бүрэн олгосон. Олон нийтийн оролцоотой дээрх ажлын хүрээнд 74 иргэнийг түр ажлын байраар ханган орлогожуулсан дүнтэй байна.	100.0
46	1.2.6. Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн болон газрын гэсэн ангиллаар явуулж, нийслэлийн өмчийн харилцааны газар, үл хөдлөх	Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын үр дүнг баталгаажуулж, бүртгэлгүй болон хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг цаг тухайд нь бүртгэлжүүлнэ.	Засаг даргын Тамгын газрын 2015 оны 5-р сарын 20 өдрийн А/42 дүгээр тушаалаар ЗДТГ-ын 39.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хагас жилийн үзлэг тооллогоор тоолж 124.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр бүртгэлд авсан байна. Тамгын газрын даргын А/65 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан жилийн эцсийн тооллогын ажлыг эхлүүлээд байна. 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 3-р улирлын байдлаар 383.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 5.0 сая төгрөгийн хангамжийн материалыг бүртгэлжүүлээд байна.	100.0
47	хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулна.	Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	Нийслэлийн хэмжээнд 2016 онд хийгдэхээр хойшилсон	-

Хоёр. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.				
2.1 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлыг бууруулах талаар				
48	2.1.1. Хороодын хөдөлмөрийн цахим биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.	Хороо бүрт цахим биржийн үйл ажиллагааг тогтмолжуулан, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн иргэдэд сурталчилж ажиллана.	Ажлын байрны мэдээллийг онлайнаар дамжуулах (Е-биржийн киоск) машинуудыг Засаг даргын Тамгын газрын байранд 2, хороодод 27, татварын хэлтэст 1, хөдөлмөрийн хэлтэст 1 тус тус байршуулан ажиллуулж байна. Нийт 31 машин ажиллуулж, иргэдэд 10 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Ажлын байр, боловсон хүчин, гадаадаас ажиллах хүчин авч ажиллуулах, мэргэжлийн боловсрол сургалт, хөдөлмөрийн хувийн биржүүдийн мэдээлэл, БНСУ-д ажиллах хүсэлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл, цахим биржүүдийн байршлын талаар, Чөлөөт мэдээлэл зэрэг үйлчилгээг үзүүлж байна. 2015 оны байдлаар 4672 иргэн киоск машинаар үйлчлүүлж, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ мэдээллийг авсан Цахим бирж машины хэвийн ажиллагааг хангах, сүлжээнд холбох, мэдээлэл шинэчлэх, ажлуудыг тухай бүрт тогтмол гүйцэтгэж байна.	100.0
49		Хөдөлгөөнт биржийн үйл ажиллагааг сайжруулж ажил хайж байгаа иргэдийг ажлын байраар хангаж ажиллана.	“Ажилтай, Орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ажиллах хүчийг нэмэгдүүлэх, иргэдийг байнгын ажлын байртай болгох зорилгоор хороодын нутаг дэвсгэрт иргэдэд хүрч үйлчлэх хөдөлгөөнт биржүүдийг ажиллуулж байна. Хөдөлгөөнт биржийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр хуваарийн дагуу 26 хороонд ажиллуулж, нийт 1012 иргэнд зөвлөгөө мэдээллийн, 624 иргэнд ажлын байрны зуучлалын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Биржийн үйл ажиллагаанд дүүргийн ажил олгогч аж ахуй нэгж байгууллагуудыг татан оролцуулж нийт 15 аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажиллалаа.	100.0
50	2.1.2. Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэгцээний дарааллаар гарган ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжил	Хороонд хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг ажиллуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа, ажилгүй иргэдийн бүртгэлийг гаргаж, ажил зуучлалын	Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/12 дугаар тушаалын дагуу 2015 онд хороо хариуцсан 15 мэргэжилтэн ажиллуулж, нэг мэргэжилтэн 2 хороо хариуцан ажиллаж байна. Хороо хариуцсан хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр шинэчлэн батлагдсан төсөл хөтөлбөрүүд, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээ мэдээллийг хүргэж, ажилд орох хүсэлтэй иргэдийг сургалтанд хамруулах, ажлын байранд зуучлах үйлчилгээг үзүүлж байна. 2015 онд хөдөлмөр эрхлэх чадамжтай	100.0

	<p>олгох болон мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулан тэдгээрийн 60-аас доошгүй хувийг байнгын ажлын байраар хангана.</p>	<p>үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.</p>	<p>хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, хөдөлмөрийн салбарын хэрэглэгчдийн үнэлгээ, хөдөлмөр эрхлэх чадвартай ахмад настны судалгааг тус тус гаргасан. 2015 онд 6117 иргэн ажил хайж бүртгүүлснээс 3537 иргэнийг ажилд зуучилсан. Мэргэжлийн болон давтан сурах сургалтанд 461 хүн хамрагдсанаас оёдол эсгүүр, цэцэрлэгийн туслах багш, үсчин, худалдагч касс нярав, тогооч, гар урлалын чиглэлээр хамгийн их суралцсан байна.</p>	
51		<p>Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд сурталчлах, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх бүсчилсэн өдөрлөгүүдийг улирал бүр зохион байгуулж, ажил олгогч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж ажиллана.</p>	<p>2015 оны 3-р сарын 20-ны өдөр Иргэний танхимд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход ажил олгогч эздийн оролцоог нэмэгдүүлж, шинээр батлагдсан хөтөлбөрүүдийг танилцуулж, ажил олгогч байгууллагуудын хамтын ажиллагааг батжуулах, туршлага судалж, мэдээлэл солилцох өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгт ажил олгогч 78 аж ахуй нэгж байгууллагыг оролцуулж хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр шинээр батлагдсан хөтөлбөр төслүүдийн талаар танилцууллаа. Хөдөлмөрийн яамнаас 2015 оны 5-р сарын 01-ний өдөр МСҮТ төгсөгчдөд зориулан зохион байгуулсан “Эв санааны нэгдэл” өдөрлөгт оролцож нийт 250 гаруй иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч, ажлын байрны зуучлалын үйлчилгээ үзүүлсэн. 2015 оны 5-р сард хугацаат цэргийн алба халагдахтай холбогдон зохион байгуулсан өдөрлөг, хорихоос бусад ял шийтгэлтэй, бүртгэлтэй иргэдэд зориулсан уулзалт зөвлөгөөнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Мөн Хөдөлмөрийн сайдтай уулзах уулзалт зөвлөгөөн, Аж Үйлдвэрийн Яамнаас зохион байгуулсан “Иновацийн 7 хоног-2015” үзэсгэлэн яармаг худалдаанд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч 70 иргэнийг оролцуулж, үзэсгэлэн худалдаа гарган 10.3 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн борлуулсан. Ажил идэвхтэй хайж байгаа иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх, ажлын байранд зуучлах “АМЖИЛТЫН ГАРАА” өдөрлөгийг Силвер худалдааны төвд зохион байгууллаа. Өдөрлөгт 22 ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага нээлттэй ажлын байраа зарлан оролцож, ажил</p>	100.0

			идэвхтэй хайж байгаа 450 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2015 оны 6-р сард Драгон төвд “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн эсрэг” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт хөдөлмөр эрхлэгч насанд хүрээгүй 70 хүүхдийг эцэг эхчүүдийн хамт оролцуулж “Хүүхдэд аюултай ажил” сэдвээр 2 цагийн сургалт явууллаа. “Мэргэжлийн сургалт амжилтын үндэс” ур чадварын анхдугаар уралдаан, Хөдөлмөр-Хөгжлийн түлхүүр Намрын хөдөлмөрийн яармаг өдөрлөгт оролцож 143 иргэнийг ажилд зуучилж, 488 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	
52		Халамж, асрамжийн төвүүдэд хүмүүжсэн залуучууд, хорихоос суллагдсан иргэд, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэн, мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулж, түр болон байнгын ажлын байраар хангах төсөл хэрэгжүүлэх, хувиараа аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Нийслэлийн цагдаагийн газартай хамтран “Хүчирхийлэлгүй гэр бүлд таны оролцоо” өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгт хорихоос суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 85, архины хамааралтай 40 иргэнийг оролцуулж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг танилцуулан, ажил идэвхтэй хайгч 20 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамруулсан. УИХ-аас Өршөөл үзүүлэх тухай хууль батлан гаргаж хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан хорихоос суллагдсан 277 иргэний судалгааг гаргасан. 2015 оны 11-р сарын 09-ны өдөр Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэстэй хамтарч хорихоос суллагдсан иргэдийг хүлээн авч хөдөлмөр зуучлал, халамж үйлчилгээ, сэтгэлзүйн болон бусад үйлчилгээг хүргэсэн. Орон гэргүй 4 иргэнийг “Нийгэм хамгааллын тусгай төвд байршуулж, 8 иргэнийг ажилд зуучлан оруулсан.	100.0
53	2.1.3. Дүүргийн нутаг дэвсгэрт ажлын байр шинээр бий болгох асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, бичил бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөлийн 07 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2015 оны А/18, 23 дугаар тушаалуудаар төслүүдийн үйл ажиллагаагааг шалгах, сонгон шалгаруулах ажлын хэсгийг тус тус байгуулсан. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 547 иргэний төслөөс 123 төслийг шалгаруулж, 144.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Сар шинийн баярыг тохиолдуулан 2015 оны 01 дүгээр сарын 26 -аас 2 дугаар сарын 16-ны хооронд “Силвер” худалдааны төвд үзэсгэлэн	100.0

			<p>худалдаа зохион байгуулж санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 6 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлсэн. Дүүргийн иргэдийн баярт хувиараа хөдөлмөр эрхлэгч 16 иргэнийг оролцуулан үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлсэн. Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулах ажлыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, нийт 928 төсөл ирүүлсэнээс шалгуур хангасан 256 иргэн, жижиг бизнес эрхлэгчид дэмжлэг үзүүлсэн. Энэ ажлын хүрээнд 553 байнгын болон түр ажлын байр бий болсны 380 нь эмэгтэйчүүд байна. Жижиг зээлд хамрагдахыг хүссэн 70 иргэний төсөл холбогдох материалыг хүлээн авч төрийн банкинд тодорхойлолт гаргаж өгсөн. Үүнээс банкны шалгуур хангасан 54 иргэнтэй жижиг зээлийн гурвалсан гэрээ байгуулж 461 байнгын болон түр ажлын байр бий болгон 281,8 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг хадгалах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 311 төсөл ирүүлсэнээс 79 төслийг 78,0 сая төгрөгөөр санхүүжүүлж, 92 ажлын байр бий болсон.</p>	
54		<p>“Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил” хөтөлбөрийг хэрэгжүүлэн оюутны хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж ажлын байранд зуучлахад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>“Оюутны хөдөлмөр эрхлэлт цагийн ажил” хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр шинээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн талаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудад сурталчилж ажиллаа. Нийтийг хамарсан ажилд 183 оюутныг хамруулж, түр ажлын байраар хангалаа. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 07 дугаар тогтоолоор “Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” батлагдан хэрэгжиж байна. Хөтөлбөрийг МСҮТ төгсөгчид, ажил олгогч байгууллага, иргэдэд танилцуулах уулзалт арга хэмжээг 4 удаа зохион байгуулсан. Хөтөлбөрт хамрагдахаар нийт 8 бүлэг төсөл ирүүлснээс үйлдвэрлэлийн 5 төслийг дэмжиж нийт 23.0 сая төгрөгийн дэмжлэгийг олгоод байна. Дэмжлэг авсан бүлгүүдийн нийт 25 залуу байнгын ажлын байраар хангагдаж орлого олох боломжтой болсон байна. Тус хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид мэргэжил эзэмшиж төгссөн 195 иргэний судалгааг гаргаж 12 иргэнийг байнгын ажлын байранд,</p>	100.0

			100 иргэн түр ажлын байраар хангагдсан.	
55	2.1.4. Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, нийгмийн эмзэг бүлгийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн амьдрах орчноо сайжруулан нөхөн сэргээх, ногоон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс санаачлан ирүүлсэн төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2015 оны А/16, А/24 дүгээр тушаалуудаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийн үндэслэлийг шалгах, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийг тус тус байгуулж, иргэдээс ирүүлсэн 310 төслөөс 79 төслийг шалгаруулан, 78.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулж, 92 ажлын байр шинээр бий болсон. Үүнээс 42 нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. “Хотжилтын орчинд настны оролцоо ба тогтвортой байдал” өдөрлөгт оролцож 78 ахмад болон иргэдэд зөвөлгөө мэдээлэл өгч, 28 иргэнийг мэдэгдэх хуудсаар ажилд зуучилж ажилласан. Мөн Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 56 иргэнийг хамруулахаар төслийг нь хүлээж авсан.	100.0
56		Зорилтот бүлгийн иргэдийг төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулна.	БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Самдун интернейшнел” төрийн бус байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу тус төрийн бус байгууллагын мэргэжлийн сургалтын төвд амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийг барилгын чиглэлээр үнэ төлбөргүй мэргэжил эзэмшүүлж, ажлын байранд зуучилж байна. Мэргэжлийн сургалтын төв нь 3 сарын хугацаанд иргэдийг үнэ төлбөргүй сургаж, барилгын засал чимэглэлчин, гагнуурчин, бетон арматурчин, өрлөг угсралтын чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулж байна. 2015 онд тус сургалтын төвд 2 ээлжээр 120 иргэн үнэ төлбөргүй суралцаж мэргэжил эзэмшсэн. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвөөс явуулсан мэргэжлийн сургалтын төвийн эрх олгох тендерт дүүргийн харьяа “Бизнес т хөтлөх харгуй”, “Сонгинохайрхан дүүргийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв”, “Оюуны язгуур” сургалтын байгууллагууд шалгарсан. Тус 3 сургалтын төв нь Бизнесээ хөгжүүлэх аргачлал, Нягтлан бодох бүртгэл, борлуулалтын сүлжээг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулан тухайн сургалтын байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд, аж ахуй эрхлэлтийг дэмжих	100.0

			хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан 160 иргэнийг суралцуулахаар болоод байна.	
57	2.1.5. Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн ажилтнуудын	Хөдөлмөр эрхлэх чадвартай ахмад настны судалгааг гарган, холбогдох ажлуудыг зохион байгуулна.	“Ахмад мэргэжилтнүүдийн үндэсний сүлжээ, бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг байгуулж тэднийг зөвлөгөө өгөх, гэрээгээр, түр хугацаагаар ажиллуулах хөтөлбөр”-ийн хүрээнд ажил хийх хүсэл сонирхолтой, чадвартай ахмад настнуудын судалгааг гаргасан. Судалгаанд ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хөдөө аж ахуйн салбарын 29, эрүүл мэндийн салбарын 22, боловсролын салбарын 54, соёл урлагийн салбарын 5, цагдаа хүчний байгууллагын 24, техник технологийн салбарын 35, барилгын салбарын 22, бусад салбарын 210, нийт 401 ахмад хамрагдаж, мэдээллийн санд бүртгэгдсэн. Бүртгэгдсэн ахмадуудын мэдээллийг нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржийн бүртгэлд оруулсан.	90.0
58	ажлын арга барилыг шинэчлэж, нийгмийн халамж шаардлагатай өрх иргэдэд хүрч үйлчилнэ.	Зорилтот бүлгийн өрх, иргэнийг нийгэмшүүлэн хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болоход чиглүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулж, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	Дэлхийн зөн олон улсын байгууллагын Толгойт болон Баянхошуу орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж өрхийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэн 9 иргэнд олон улсын байгууллагаас 8.0 сая төгрөгийн зээл олгосон. 2, 3, 26-р хорооны 7 өрхийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрууллаа. “Өрхийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хороодод хадгаламж зээлийн хоршоод байгуулагдаж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 266 иргэний төслийг дэмжиж, 850.0 сая төгрөгийн зээл олгоод байна.	90.0
59		Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран бага орлоготой 700–аас доошгүй өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран “Төгсөлтийн аргачлал 36-сар” төслийг хэрэгжүүлж Толгойт, Баянхошуу бүсийн эмзэг бүлгийн 700 өрхийг сонгон авч амьжиргааг нь дээшлүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд хамруулж байна. 700 өрхийн дунд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн судалгаа, ажилгүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрүүл мэндийн даатгалгүй иргэд, хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан иргэд, өрх тус бүрт өрхийн хэрэгцээний судалгааг тус тус хийж нэгдсэн судалгаа гаргасан. Судалгааг үндэслэн төсөлд хамрагдсан 700 өрхөөс 124	100.0

			<p>өрхөд хүнсний эрхийн бичиг олгож, ХОЛТ олон улсын байгууллагын төсөлд 123 өрхийг хамруулан, өрх тус бүрт 30-40.0 мянган төгрөгийн дэмжлэгийг сар бүр олгуулж байна. “Оюун санааны эргэлт” ТББ-ын нарийн ногоо тарих сургалтанд төсөлд хамрагдсан 32 эмэгтэйг үнэ төлбөргүй сургаж, дүүргийн Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран гар урлалын сургалтанд 30 иргэн, хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалтанд 60 өрхийг сургаж өрх тус бүрт 240.0 мянган төгрөгийн үнэ бүхий хүлэмж, аж ахуй эрхлэх багаж хэрэгсэл олгож дэмжлэг үзүүлсэн. Төсөлд хамрагдсан 2 өрхөд олон улсын байгууллагын дэмжлэгээр гэр олгоод байна.</p>	
60	<p>Нийгмийн халамжийн үйлчилгээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоо түншлэлийг нэмэгдүүлэх, төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот бүлгийн иргэдийг хамруулна.</p>	<p>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийт 184 иргэн хамрагдаж халамжийн сангаас 27,0 сая төгрөг зарцуулагдсан. Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газартай гэрээ байгуулсан “Өөрчлөгдсөн амьдрал”, “Ерөөгдсөн гэр бүл” ТББ-аар дамжуулан тэнэмэл болон хүчирхийлэлд өртсөн иргэдийг нийгэмшүүлэх, түр хоноглуулж хооллож ундлах үйлчилгээ үзүүлсэн. Нийт 180 иргэн тус үйлчилгээнд хамрагдсан. 2015 оны 03 сарын 01-нд НХҮЕГ-аас олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэдэг төрийн бус байгууллага аж ахуй нэгжүүдийн талаар зөвлөмж ирсний дагуу түр хоноглуулж, хооллож ундлах үйлчилгээг түр зогсоогоод байна. Засаг даргын 2015 оны А/440 дүгээр захирамжийн дагуу Цагдаагийн хэлтсүүд, “Эгэл амьдралын мөр” ТББ, Нийгэм хамгааллын тусгай төвтэй хамтран тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 84 иргэнийг нийгмийн үйлчилгээнд хамруулсан.</p>	100.0	
61	<p>Аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллана.</p>	<p>2015 онд аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Монгол тусгал залуусын нэгдэл ТББ, Натул эмнэлэг, Өөрчлөгдсөн амьдрал ТББ, Ерөөгдсөн гэр бүл ТББ, Койкагийн сургалтанд оролцогчдын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Койкагийн сургалтанд оролцогчдын холбоо, Комекс Монголия нийгэмлэг, Монгол тусгал залуусын нэгдэл төрийн бус байгууллагуудтай хамтарч амьжиргааны түвшнээс доогуур орлоготой зорилтот бүлгийн 250 өрхөд тус бүр 25.0 мянган төгрөгийн хоол хүнс, хувцас хэрэглэлийн тусламж</p>	100.0	

			<p>үзүүлсэн. ХОЛТ олон улсын байгууллага нь сар бүр олон хүүхэдтэй, нэн ядуу 186 өрхөд 30-40.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж үзүүлж нийт 26,0 сая төгрөгийн тусламж үзүүлээд байна. “НАТУЛ” хувийн эмнэлэгт хүсэлт гаргаж хамтран ажилласнаар 35 өрх толгойлсон эмэгтэй, 180 ахмад настныг үнэ төлбөргүй үзлэг шинжилгээнд хамруулаад байна. 2015 онд онцгой тохиолдлын амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1,2 сая төгрөгийг нийт 164 иргэнд олгож, төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр эмзэг бүлгийн 39 өрхөд гэр олгосон.</p>	
62	<p>2.1.6. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар ажил зохион байгуулж, тэтгэврийн даатгалыг нөхөн авах иргэдэд мэдээлэл өгч хамруулна.</p>	<p>Иргэдэд нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчлан, сайн дурын нийгмийн даатгалд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.</p>	<p>Дүүргийн 17182 иргэнд сайн дурын даатгалын үйлчилгээг үзүүлж, сайн дурын даатгалын санд 3893,9 сая төгрөг хуримтлуулж, шинээр 3721 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан. Нийгмийн даатгалын тухай хуулийг сурталчилах, сайн дурын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх үүднээс дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг томоохон худалдааны төвүүд болон ажил олгогч байгууллагуудад сургалт сурталчилгааг хийж, нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу иргэдэд зөвлөгөө өгч, гарын авлага тараасан. 2015 оны 3-р сард ерөнхий боловсролын Ирээдүй цогцолбор сургуулиас зохион байгуулсан өдөрлөгөөр Нийгмийн даатгал болон иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг сурталчилж 250 сурагчийг эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулж, сургуулийн багш ажилчдад ЭМД, Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн талаар зөвлөгөө өгсөн. Мөн 21-р хороонд нийгмийн даатгалын байцаагч нар ажиллан “Ажилласан жил нөхөн тооцуулсан” 20 иргэнд батламжийн хуудас олгож, ажилласан жилээ нөхөн тооцуулахаар ирсэн 6 иргэний материалыг хүлээн авч, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 2, эрүүл мэндийн даатгалд 8 иргэнийг тус тус хамруулсан. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2015 оны 07-р сарын 01-нээс хэрэгжиж эхлэх хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээ мэдээллийг олон нийтийн хэвлэлээр мэдээллэж ажилласан. Аж ахуйн нэгжүүдийн захирал нягтлан бодогчийн хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ ухамсарлаж, хуулийн хүрээнд ажиллах, өр авлага гаргахгүй ажиллах үүднээс ажил олгогчдын захирал, нягтлан бодогчдод 10,</p>	100.0

			11 дүгээр саруудад сургалт зохион байгууллаа. Нийгмийн даатгалын тухай хууль, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгал, ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар 72 хүнд мэдээлэл, зөвлөгөө өгч нийт 198 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 11-р сарын 11, 13-ний өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон худалдааны төвийн түрээслэгчдэд болон үйлчлүүлэгчдэд нийгмийн даатгалын тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, түүний ач холбогдлыг сурталчилах ажлыг зохион байгуулсан. Нийт 15 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулж, 120 хүнд сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын талаарх гарын авлагуудыг тарааж, 63 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна.	
63		Нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч байгууллагуудын жагсаалт, судалгааг Татварын хэлтэстэй хамтран гаргаж нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.	Татварын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 2158 аж ахуй нэгж байгууллагын судалгааг гаргаж нийгмийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулан ажилласан. 2158 ажил олгогч байгууллагын судалгааг нийгмийн даатгалын мэдээллийн баазтай тулган шалгаж 400 аж ахуйн нэгж байгууллага нийгмийн даатгалд бүртгэлгүй байсныг тогтоосон. Тус байгууллагуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж татварт бүртгэлтэй боловч нийгмийн даатгалд бүртгэлгүй 411.5 сая төгрөг бүхий цалингийн сантай 1231 даатгуулагч бүхий 68 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж нийгмийн даатгалын санд 86,4 сая төгрөг төвлөрүүлсэн. Нийгмийн даатгалын хэлтсээс 2015 онд шинээр бүртгүүлсэн 919.6 сая төгрөгийн цалингийн сантай 1907 даатгуулагчтай 450 аж ахуйн нэгжийг НД-д хамруулж тайлан тооцоог хүлээн авч ажилласан байна.	100.0
2.2 Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр				
64	2.2.1. Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгож,	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг сайжруулах зорилгоор сайн дурын	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна. 2015 онд 1154 удаагийн сургалтыг “Осол гэмтэл”, “Архи тамхины хор уршиг”, “Сэтгэл гутрал	100.0

	<p>өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж материаллаг баазыг нэмэгдүүлнэ.</p>	<p>идэвхтэнүүдийг сонгон сургалтанд хамруулж, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллуулж сар бүр ажлын үр дүнгээр урамшуулал олгоно.</p>	<p>ба стресс”, “БЗДХ”, “Томуу”, “Сүрьеэ”, “Хавдар”, “Амны хөндийн эрүүл мэнд” зэрэг 26 сэдвээр зохион байгуулж 94150 иргэнийг хамрууллаа. Сургалтын мэдээллийг оруулсан 29 төрлийн брошур, сурталчилгааны материал шинээр боловсруулж, давхардсан тоогоор 252170 иргэнд тараасан ба 23 өдөрлөг 8 аяны хүрээнд 95500 иргэдэд мэдээлэл, сурталчилгааг хүргэсэн. “Хүүхэд бол маргаашийг гэрэлтүүлэхээр өнөөдөр мандаж буй наран билээ” өсвөр үеийн сургагч багш бэлтгэх сургалтыг Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг, “Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээ”, Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын дэмжлэгтэйгээр дүүргийн өсвөр үеийн танхимын оролцоотойгоор зохион байгуулж 36 өсвөрийн сургагч багшийг бэлтгэж, сургуулиудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудыг явуулж байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан сурталчилгааны материалыг /брошур/ 6000 хувь хэвлэн тарааж, амны хөндийн эрүүл ахуй видео сургалт, шүд угаах арга сургалтанд 6780 сурагчийг хамруулсан. НҮБ-ийн Хабитат /UN habitat/ төсөлтэй хамтран 10 хороог сонгон, “Иргэдийн оролцоотойгоор хүн амын эрүүл мэндийг дэмжих” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох “Хүн амын эрүүл мэндийг сайжруулахад олон нийтийн оролцоог хангах” сэдвээр 1, 9, 22, 30, 31 дүгээр хороодын 500 иргэнд сургалт зохион байгуулж хэрэгцээ, бэрхшээлээ тодорхойлон төлөвлөгөө гаргалаа. Мөн эрүүл мэндийн боловсролыг дэмжих сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтанд 30, эрүүл мэндийн мэдлэг дээшлүүлэх сургалтанд 1000 иргэнийг хамруулсан.</p>	
65		<p>Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр /ЭХО аппарат-3, зүрхний ЭХО-1, ходоодны дуран-1, рентген аппарат-2, зүрх судасны эмгэгийн оношлогооны аппарат/ хангах асуудлыг холбогдох</p>	<p>Эрүүл мэнд, Спортын яам, төсөл, хандивлагч байгууллагуудын хөрөнгө оруулалтаар нийт 98.5 сая төгрөгийн өртөг бүхий Гематологийн анализатор, Термостат, Хатаах шүүгээ, Центрфуг, Шээсний анализатор, Микроскоп, Зөөврийн ЭХО, 5 функцтай ор, өвчтөний монитор зэргийг нийлүүлснийг тасаг кабинет, амбулаториудад эмчилгээнд хэрэглэж байна. Эрүүл мэндийн байгууллагыг дэмжих, холбогдох машин, техник тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг Эрүүл мэнд, спортын яаманд, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмнэлгийн оношлогооны багаж,</p>	100.0

		байгууллагуудад уламжилна.	тоног төхөөрөмжийн судалгааг хийж, “Жишиг Өрхийн эрүүл мэндийн төв” байгуулах хүсэлтийг Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр төсөлд тус тус хүргүүлээ.	
66		Иргэдийн дунд зонхилон тохиолдох бэлгийн замын халдвар, сүрьеэ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хүн амын 20%-иос доошгүй хувийг хамруулна.	2015 онд 15 төрлийн цочмог халдварт өвчний 5376 тохиолдол /10,0 мян хүн амд 187.598%/ илэрсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4404 тохиолдол буюу 151%-иар өссөн үзүүлэлттэй. Энэ нь улаанбурхан өвчний дэгдэлттэй холбоотой нэмэгдсэн байна. Вируст гепатит нийт цочмог халдварт өвчний 3.1%-ийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 0.01%-иар өссөн үзүүлэлттэй. Хүн амын дундах вируст гепатитын шаргүй далд хэлбэрийг илрүүлэх үзлэгт хамрагдвал зохих 150630 иргэнээс 56320 иргэнийг хамруулж, сэжигтэй илэрсэн 563 хүнийг эрүүлжүүлж ажилласан. Мөн 16 сургуулийн 31101 сурагчдад Вируст гепатитын шаргүй далд хэлбэрийг илрүүлэх үзлэг, 26903 хүүхэд назофарингит илрүүлэх үзлэг хийсэн бөгөөд 1873 томуу, томуу төст өвчин, 16 гахай хавдар, 38 салхинцэцэг илрүүлж, эрүүлжүүлээ. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг 17 сургуулийн 22610 хүүхэд, 16 цэцэрлэгийн 4629 хүүхдийг хамруулан зохион байгуулж, өвчтэй илэрсэн 2567 хүүхэд эрүүлжсэн байна. 27 аж ахуйн нэгж, албан байгууллагуудад БЗДХ/ХДХВ/ДОХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж 1539 иргэнийг хамруулан, 105 хүн өвчтэй илэрснийг эрүүлжүүлээ. Амьдрах ухаан төвд амьдардаг 48 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсанаас 15 тэмбүү илэрснийг эрүүлжүүлээд байна. 2015 оны 3-р сарын 24-ны өдөр “Сүрьеэгүй Сонгинохайрханчуудын төлөө хамтдаа” нөлөөллийн жагсаалыг 800 хүн хамруулан зохион байгууллаа. Дэлхийн Зөн Герман Олон Улсын байгууллагатай хамтран “Өрхийн амьжиргааг сайжруулж, сүрьеэ өвчлөлийг бууруулах нь” хөтөлбөрийг 2015 оны 7-р сараас хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү ажлын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулж, 2, 26-р хороодын 300 өрхөд ядуурлын түвшний судалгаа, үнэлгээг хийж 100 өрхийг хөтөлбөрт хамрууллаа. Сүрьеэгийн өвчлөл өндөр хороодын эмзэг бүлгийн хүн амын дунд сүрьеэ болон БЗДХ-ыг эрт илрүүлэх идэвхтэй үзлэгийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сүрьеэгийн тандалт судалгааны алба, Дэлхийн Эрүүл мэндийн	100.0

			байгууллагатай хамтран зохион байгуулж 400 иргэн хамрууллаа.	
67		3-р амбулаторийн дулааны шугамын засварын ажлыг хийлгэх талаар зохих байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.	3-р амбулаторийн дулааны шугамын засварын ажлыг хийлгэх, хөрөнгийг шийдвэрлүүлэхээр зохих байгууллагад хүсэлт хүргүүлснээр 2016 онд хийгдэхээр төсөвт тусгагдсан.	70.0
68		Эрүүл мэндийн төвийн барилгыг засварлах ажилд дэмжлэг үзүүлнэ.	Эрүүл мэндийн төв болон салбар амбулаторийн байруудад 681.5 сая төгрөгөөр засварын ажлыг хийсэн. Засварын ажилд улсын төсвөөс 545.0 сая, байгууллагын төсвөөс 3.2 сая, гадны хөрөнгө оруулалтаар 133.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.	100.0
69		Агаар, хөрсний бохирдлыг бууруулах сэдвээр иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулан түгээнэ.	Эй Си Эф Олон улсын байгууллагатай хамтран “Усны аюулгүй байдал” сургалт, танилцуулгыг 32 хорооны Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, нийгмийн ажилтнуудын дунд зохион байгуулсан. Сургалтын үеэр усыг зөв хэрэглэх талаар сурталчилгааны материал 1000 ширхэгийг тараалаа. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” стратегийн хүрээнд 5 дахь стратеги зорилт буюу “Орчны эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах” ажлын хүрээнд Толгойт бүсийн 5, Баянхошуу бүсийн 5 хороонд усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Эрүүл мэнд, Спортын Яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран “Усны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” үнэлгээний ажлыг хийж, 10 хорооны нийгмийн ажилтнуудтай хэлэлцүүлэг зохион байгууллаа. 2015 оны 3-р сард “Усны өдөр”-ийг тэмдэглэн 41 сайн дурын идэвхтэн, 89 иргэнд усны аюулгүй хэрэглээний талаар сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажиллаа. Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагатай хамтран Толгойт, Баянхошуу бүсийн 350 өрхөд сургалт хийж, 100 өрхөд эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газар, бохирын цооног барих материалын дэмжлэг үзүүлж, 6000 сурталчилгааны материалыг тараасан.	100.0
70		Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөрийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад	Засаг дарга, Тамгын газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ” хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлэхээр 6 стратеги зорилтоо тодорхойлон 2015 оны 1-р сард “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ	100.0

		төрийн, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	СТРАТЕГИ"-ийг албан ёсоор үзэглэлээ. “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх нь” хөтөлбөрийн 6 стратеги зорилтын хүрээнд 2015 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: “Өсвөр насны хүүхдийг эрүүлжүүлэх”, “Халдварт бус өвчний эрт илрүүлгийн аян”-ууд, “Зумба фитнес”, “Архи, тамхины хор хөнөөл” сургалтууд, “Сонгинохайрхан дүүргийн төлөө хамтдаа” нөлөөллийн жагсаал зэрэг 20 арга хэмжээг зохион байгуулж 10000 иргэнийг хамруулсан. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл тамхи, архинаас гаргах, эрүүл зөв хооллолтыг дэмжих тухай “Видео” хичээлийг боловсруулж, олон нийтэд сурталчиллаа.	
71		Эрүүл мэндийн төвийн 2 дугаар амбулаторийн барилгын газрын асуудлыг шийдвэрлэнэ.	Газрын асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудад саналыг уламжилсан.	10.0
72		“Эрүүл хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	“Эрүүл хүн” дэд хөтөлбөрийн 2015 оны хэрэгжилт 100%-тай байна.	100.0
73	2.2.2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт 45-аас дээш насны иргэдийн 50-с доошгүй хувийг хамруулж , өвчлөлийн судалгааг гарган тэргүүлэх байр эзэлж байгаа 3 өвчлөлөөс сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн хүн амыг хамруулах зорилгоор “Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг”-ийг 2 удаа зохион байгууллаа. Үзлэгт зорилтот бүлгийн 10398 хүнээс давхардсан тоогоор 15474 иргэн буюу 69.5 хувь нь хамрагдлаа. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад артерийн гипертензитэй, чихрийн шижин, умайн хүзүүний өмөн тэргүүлэх байр эзэлсэн. Халдварт бус өвчинд нөлөөлөх гол хүчин зүйл болох архи, тамхины хор хөнөөлийг сурталчилах ажлын хүрээнд 8 удаагийн сургалтанд 157 иргэнийг хамруулан, сурталчилгааг 5560 иргэнд хүргэсэн. Тамхины хор хөнөөл, тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа сэдвүүдээр 620 сурагч, 300 оюутан, 150 иргэн, 92 аж ахуй нэгжид сургалт явууллаа. Тамхинаас гаргах, зөвлөгөө өгөх 98254999 дугаарын итгэлт утсыг 8-р сарын 1- ээс ажиллуулж эхлээд байна.	100.0

74		Элэгний хавдар, чихрийн шижин өвчнүүдийн эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулж эмчилгээний үр дүнг сайжруулах, шаардлагатай эм, багаж хэрэгслэлээр хангах ажилд дэмжлэг үзүүлнэ.	Зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн 138 мэдээлэл, сургалт, сурталчилгааг хавдар, архи тамхины хэрэглээ, ХБӨ, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, чихрийн шижин, артерийн даралт, эмчилгээний хоол зэрэг сэдвээр 3600 хүн хамруулан зохион байгуулж, 32.000 хүнд сурталчилгаа хийлээ. Зөв зохистой хооллолт, дасгал хөдөлгөөн, осол гэмтлээс сэргийлэх талаар 5 өдөрлөг зохион байгуулж 1200 хүн хамруулав. 2015 оны 5-р сард дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадна талбайд “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт хоол, шим тэжээлийн өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд зөв зохистой хооллолтын талаар сургалт сурталчилгаа явуулан, биеийн найрлага тодорхойлох, цусны даралт хэмжих, захын цусан дах сахар тодорхойлох шинжилгээ хийж ажиллалаа. Өдөрлөгт 470 хүн оролцлоо. Дүүргийн төрийн албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд 180 албан хаагчийг элэгний В, С вирус үзэх шинжилгээнд хамрууллаа. Эрүүл мэндийн төв, БНСУ-ын ВИТ /WITH/ төрийн бус байгууллагын төлөөлөгчидтэй хамтран “Зохистой хоол- Эрүүл мэнд” өдөрлөгийг Нийслэлийн хэмжээнд 2015 оны 10 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулсан.	100.0
75		Элэгний В,С вирусын маркер болон хурдавчилсан оношлуураар Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хангах саналыг зохих байгууллагад уламжлан ажиллана.	Элэгний В,С вирусын маркер болон хурдавчилсан оношлуураар Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хангаж ажиллаж байна.	100.0
76		Осол гэмтлээс сэргийлэх талаар мэдээлэл, сургалт сурталчил-гааны ажлыг зохион байгуулж, бага насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулна.	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аяныг Засаг даргын 2015 оны А/21 дүгээр захирамжаар зохион байгуулж, Дэлхийн зөн ОУБ, Улаан загалмай зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төв болон Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хороодтой хамтран 60 гаруй удаагийн сургалтыг 10.000 гаруй иргэдэд зохион байгуулж хүүхдийн осол эндэгдлийн талаарх мэдээллийг хүргэн ажилласан. 31-р хороо, ДЗОУБ, ОБХ-тэй хамтран “Хүүхдийг осол гэмтлээс сэргийлье” телевизийн шторкийг бэлтгэн фасебүүкээр болон телевизээр сурталчилан ажиллаж байна. Осол гэмтэл /хүүхдийн түлэгдэлт, халтиргаа, зам	100.0

			тээврийн осол/-ээс сэргийлэх, архи, тамхинаас гаргах зөвлөгөө өгөх, зөв хооллолт, дасгал хөдөлгөөний ач холбогдол сэдвээр видео сурталчилгааны киног ДЭМБ-ийн санхүүжилтээр бэлтгэж байна. “Эцэг эхчүүд, цэцэрлэг, сургуулийн багш нарт хүүхдийг болзошгүй ахуйн болон бусад осол гэмтлээс сэргийлэх нь” сургалтыг зохион байгуулж, гарын авлага, санамж түгээн ажиллалаа.	
77	Ерөнхий боловсролын сургуулийн болон эрсдэлт бүлгийн охидод хүсээгүй жирэмслэлтээс хамгаалах талаар мэдлэг, дадал олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Дүүргийн өсвөр үеийн кабинетаар 2015 онд 10436 өсвөр насны хүүхэд, залуучууд үзүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч, урьдчилан сэргийлэх үзлэгт 8398 хүүхэд хамрагдсан. Тус кабинетаар 17 удаагийн сургалтаар 2190 хүүхдэд мэдээлэл хүргэлээ. Охидын эрүүл мэндийг хамгаалах “Гэр бүл төлөвлөлт”, “Охидын шивнээ”, “Зөвхөн охидод” зэрэг өдөрлөгүүдийг зохион байгуулж 3945 охидыг хамруулж, гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах аргуудын талаар сурталчилгаа хийлээ. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар “Хайр бидний амьдралд”, “Хүсээгүй жирэмслэлт”, “Үр хөндөлт” зэрэг сэдвээр лекц уншиж, 18 нас хүрэхийн өмнөх бэлгийн харьцаанд орж буй шалтгаан нөхцөлийн талаархи ярилцлага хийж, тулгамдаж буй асуудлаар судалгаа гаргаад байна. Ерөнхий боловсролын сургуулийн 11-18 насны хүүхдүүдийн дунд “Өсвөр насны хүүхдүүдийг эрүүлжүүлэх 8 сарын аян”-ыг ДЗОУБ, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, өсвөр үеийн кабинеттай хамтран зохион байгууллаа. Үзлэгт 17794 хүүхэд хамрагдахаас 17178 хүүхэд хамрагдаж, хамралт 96,5%-тай байна. Эрүүл мэндийн танхимаар 85 удаа 680 хүүхдэд архи тамхины хор хөнөөл, дэлгэцийн донтолт, охидын эрүүл ахуй зэрэг сэдвүүдээр сургалт явуулаад байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд архи, тамхи, мансуурлын хор уршгаас сэргийлье сэдвээр “АХА” тэмцээн, “Хорт зуршлаас сэргийлье” сэдвээр гар зургийн уралдааныг тус тус зохион байгууллаа.	100.0	
78	“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	Зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааг нийт хавдар, архи тамхины хэрэглээ, ХБӨ, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, чихрийн шижин, артерийн даралт, эмчилгээний хоол зэрэг 138 сургалтанд 3600 гаруй хүнийг хамруулж, 12500 гаруй гарын авлага, материал тараан 32000 орчим	100.0	

			хүнд сурталчилгаа хийгээд байна. Өдөрлөгүүдийн үеэр иргэдийн цусан дах сахар, цусны даралт үзэж зөвлөгөө өглөө. Хоол шим тэжээлийн төвөөс зохистой хооллолт, цусны даралт ихсэх өвчлөл, чихрийн шижин таргалалт зэрэг сэдвүүдээр нийт 23 удаагийн сургалт явуулж 483 хүн хамруулсан. Нарийн мэргэжлийн кабинетуудаар үйлчлүүлж буй 8000 гаруй үйлчлүүлэгчид амьдралын хэв маягаа өөрчлөх талаар зөвлөгөө өгч, санамж, зөвлөмж тараан ажиллаж байна.2015 оны 10-р сард Нийслэлийн Эрүүл мэндийн газарт “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаарх уулзалт, зөвлөгөөнд оролцож дүүрэгт хийгдэж байгаа ажлыг танилцууллаа. Хөтөлбөрийн хэрэгжилт 100% тай байна.	
79	Дүүргийн эрэгтэйчүүдийн дундах өвчлөл, эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа хийж, холбогдох арга хэмжээ зохион байгуулна.	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн суурь судалгааг өмнөх оны судалгаанд үндэслэн гаргалаа. Нийт нас баралтын 55.6% нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд нас баралтын тэргүүлэх шалтгаанууд нь осол гэмтэл, хоол боловсруулах замын эмгэг, хавдар байна. Нийт эрэгтэйчүүдийн 82.1% нь тамхи татдаг, 85% нь архи уудаг байна. Үзлэгийн байдлаар нь авч үзвэл халдварт өвчин, мэдрэлийн гаралтай өвчлөлүүд, амьсгалын тогтолцооны өвчлөлүүд эмэгтэйчүүдийг бодоход харьцангуй бага буюу нийт өвчлөлийн 10 - 26% эзэлж байна. Өвчлөлийн байдлаар авч үзвэл осол гэмтэл, амьсгалын замын эмгэг үүнд хатгалгаа, сүрьеэ, БЗДХ, Сэтгэц, хоол боловсруулах замын өвчлөл, хавдраар өвчлөх нь эрэгтэйчүүдэд илүү байгаа нь ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, архи тамхины хэрэглээ, хорт зуршил, БЗДХ, эрчүүд ба гэр бүл төлөвлөлт зэрэг сэдвээр нийт 7 удаагийн сургалтыг зохион байгуулж 420 гаруй эрчүүдийг хамрууллаа. “Эрчүүдийн эрүүл мэнд” бүсчилсэн сургалтыг мөн зохион байгуулсан. Сургалтын үеэр архи тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл, бэлгийн боловсрол, артерийн даралт ихсэх өвчин, зөв зохистой хооллолт, дасгал хөдөлгөөн гэсэн сэдвүүдээр зөвлөгөө өгч 3 төрлийн мэдээлэл бүхий сурталчилгааны хуудас түгээн ажиллаа.	100.0	

80		Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, өрх, иргэнийг шалгаруулах, сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулна.	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар шалгаруулахаар 4 байгууллагын тайлан, 5 өрх, 5 иргэний материалыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн боловч төсөв хүндрэлтэй байгаа тул 2015 онд шалгаруулалт явагдаагүй.	70.0
81	2.2.3. Цахим бүртгэлийг хэрэгжүүлэн, хүн амд чирэгдэлгүй, товлोलт үйлчилгээг нэвтрүүлнэ.	Цахим бүртгэлийг сайжруулахад шаардлагатай компьютерээр амбулаторуудыг хангах ажлыг холбогдох газруудад уламжилж, шийдвэрлүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.	Цахим бүртгэлийг сайжруулахад шаардлагатай компьютерээр амбулаториудыг болон эмч нарыг хангаснаар эмч нарын үзлэг, шинжилгээний бүртгэлийг цахим санд шилжүүлж, салбар амбулаториуд 49 кабинетийн үзлэгийг цахимаар бүртгэн давхардсан тоогоор 500 мянган иргэнд үйлчлээд байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс салбар төвүүд рүү цаг авах тогтолцоог хэрэгжүүлснээр 17964 хүнд үзлэгийн дугаар тараан үйлчилсэн байна.	100.0
82		Программ болон техник хангамж, сүлжээг сайжруулж, интернетийн орчин бий болгоно.	Эрүүл мэндийн төв нийт 17 төрлийн программ хангамж ашиглаж байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа программ хангамжийн талаарх судалгааг хийж, нарийн мэргэжлийн эмч нарын 53.8% нь цахимд холбогдон эмчилгээ, үйлчилгээгээ үзүүлж байна. 2015 онд салбар 3 төвийг камержуулж, мэдээллийн электрон самбар, хурлын теле төхөөрөмж суурилуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.	100.0
83		Амбулаториудыг автомат дугаар тараагч машинаар хангана.	Өрхийн эрүүл мэндийн төвөөс дүүргийн ЭМТ болон салбар амбулаториуд руу цаг авах тогтолцоог хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт хүн амд үзлэгийн дугаар тараан үйлчилж байна.	70.0
84	2.2.4. Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	Өрхийн, гэмтлийн, мэс заслын болон сургууль, цэцэрлэгийн эмч нарыг чадваржуулах сургалтыг “Осол гэмтлээс сэргийлэх нь” сэдвээр зохион байгуулж, зөвлөгөө, тусламжийн үйл ажиллагааг нэмэгдүүлнэ.	Өрх, гэмтэл, мэс засал, нарийн мэргэжлийн эмч нарт “Осол гэмтлээс сэргийлэх нь” сэдвээр сургалт 2 удаа, амилуулах суурь тусламж сэдвээр /багц цагийн/ 2 сургалт зохион байгууллаа. Мэс заслын кабинетээр 555, гэмтлийн цэвэр боолтын кабинетээр 4099, бохир боолтын кабинетээр 2403 иргэд үйлчлүүлж, 54733 удаагийн үзлэг хийлээ.	100.0
85		Эмч, сувилагч нарыг мэргэшүүлэх, ажлын байран дах болон давтан сургалтад хамруулан туршлага	Эрүүл мэндийн байгууллагын 2215 /давхардсан тоогоор/ эмч, сувилагч, ажилтнуудыг ажлын байранд мэргэшүүлэх, чадваржуулах, ур чадварыг нэмэгдүүлэх 71 удаагийн сургалтанд хамрууллаа. Үүнд:	100.0

		судлуулах ажлыг зохион байгуулна.	<p>-ОХУ-ын Петербург хотын Хүүхдийн халдварт өвчин судлалын эрдэм шинжилгээний институтэд “Хүүхдийг халдварт өвчний үеийн эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах нь” сургалтанд нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч</p> <p>-Москва хотод зохион байгуулагдсан “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, сэхээн амьдруулах” сургалтад 1 эмч</p> <p>-“БАГИЙН АМЖИЛТ–МИНИЙ АЖЛААС “ сэдэвт удирдах ажилтны сургалтад Эрүүл мэндийн төвийн 25 удирдах ажилтан</p> <p>-БНСУ-ын Чейл, Янжи, Гэгээн Мария, Чунь-Ань Их сургуулийн эмнэлэгүүдэд Эрүүл мэндийн төвийн 50 эмч</p> <p>-Японы Токио хотын эмнэлэгт Эрүүл мэндийн төвийн 1 сувилагч</p> <p>-Ургийн хөгжлийн гажигийн зарим биомаркер ба хэт авиан шинжилгээгээр эрт үед оношлох сургалтанд эмэгтэйчүүдийн 4 эмч, ЭХО-ны 1 эмч</p> <p>-“Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ” сургалтанд Өрхийн эрүүл мэндийн төвийн 50 эмч, сувилагч</p> <p>-Эрчүүдийн эрүүл мэнд ба сэтгэлзүйн тусламж үйлчилгээ сургалтанд 60 эмч</p> <p>-Эмнэлгийн яаралтай тусламжийн сургалтанд 60 эмч</p> <p>-Оновчтой сувилгаа сургалтанд 40 сувилагч тус тус хамрагдаад байна.</p> <p>Мэргэжил дээшлүүлэх /резедэнтийн/ сургалтанд төрийн сангаар 5, байгууллагын зардлаар 4, нийт 9 эмчийг сургаж байна.</p>	
86	2.2.5. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийн хөгжил-4” төслийн хүрээнд дүүргийн жишиг эмнэлэг байгуулна.	Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар баригдах “Жишиг эмнэлэг”-ийн барилгын ажлыг эхлүүлэхэд дүүргийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжих “Жишиг эмнэлэг” барих ажил нь нийт 37,0 сая долларын өртөгтэй бөгөөд барилгад 22,0 сая, тоног төхөөрөмж, боловсон хүчний асуудалд 15,0 сая долларыг зарцуулахаар төлөвлөгдсөн. “Жишиг эмнэлэг”-ийн барилгын ажлын зураг, архитектурын даалгаврыг Галландын “Симэд” компани гүйцэтгэж, Солонгос улсын “Жүнгли” компани зургийг хийж ЭМСЯ-нд хүлээлгэн өглөө. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 113 дугаар тогтоолоор барилгын хөрөнгийг бүртгэлээс хасаж, Нийслэлийн Засаг даргын А/786 дугаар захирамж, Нийслэлийн Өмч газрын харилцааны газрын даргын А/503 дугаар тушаалаар газрын асуудлыг тус тус шийдвэрлэж 2016 оны 4-р сараас барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.	100.0

			Боловсон хүчнийг бэлтгэх ажлын хүрээнд “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл”-өөс “Олон нийтийн онооны карт” аргачлалаар эмнэлгийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх судалгааны ажлыг 2015 оны 4-р сард зохион байгууллаа. Судалгаанд 32 хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нар болон Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчид нийт 500 гаруй хүн хамрагдаж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг гаргалаа.	
87	2.2.6. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэн бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлэн олон нийтэд сурталчилна.	Спорт цогцолборын барилгын ажлыг дуусгах нэмэлт санхүүжилт 319.0 сая төгрөгний хөрөнгөөр Боорчи ХХК нь том заалны ханын цонх, сан техникийн угсралт, уурын зуух, цахилгааны под станцыг барьж дуусгаад байна. Спорт цогцолборыг 2015 оны 12-р сарын 30-нд ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	90.0
88		Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан, иргэдийн усан спортоор хичээллэх боломжийг бүрдүүлж, баг, тамирчдыг уралдаан тэмцээнүүдэд оролцуулна.	Усан спорт сургалтын төвийн тамирчид 2015 онд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын 5-р их наадам, Өсвөр үе идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн, “Улсын аварга” шалгаруулах тэмцээнд, “Залуучуудын дэлхийн аварга” шалгаруулах тэмцээнүүдэд тус тус оролцож, 5 алт, 4 мөнгө, 12 хүрэл медаль хүртсэн амжилтуудыг үзүүллээ. 2015 онд нийт 2016 иргэн усан спортоор хичээллэж байна. Усан спорт сургалтын төвөөс төрийн албан хаагчдыг усан спортоор хичээллүүлэх зорилт тавин Нийслэлийн замын цагдаагийн газрын албан хаагчдын дунд 2015 оны 1-р сарын 17-ны өдөр “Усанд сэлэлтийн аварга” шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулаа. Усан спортын сургалтын төвийн үйл ажиллагааг сурталчилах өдөрлөг, уулзалт, сургалт 12 удаа зохион байгуулсан.	100.0
89		“Зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлж, хийн дасгал, Зумба фитнесийн багш бэлтгэн уралдаан тэмцээн зохион байгуулна.	Дүүргийн Эрүүл мэндийн төвд байрлах биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төвөөр 2015 онд 12026 хүн давхардсан тоогоор үйлчлүүлсэнээс эмчилгээний биеийн тамирын дасгалаар 2398, хийн дасгалаар 6390, хөдөлгөөн заслын эмчилгээнд 425, ажлын байрны дасгал хөдөлгөөнөөр 160, хэрэгсэлтэй дасгал болон аэробикоор 418 хүн тус тус хичээллэсэн байна. Дүүргийн Эрүүл мэндийн төв, БНСУ-ын WITH төрийн бус байгууллагатай хамтран “Зохистой хоол-Эрүүл мэнд” өдөрлөгийг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж эрүүл зөв хооллолтын кабинетуудын үйл ажиллагааг 200 гаруй	100.0

			иргэнд сурталчиллаа. Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2, 4, 6, 12, 13, 14, 16, 18, 19, 22, 23, 29-р хороодод нийтийн биеийн тамирын талбайг тохижуулж, тоног төхөөрөмжүүдийг суурилууллаа. Дасгал хөдөлгөөнийг дэмжих ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж /нийтийг хамарсан уралдаан тэмцээнүүдийг нийслэл, дүүргийн хэмжээнд 7 удаа зохион байгуулж нийт 768 иргэнийг хамрууллаа. Усан спорт сургалтын төвөөс төрийн албан хаагчдын хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, идэвхтэй зөв хооллолтыг дэмжих зорилгоор “Акуа фитнес”-ийн сургалтыг тусгайлан зохион байгуулж 25 албан хаагчийг хамруулаад байна.	
90	Хүүхдийн спортын наадам зохион байгуулна.	Дүүргийн Хүүхдийн спортын V их наадмын аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнийг спортын 17 төрлөөр /Тэшүүр, Ширээний теннис, Зуун буудалт даам, Тэшүүр, Жу-до бөх, Шатар, Чөлөөт бөх, Буудлага, Самбо бөх, Спорт бүжиг, Хөнгөн атлетик, Хөл бөмбөг, Сагсан бөмбөг, Уралдааны дугуй, Уулын дугуй, Олс таталт, Дөл тоглолт, Үндэсний бөх / зохион байгуулж, нийт 235 байгууллагын 3683 өсвөрийн тамирчид оролцож нийт 50 тамирчин шигшээ тэмцээнд оролцох эрх авч, 10 төрөлд өрсөлдөж 6 алт, 4 мөнгө, 7 хүрэл, нийт 17 медаль хүртэж, дүүргийн Спорт хороо шилдэг хороогоор шалгарсан. Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 179 тамирчин 16 тэмцээнд оролцож 19 алт, 34 мөнгө, 48 хүрэл, нийт 94 медаль хүртсэн байна.	100.0	
91	Засаг даргын нэрэмжит “999 өсвөрийн шатарчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль бүрт шатрын клуб ажиллуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/414 дүгээр захирамжаар “Их нүүдэл-999 өсвөрийн шатарчин” тэмцээнийг зохион байгуулж 16 байгууллагын 384 тамирчин оролцлоо. “999 өсвөрийн шатарчин” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад шатарын 10 клуб, 120 секц дугуйлан хичээллэж, 1600 хүүхэд хамрагдаж байна. Өсвөрийн шатарчин клубын тамирчин Б.Аззаяаг “Азийн аварга” шалгаруулах тэмцээнд оролцоход дүүргийн Засаг дарга замын зардлын /1.5 сая/ дэмжлэг үзүүлж, “Азийн аварга”-ын хошой мөнгөн медалийн эзэн боллоо.	100.0	

92		<p>Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, сурталчлах уралдаан, тэмцээнийг “Спортлог Сонгинохайрханчууд” уриан дор үе шаттай зохион байгуулна.</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2015 оны А/20 дугаар захирамжийн хүрээнд өвлийн спорт наадам, цасны баярыг “Цэнгэг агаар 2015” сэдвийн дор 2015 оны 1-р сарын 24-ны өдөр Хандгайтын аман дахь Янзага зусланд зохион байгууллаа. “Цэнгэг агаар-2015” сэдэвт цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн арга хэмжээнд дүүргийн 35 байгууллагын 1000 гаруй ажилтан, албан хаагчид оролцож спортын 4 төрлөөр хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Нийслэлийн “Цэнгэг агаар-2015” сэдэвт цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн нэгдсэн арга хэмжээнд Сонгинохайрхан дүүрэг “Аварга баг”-аар шалгарч Цом, өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд боллоо. 2015 оны 4-р сарын 11-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын дунд “Спорт наадам 2015” тэмцээнийг зохион байгууллаа. Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадын төрийн албан хаагчдын дунд уламжлалт “Спорт наадам” арга хэмжээг зохион байгууллаа. Тэмцээнд 20 байгууллагын 300 гаруй тамирчид хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдсөнөөс дүүргийн Татварын хэлтэс байгууллагын нэгдсэн дүнгээр тэргүүлж шилжин явах цомын эзэн боллоо. Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар Марафон 2015” цомыг дүүргийн Засаг даргын А/134 дүгээр захирамжаар хуваарь, үйл ажиллагааны чиглэлийг батлан байгууллагуудад хүргүүлэн, цомыг аялуулах ажлыг зохион байгуулсан. Найрсаг Улаанбаатар, Автомашингүй өдөр буюу 6 дугаар сарын 6-ны мягмар гаригт “Улаанбаатар марафон”-д 3000 гаруй тамирчинтайгаар оролцлоо. 2015 онд бүх нийтийн спорт өдөрлөгийг 47 удаа //Цэнгэг агаар-2015” спорт өдөрлөг, “Эрүүл агаар эм-2015” спорт өдөрлөг, Уран хөдөлгөөнт гимнастик /СӨББ/, “Багшийн алдар-2015”, Цэргийн алдар-2015, Уран хөдөлгөөнт гимнастик /ЕБС/, Арзобик, Хүн-Хөгжил-Хөдөлгөөн спорт наадам, Эрүүл мэндийн байгууллагын спорт наадам -2015, Нийслэл, дүүргүүдийн ЗДТГазрын албан хаагчдын тэмцээн, Залуу багш нарын тэмцээн, Багш шавь 12 дахь хавраа үдье, Засаг даргын дэргэдэх байгууллагуудын Спорт наадам-2015 спорт өдөрлөг, “Улаанбаатар Марафон-2015” Олон Улсын гүйлт, Сонирхогчдын</p>	100.0
----	--	--	--	-------

			насанд хүрэгчдын дүүргийн аварга шалгаруулах шатрын тэмцээн// зохион байгуулж, нийт 1506 байгууллагын 86580 хүнийг хамруулан ажилласан. Бие бялдрын түвшин тогтоох сорилыг 2015 оны 4-р сарын 10-наас 05-р сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулж 68 байгууллагын 49484 хүнээс сорил авч, программд оруулж, нийслэлийн хэмжээнд “Тэргүүн” байр эзэллээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмцээнийг 2 удаа /Суугаа волейбол, Пара жүдо/ зохион байгуулж, нийт 19 байгууллагын 129 тамирчныг хамрууллаа.	
2.3 Боловсролын талаар				
93	2.3.1. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэн хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг	Баруун салаанд баригдаж буй 640 хүүхдийн суудалтай ерөнхий боловсролын сургуулийн барилгыг ашиглалтад оруулах, 104-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх асуудлаар холбогдох арга хэмжээ авна.	-124-р сургуулийн барилгын ажлыг “Интеко ХХК” гүйцэтгэж байна. Гүйцэтгэгч компани өөрийн нөөцдөө тулгуурлан 2015 онд 2 удаагийн гүйцэтгэлээр нийт 1.0 тэрбум төгрөгийн ажил хүлээлгэн өгсөн. Ажлын явц 95.0 хувьтай бөгөөд 1 давхарын будаг, эмульс, плитаны ажлууд, спорт, урлаг заалны тааз, дотор заслын ажлууд үлдээд байна. Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээгүйгээс барилгын ажил зогсоход хүрээд байна. -Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх нийт 3.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 104-р сургуулийн 640 хүүхдийн барилгын ажилд 2015 онд 750.0 сая төгрөг батлагдсан. Барилгын ажлыг “Фүжи-Алтай” ХХК гүйцэтгэгчээр шалгарсан бөгөөд 2015 онд төлөвлөсөн ажлыг 100%, нийт ажлын 40.0 хувийг гүйцэтгээд байна.	90.0
94	мөрдүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	640 хүүхдийн суудалтай лаборатори сургууль, 25-р хорооны сургуулийн барилгын ажлыг эхлүүлэх асуудлаар холбогдох арга хэмжээ авна.	Лаборатори сургуулийн шинэ барилгад улсын төсвөөс 500,0 сая төгрөгийг батлуулсан боловч 2015 онд санхүүжилт хийгдээгүйн улмаас барилгын ажил эхлээгүй. 25-р хороонд бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын үндсэн барилгын ажил дууссан боловч уурын зуухны барилгын 500.0 сая төгрөгийн санхүүжилт хойшлогдсноос сургууль бүрэн ашиглалтад ороогүй. 500.0 сая төгрөгийг төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагад уламжилсан.	70.0
95		27, 29-р хороодод сургууль цэцэрлэгийн барилгын газрын асуудлыг холбогдох газруудад уламжилна.	27, 29-р хорооны нутаг дэвсгэрт сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга барих асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүссэн тухай албан бичгийг Нийслэлийн Засаг дарга, Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Боловсролын газар, Хөрөнгө оруулалтын газар, Нийслэл, дүүргийн Өмч, газрын харилцааны албанд	100.0

			хүргүүлсэн. Үүний дагуу 27-р хорооны Агарын гудамжны айлуудад нөхөн төлбөр олгох замаар сургууль, цэцэрлэгийн зориулалтаар газар чөлөөлөх боломжтойг тогтоосон.	
96		Сургууль, сургуулийн өргөтгөл бариулах шаардлагатай газруудын судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудад хандана.	Сургууль бариулах шаардлагатай 14 хороо, барилгын өргөтгөл хийх шаардлагатай /9, 62, 65, 67, 104, 107/ сургуулиудын судалгааг гаргаж Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн.	100.0
97	2.3.2. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах асуудлыг шийдвэрлэнэ.	4, 7-р хороодын цэцэрлэг, 19-р хорооны 26-р цэцэрлэгийн барилгын үйл ажиллагааг дуусгана.	4-р хорооны цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл 98.0 хувьтай явагдаж байна. 12-р сард улсын комисс хүлээн авч ашиглалтад орно. 7-р хороонд шинээр баригдсан 227 дугаар цэцэрлэгийн барилгыг улсын комисс хүлээн авч 2015 оны 11-р сараас үйл ажиллагаа эхэлсэн. 26 дугаар цэцэрлэгийн шинэ барилгыг 11 сард улсын комисс хүлээн авсан.	100.0
98		8, 20-р хороодод тус бүр 120 хүүхдийн ортой цэцэрлэг, 38, 91-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх асуудлаар холбогдох арга хэмжээ авна.	8-р хорооны 117 дугаар цэцэрлэгийн 120 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилгын ажил 11-р сард дуусч улсын комисс хүлээн авсан. 20-р хороонд баригдаж байгаа 228 дугаар цэцэрлэгийн барилга 2015 онд барилгын суурь болон 1, 2-р давхрын өрлөгийн ажил хийгдсэн. Энэ жил хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай бөгөөд нийт барилгын ажлын явц 50.0 хувьтай байна. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 38 дугаар цэцэрлэгийн барилгын зарим хэсгийг шинэчлэхээр зураг төсвийг хийсэн. Тус барилгад дахин акт тогтоолгохоор Мэргэжлийн хяналтын газарт холбогдох асуудлыг уламжилсан. 91-р цэцэрлэгийн өргөтгөлийн ажил 11-р сард дуусч, улсын комисст хүлээлгэн өгсөн.	100.0
99		1, 23, 26, 30, 31-р хороодод тус бүр 120 ортой цэцэрлэгийн барилга бариулах асуудлаар холбогдох байгууллагуудад уламжилна.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд цэцэрлэггүй 5 хорооны судалгааг хүргүүлж, 2016 оны нийслэлийн төсөвт цэцэрлэг бариулах тухай хүсэлтийг хүргүүлсэн.	90.0
100		9-р хорооны цэцэрлэгийн зориулалтаар барилга худалдаж авах асуудлаар холбогдох газруудад хандана.	“Түншлэл” бөөний худалдааны төвийн барилгыг худалдан авч цэцэрлэгийн зориулалтаар ашиглахаар 1.0 тэрбум төгрөгийн төсөв боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн.	100.0

101		Гэр цэцэрлэгийн салбар бүлэг байгуулж, хувилбарт сургалтыг зохион байгуулна.	БСШУЯ-ны сургуулийн өмнөх боловсрол төслийн хүрээнд 11 цэцэрлэгт 14 бүлгээр гэр цэцэрлэг ажиллаж байна. 2014-2015 оны хичээлийн жилд 61 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулсан бол 2015 онд 38 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулаад байна.	90.0
102	2.3.3.Сургууль, цэцэрлэгт эрүүл аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлнэ.	Сургууль, цэцэрлэгийн сургалтын гадаад, дотоод орчин сайжруулах зорилгоор шаардагдах хөрөнгө оруулалтын ажлуудыг үргэлжлүүлнэ.	Боловсролыг дэмжих олон улсын түншлэлийн Сургуулийн өмнөх Боловсрол төслийн хүрээнд 10 цэцэрлэгт /91, 113, 117, 125, 127, 156, 163, 170, 188, 192/ зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж, шкаф, ширээ сандал, гадна тоглоом зэрэг 1.4 тэрбум төгрөгийн, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Туркын хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /ТИКА/ төслийн хүрээнд 163-р цэцэрлэгт 14.4 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, 80-р цэцэрлэгт 40.0 сая төгрөгөөр гадна тоглоомын талбай байгуулсан.	100.0
103		Сургууль, цэцэрлэгүүдийн эрүүл аюулгүй орчин, нөхцлийг хангах зорилгоор гадна гэрэлтүүлэг, хяналтын камер, нэг хүүхдэд оногдох угаалтуур суултуурын тоог нэмэгдүүлнэ.	2014-2015 оны хичээлийн жилд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газартай хамтран зохион байгуулсан “Эрүүл аюулгүй байдлын индексийн хариу арга хэмжээ авах аргачлал” нэгдсэн сургалтанд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар хамрагдлаа. Төрийн өмчийн 16 сургууль гадна орчинд 90 гэрэлтүүлэг, 288 хяналтын камер, 37 цэцэрлэгт 114 гэрэлтүүлэг, 71 хяналтын камер суурилуулан ажиллуулсан. Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд Ирээдүй цогцолбор 1-р дунд сургуулийн ариун цэврийн өрөөнд засварын ажил хийгдсэн. Нийслэлийн 133,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1, 2-р ахлах сургуулиудын биеийн тамирын заалны дээвэр, дотор засал, шал, дотор гэрэлтүүлэг, хувцас солих өрөөнд засвар хийгдсэн.	100.0
104		"School police" ажлыг идэвхжүүлэн сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, сургууль орчмын аюулгүй орчин бүрдүүлэлтэнд хяналт тавьж ажиллана.	2014-2015 оны хичээлийн жилд 22 сургуулийн 23478 эцэг эх, 20000 сурагч, 1300 багш, ажилтнуудыг “school police”-оор ажиллуулсан. School police” төслийн хүрээнд 144 сургалт зохион байгуулсан. - Эргүүлээр урьдчилан сэргийлж, таслан зогсоосон зөрчил 333, гэмт хэргийн шинжтэй 16, захиргааны шинжтэй 7 зөрчлийг илрүүлж цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. 2015-2016 оны хичээлийн жилд Нийслэлийн боловсролын газраас "School police" ажиллах журам гаргасан. Энэ хичээлийн жилийн эхний 2 улирлын байдлаар 7200 эцэг эхээр эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгүүлж байна.	100.0

105		158-р цэцэрлэгийн дээвэр, 42-р сургуулийн спорт заалны засварын талаар холбогдох байгууллагуудад уламжилна.	158-р цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг 9-р сард улсын комисс хүлээн авсан. 42-р сургуулийн спорт заалны засварын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт уламжилсан.	100.0
106		Ирээдүй цогцолборын 2 дугаар дунд сургуульд уншлагын танхим байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Хөрөнгийн асуудлыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн.	50.0
107		Ахлах ангийн сурагчдын дунд хорт зуршлаас татгалзах сургалт, семинарын ажлыг идэвхижүүлнэ.	Ерөнхий боловсролын 16 сургууль ахлах ангийн 5500 сурагчдад “Тамхины хор хөнөөл”, “Мансууруулах бодисны донтолт” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтын дагуу нийгмийн ажилтнууд “School police” хамтран сургуулийн орчинд тамхи татсан сурагчдад биечлэн тамхины хор хөнөөлийн талаар зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.	100.0
108	2.3.4. Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх хоолны газрыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлж, баталгаатай хоол хүнсээр үйлчлэх бүх нөхцлийг бүрдүүлж үдийн цай хөтөлбөрийг чанаржуулна.	Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн байгууллага, эцэг эхийн хяналтыг тогтмолжуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх үзүүлэх сургалт, өдөрлөг зохион байгуулна.	2014-2015 оны хичээлийн жилд 20747 хүүхэд Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа бөгөөд тэдгээр хүүхдүүдийн эцэг эхчүүдийн дунд уламжлалт арга хэмжээ болох “Эцэг эхийн нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Өдөрлөгт 1325 эцэг эхчүүд хамрагдаж үдийн цайны амтлагаа, түгээлт, бүтээгдэхүүн хүлээн авалт болон боловсруулалттай танилцсан. 65-р сургууль, “Болор шоо” ХХК-г түшиглэн 22 сургуулийн 24 тогоочдын дунд үзүүлэх сургалт зохион байгуулсан. Үдийн цайг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, хувь хүмүүс суралцагчдад халуун хоолоор үйлчлэх цэсийг сар бүр гарган сургуулийн удирдлага, хяналтын зөвлөлөөр хянуулан, баталгаажуулах ажил хэвшээд байна. 2015 оны 9-р сард зохион байгуулагдсан “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний улсын 2 дугаар зөвлөгөөн”-д дүүргийн сургууль, цэцэрлэгийн 10 тогооч хамрагдаж, ур чадвараа дээшлүүлэн, харилцан туршлага судаллаа. 2015-2016 оны хичээлийн жилд нийслэлийн Захирагчийн ажлын алба, Боловсролын газар, Эрүүл мэндийн газартай хамтран баг бүрдүүлж 2015 оны 11-р сард сургуулийн цайны газар, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.	100.0
109	2.3.5. ЕБС-уудыг 12 жилийн сургалтын	Ерөнхий боловсролын сургуулийн бага, суурь боловсролд боловсролын	Ерөнхий боловсролын сургуулиудыг 2 бүсэд хувааж 2 лаборатори сургуулийн багш нараар 14 сургууль дээр хичээл заалгаж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. 2015 оны 3-р сард 3 бүсийн	100.0

	тогтолцоонд бүрэн шилжүүлж, бага, дунд боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.	шинэчлэлийг гүнзгийрүүлж, бага боловсролын "Цөм хөтөлбөр"-ийг түгээн дэлгэрүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	"Хүүхэд бүрийг хөгжүүлэх хичээл, үйл ажиллагааны туршлага солилцох улсын зөвлөгөөн" зохион байгуулав. Зөвлөгөөнд 13 аймаг, нийслэлийн 5 дүүргийн лаборатори сургуулийн захирал, сургалтын менежер, багш нар, нийт 300 гаруй хүн оролцсон. Зөвлөгөөний үйл ажиллагааг TV8, NTV, C1, ZA, Эх орон, NBS, EAGLE телевизүүдээр сурталчиллаа. Цөм хөтөлбөрийн хүрээнд дүүргийн ЕБС, цэцэрлэгийн нийт 14 багш Япон, БНХАУ-д мэдлэг боловсролоо дээшлүүлж, туршлага судалсан. 2015-2016 оны хичээлийн жилийн бэлтгэл хангах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын хөгжлийг дэмжиж "Багшийн манлайлал" сургалтыг 2015 оны 8-р сарын 19-26-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 108 багш хамрагдсан. Засаг даргын Тамгын газраас 8.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
110		Бага боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагатай хамтран аян зохион байгуулна.	Японы хүүхдийг ивээх сантай хамтран 4 /104, 122, 67, 107/ сургууль дээр 2015-2016 оны хичээлийн жилд "Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь" төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хичээлийн жилд 4 удаа сургалт семинар зохион байгуулж, сургалтад 20 багш, сургалтын менежер захирлууд, бага боловсролын мэргэжилтнүүд хамрагдлаа.	100.0
111	2.3.6. Ерөнхий боловсролын сургуулиудыг цахимжуулах, эцэг эх, багш, сурагчдад зориулсан	65, Ирээдүй 2-р ахлах сургуулийг цахимжуулж, сургалтын зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ.	Ирээдүй 2-р ахлах сургуулийн "Багш хөгжлийн танхим"-ыг тохижуулан сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, 72 багшийг компьютерын сургалтанд хамруулсан. 2015-2016 оны хичээлийн "Шинэ зууны боловсрол" төслийн хүрээнд Багш бүрийг компьютержүүлэх аян явагдаж Ирээдүй цогцолбор 2-р ахлах сургуульд нийт 80, 65-р сургуульд нийт 161 компьютер хуваарилагдсан.	100.0
112	мэдээллийн төвүүд, суралцагчдын амьдрах ухаан, харилцааны ур	Эцэг эх, багш, сурагчдад зориулсан мэдээллийн төвийг Толгойт бүсийн сургуулиудад байгуулна.	ДЗОУБ-тай хамтран Толгойт бүсийн сургууль тус бүрт мэдээллийн төвийг байгуулан сургуулиудын нийгмийн ажилтнуудын хамтарсан баг байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, эцэг эх, багш сурагчдад сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж хэвшээд байна.	90.0
113	чадвар, сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх	Ирээдүй цогцолбор 1-р ахлах сургуульд суралцагчдын амьдрах ухаан, харилцааны	"Ирээдүй цогцолбор" I ахлах сургууль дээр Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, "ROTORU" агентлагтай хамтран 19.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн "Номын гэр" танхимыг байгуулан үйл	100.0

	чадварыг бүрдүүлэх “book safe”-г байгуулна.	ур чадвар, сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх чадварыг бүрдүүлэх “book safe” байгуулна.	ажиллагаа нь тогтмолжсон.	
114	2.3.7. Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, мэргэжил арга зүйн	Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, багшлах боловсон хүчний чанарыг дээшлүүлж, үе шаттайгаар сургалтанд хамруулна.	Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багш нарыг чадавхжуулах зорилгоор 4 удаагийн шинэчилсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд давхардсан тоогоор 250 багш удирдлагууд хамрагдсан.	100.0
115	удирдлагаар хангана.	Төрийн бус цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2014-2015 оны хичээлийн жилд Төрийн бус өмчийн 44 цэцэрлэг 3089 хүүхэдтэй сургалт хүмүүжлийн ажил явуулж байгаа бөгөөд 2013-2014 оны хичээлийн жилтэй харьцуулахад 6 цэцэрлэг шинээр нэмэгдэж, сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо 423-аар нэмэгдсэн. Дүүргийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, дүүргийн хувийн хэвшлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын холбоо хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний дагуу 2015-2016 оны хичээлийн жилд хувийн 20 цэцэрлэгт 500 хүүхдийг хамруулаад байна.	100.0
116	2.3.8. Гэгээрэл хөгжлийн төвийг бие даасан ажлын байртай болгож, Гэгээрэл хөгжлийн	Албан бус-Насан туршийн боловсролын төвийн барилгын санхүүжилтийг холбогдох газруудад уламжилна.	Төвийн байр бариулах саналыг Засаг даргын 2015 оны 1/521 дугаартай албан бичгийг нийслэлийн Боловсролын газарт уламжилсан.	100.0
117	төвийн үйл ажиллагааг албан бус боловсролын үйлчилгээнээс иргэн бүрт хүрч үйлчлэх “Насан туршийн боловсролын төв” болгон өргөжүүлнэ.	Бичиг үсгийн анхан шатны сургалтад шинээр боловсрол нөхөн олгох сургалтын танхимыг хамран сургах тойргийг түшиглэн хичээллүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.	Насан туршийн боловсролын төвөөс 2015-2016 оны хичээлийн жилд төрийн өмчийн 67, 124 дүгээр сургуулиудад анги нээж 7, 8, 24-р хорооноос сургууль завсардсан хүүхдүүдийг албан бус боловсролд хамруулахаар ажиллаж байна. Хүн амын бичиг үсгийн боловсролыг нөхөн олгох, бичиг үсгийн хэрэглээний чадамжийг сайжруулах зорилгоор бичиг үсгийн сургалтанд 2014-2015 оны хичээлийн жилд нийт 21 иргэнийг хамруулсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 48 иргэнийг хамруулан суралцуулж байна. Үүнээс: 25 иргэнийг 240 цагийн анхан шатны сургалтанд, 23 хүүхдийг дараа шатны боловсрол нөхөн олгох сургалтанд анги дэвшүүлэн	100.0

			суралцуулсан. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 27 иргэн, хүүхэд багачуудаар ахисан байна.	
118		Насанд хүрэгчдийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах сургалтын танхимыг төрийн болон төрийн бус байгууллагыг түшиглэн нээх боломжийг бүрдүүлнэ.	“Харилцааны төв” төрийн бус байгууллагатай хамтарсан гэрээ байгуулснаар тус төвийн сургалтын танхимд “Соёл В” салбар ангийг шинээр нээж сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна. Иргэдэд өөрөө өөртөө ажлын байр бий болгох, өрхийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр 120 цагийн 45 хоногийн “Эсгий урлал” “Сүлжмэл”-ийн сургалтыг орон нутгийн 5, 7, 18 дугаар хороотой хамтран хорооны иргэний танхимд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан 80 иргэнийг хамруулав. Төвийн насанд хүрэгчдийн сургалтын танхимд 5, 18-р хорооны хүсэлтээр 9 хэсгийн ахлагч, 11 иргэнийг хамруулан 48 цагийн компьютерийн сургалтыг батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулж амжилттай төгсгөв. Төвийн төлөвлөгөөт сургалтаар 50 удаа 1830 иргэнд /давхардсан тоогоор/, хамтарсан төлөвлөгөөт сургалтыг 2 удаа 1977 иргэнд, захиалгат сургалтыг /Амьдрах ухааны чадвар олгох”, “Ёс суртахуун төлөвшил-Харилцаа”/ 2-р хороо, 110-р цэцэрлэг, 55-р цэцэрлэгийн нийт 152 иргэнд, 5,7-р хорооны 35 иргэнд “Төсөл бичих арга зүй” сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан. 7-р хорооны 12 иргэнд англи хэлний 40 цагийн сургалт, 3-р хорооны 14 иргэнд монгол бичгийн 48 цагийн сургалт, иргэдийн бичиг үсгийн хэрэглээний чадамжийг сайжруулах сургалт 25 иргэнд тус тус зохион байгуулж байна.	100.0
119		Дүйцсэн болон насанд хүрэгчдийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, сайжруулах шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Төвийг 18.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангасан.	100.0
2.4 Соёл урлагийн чиглэлээр				
120	2.4.1. Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.	Соёлтой өрх, хороог шалгаруулан сурталчилна.	Засаг даргын А/115 дугаар захирамжаар шилдэг тохижилттой хороо, өрх, орон сууцны байр, гэр хорооллын гудамж болзолт уралдааныг зарлаж, 2015 оны 10-р сард шалгарууллаа. Үүнд: Шилдэг тохижилттой хороогоор : 25, 29, 9-р хороо, Шилдэг тохижилттой өрхөөр: 32, 25, 7-р хорооны иргэд	100.0

			Шилдэг тохижилттой орон сууцны байраар: Тохилог-21, Итгэл-1, Кремль СӨХ, Шилдэг тохижилттой гэр хорооллын гудамжаар: 25-р хорооны Хайрханы 9, 9-р хорооны Малчны 2-р гудамж тус тус шалгарлаа.	
121	Утга соёлын өв тээгч иргэдийг олон нийтэд сурталчлан таниулж, алдаршуулах, тэмцээн уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлнэ.		2015 онд 74-р сургуулийн хөгжмийн багш Энхбатын “Урлагт хөглөгдсөн он жилүүд” тайлан тоглолт, Жаргалант тосгоны соёлын ордны арга зүйч Д.Бямбацэрэнгийн “Дуу минь, дуу минь” тайлан тоглолтыг тус тус зохион байгуулж 450 иргэнд сурталчилсан. “Хослох уянга” хос дуулаачдын уралдааныг зохион байгуулж 16 хорооны 20 хос дуучид оролцсноос нэгдүгээр байранд 21, 2-р байранд 32, 3-р байранд 18, тусгай байранд 17, 21, шүүгчдийн нэрэмжит шагналд 6, 7, 13-р хороодын иргэд тус тус шалгарлаа. Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн “Латиг” сангийн аялан тоглолт, зохиолын дуучдын тоглолтыг зохион байгууллаа. УДЭТ-тай хамтран “Бүүвэй” жүжиг, МУГЖ, дуучин н.Батбаярын уран бүтээлийн тоглолтуудыг нийт 1500 иргэнд толилуулсан.	100.0
122	Хороодын бичил номын сан болон Жаргалант тосгоны соёлын ордны номын санг баяжуулна.		Хороодын бичил номын санг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 31, 20, 10, 12-р хороодод “Эгэл амьдралын мөр” төрийн бус байгууллагатай хамтран бичил номын сан байгуулсан. Монголын бизнес эрхлэгчдийг дэмжих холбоотой хамтран 5-р хороонд “Бизнес хөгжлийн төв”-ийг шинээр нээн үйл ажиллагаа явуулж байна. Уг төвд 200 номын фондтой, 50 хүний суудалтай номын сан ажиллаж байна. Соёлын ордны номын сангийн фондыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2015 онд БСШУЯамнаас тус бүр нь 25000 төгрөгийн өртөг бүхий “Уламжлалт урлагаа хөгжүүлэе” сэдэвт 10 ширхэг номыг худалдан авсан. Засаг даргын Тамгын газраас Жангар туужийн 2, 3-р боть 10 ширхэгийг олголоо.	90.0
123	Иргэдийн дунд соёлыг хэвшүүлэх, гоо зүйн зөв дадал эзэмшүүлэх сургалт зохион байгуулна.		Иргэдийн дунд соёлыг хэвшүүлэх, гоо зүйн зөв дадал эзэмшүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын даргын 2015 оны А/41 дүгээр тушаалаар “Монгол цэргийн жавхаа-2015” үдшийн цэнгүүн, Засаг даргын 2015 оны А/112 дугаар захирамжаар “Иргэдийн баяр - 2015” наадам, А/281 дүгээр захирамжаар “Дээлтэй Монгол-2015” наадмыг тус тус зохион байгууллаа. Арга хэмжээнүүдэд нийт 4500 иргэдийг хамруулсан. 2015 оны 7-р сарын 11, 12-ны баяр наадмын	100.0

			өдрүүдэд Дүнжингарав худалдааны төвийн талбайд дүүргийн ардын авьяастан, соёлын ордны уран бүтээлчдийн хамтарсан урлагийн тоглолтыг зохион байгуулан наадамчин олонд толилуусан.	
124	Ардын ёс заншлыг хүүхэд, залуучуудад өвлүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.	Жаргалант тосгоны соёлын ордны дугуйлангийн сурагчдын санаачлагаар хандивын тоглолт зохион байгуулан 116-р цэцэрлэгийн ардын ёс заншлын танхимыг тохижуулсан. Ардын урлагийн талаарх лекц-тоглолтыг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж, 600 сурагчийг хамрууллаа. Сургалтаар сурагчдад ардын урлагийн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлж, хуучир хөгжмийн үүсэл гарал, ангилал, тархацын талаар мэдээллийг өгсөн. 2015 оны 10-р сард 74-р сургуулийн 2-7-р ангийн сурагчдын дунд ардын ёс заншлыг сурталчлах өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр ардын уламжлалт тоглоом наадгай, монгол зан үйлийг сурталчлан, АХА тэмцээн явуулж, 200 хүүхдийг хамрууллаа.	100.0	
125	Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах уралдаан зохион байгуулна.	Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг” шалгаруулах уралдааныг ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгууллаа. Тэмцээнд 13 сургууль оролцсноос Ирээдүй цогцолбор, 67, 107, 106-р сургуулиуд тус тус шалгарч, Нийслэлийн Шилдэг найрал дууны хамтлаг шалгаруулах уралдаан оролцон 107-р сургуулийн найрал дууны хамтлаг тусгай байрын шагнал хүртэж нийслэлийн 376 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтод оролцсон.	100.0	
126	Дүүргийн цэцэрлэгүүдийн дунд Уран жиргээ уран уншлагын уралдаан зохион байгуулна.	Дүүргийн цэцэрлэгүүдийн дунд “Уран жиргээ ” уран уншлагийн уралдааныг 2015 оны 1-р сарын 15 -ны өдөр зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 100 хүүхэд багачууд оролцсон.	100.0	
127	Соёлын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	2015 оны 2-р сарын 02-09-ний өдрүүдэд соёл урлагийн төлбөрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Тус шалгалтанд 22 караоке хамрагдаж 8 зөрчил, дутагдлыг газар дээр арилгуулж 4 зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.	100.0	

128	2.4.2. Соёл, урлагийн чиглэлээр хэрэгжиж үндэсний дэд хөтөлбөрүүдийг чанартай хэрэгжүүлнэ.	Соёл, байгаа болон	ЕБС-ийн сурагчдыг Түүх соёлын дурсгалт газруудаар аялуулна.	Засаг даргын 2015 оны А/195 дугаар захирамжаар ЕБС-уудын дунд Монголын адал явдалт спорт аялалын холбоотой хамтран “Түүх соёлын дурсгалт газартай танилцах” спорт аяллыг 5-р сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Тус аялалд 6 сургуулийн 8 баг оролцож явган аяллын 4 төрөлт тэмцээнд 42, 65, 62-р сургуулиуд амжилттай оролцлоо.	100.0
129			Түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах ажлыг үргэлжлүүлнэ.	Түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын зүйлийг сэргээн засварлах ажлын хүрээнд “Дүүргийн өндөрлөг”-ийг “Plips” ХХК 9,5 сая төгрөгөөр сэргээн засварласан болно. Мөн сэргээн засварлах шаардлагатай хөшөө дурсгалын жагсаалтыг гарган Нийслэлийн соёл урлагийн газар хүргүүллээ. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/343 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 15 “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлс”-ийн хадгалалт, хамгаалалт, Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, үзлэг тооллогын ажлыг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Улаанбаатар музейтэй хамтран 2015 оны 8-р сарын 20-27-ны өдрүүдэд зохион байгуулсан.	100.0
130			Монгол цуур хөтөлбөрийг хэрэгжүүлж, судалгааг гаргана.	Монгол цуур хөгжмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулагдаж буй 3 сарын сургалтанд соёлын ордны уран бүтээлч Нямдоржийг хамруулсан. Монгол цуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд судалгаа явуулсан боловч цуур хөгжим өвлөн авсан өв тээгч иргэд бүртгэгдээгүй байна.	70.0
131	2.4.3. Дүүргийн соёл, урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна		ЕБС-ийн сурагчдаас бүрдсэн ардын урлагийн хамтлагуудын тоог нэмэгдүүлнэ.	Ардын урлагийн хамтлагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын 62-р сургуульд 8 хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Морин хуурын чуулга”, 74-р сургуульд 10 хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Бөмбөрийн чуулга” тус тус байгуулагдсан.	100.0
132			Авьяас хөтөлбөрийн хүрээнд урлагийн наадам зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын А/127 дугаар захирамжаар Монголын хүүхдийн байгууллагын 90 жилийн ойг угтаж 2015 оны 5-р сарын 18-ны өдөр ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн дунд язгуур урлаг, уран уншлагын наадмыг Хүүхэд гэр бүл хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа. Уралдаанд 79, 80, 84, 91, 92, 107, 117, 158, 192, 195-р цэцэрлэг, 12-р сургуулийн авьяаслаг 120 сурагчид оролцож. гоцлол дуу, хамтлаг дуу, уран уншлага 3 төрөлд өрсөлдлөө. “BOB” энтертаймент, Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын	100.0

			дунд урлагийн наадмыг 11-р сард зохион байгуулж 10 сургуулийн 800 сурагчдыг хамруулсан.	
133	2.4.4. Дүүргийн Соёлын төвийг байгуулж иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Дүүргийн соёлын ордон бариулах талаар холбогдох байгууллагуудад уламжилна.	Хүүхэд залуучуудын соёлын ордны зураг төсвийг гүйцэтгэх сонгон шалгаруулалт Нийслэлийн Барилга, хот байгуулалтын газраас зарлагдаж “Baldans” ХХК шалгарч зураг төсвийн ажлыг гүйцэтгэсэн. Тус дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэрт соёлын ордон байгуулах 5000 мкв газрыг дүүргийн зүгээс шийдвэрлэсэн. 2016-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд Соёлын ордон бариулах хөрөнгийг суулгуулах талаар Засаг даргын орлогчийн 2015 оны 02/1194 тоот албан тоотыг Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар хүргүүлэв.	100.0
2.5 Хүүхэд, залуучуудын талаар				
134	2.5.1. Хүүхэд хөгжлийн төв байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.	Хүүхдийн асрамжийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн байр барих ажлыг эхлүүлнэ.	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн барилгыг 27-р хорооны нутаг дэвсгэрт барихаар оршин суугчдаас барилга барих зөвшөөрлийг гарын үсгээр баталгаажуулан авч нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар хүргүүлсэн.	30.0
135		Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн дэргэд “Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх сэтгэлзүйн өрөө” тохижуулан, үйл ажиллагааг жигдрүүлнэ.	2015 оны 6-р сараас эхлэн мэргэжлийн сэтгэлзүйчтэй болж давхардсан тоогоор нийт 100 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажиллаа. Үүнээс: <ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн маргаан зөрчил, хүчирхийллийн асуудлаар- 20 - Сэтгэлзүйн зөвлөгөө авах хүсэлтэй иргэд, хүүхэд- 15 - Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд-3 - Өсвөр насны хүүхдийн асуудлаар зөвлөгөө авч, хувь хүний онцлогийн талаар судалгаа оношилгоо хийлгэх хүсэлтэй хүүхэд- 37 - Шүүхийн шинжээчийн багийн ажлын хүрээнд 25 үйлчлүүлэгчтэй тус тус уулзаж, ярилцан оношилгоо явуулж, сэтгэлзүйн зөвлөгөө өгсөн. 	90.0
136	2.5.2. Гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга	Хүүхдийн төлөө үндэсний газрын харьяа “Хүүхдийн тусламжийн утас-108”, Цагдаагийн газрын харьяа “Гэр бүлийн хүчирхийллийн утас-107”-тай хамтран	Хүүхдийн тусламжийн утас 108-аас 220 дуудлага, гомдол хүлээн авч хороодын хамтарсан баг болон сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран шийдвэрлэлээ. Гэр бүлийн хүчирхийллийн утас-107-оос 8 гомдол хүлээн авч, гэр бүлд нь нэгтгэх, асрамж халамжийн төвд шилжүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн	100.0

	хэмжээ авна.	ажиллаж, дуудлагыг шуурхай барагдуулна.	102 дугаарын утсанд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагын дагуу 28 гэр бүлд нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлж, тухайн гэр бүлүүдэд хяналт тавин ажиллаж байна.	
137		Хороодын хамтарсан багийг чадваржуулах сургалтыг зохион байгуулан үйл ажиллагааг идэвхжүүлэх, байнгын ажиллагаатай байлгах зорилгоор аян зохион байгуулна.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх 2 сарын аян зарласан. Аяны хүрээнд 12 хорооны дунд “Дэвжээ” тэмцээнийг Цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран 10-р сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Нийслэлийн хороодын шилдэг хамтарсан баг шалгаруулах ур чадварын Центавр тэмцээнд дүүргийн баг амжилттай оролцож “Тэргүүн байр” эзэлж, шилдэг нийгмийн ажилтнаар 9-р хорооны нийгмийн ажилтан шалгарав. Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран хороодын хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 4-р сарын 14-20-ны өдөр зохион байгууллаа. Шалгалтаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгалах тухай хууль, нийслэлийн Засаг даргын 2007 оны А/144 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2014 оны А/67 дугаар захирамжийн хэрэгжилтийг шалгаж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөн, хамтарсан багийн гишүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. 32 хорооны хамтарсан багт арга зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн кейсийн маягтууд болон хамтарсан багийн хурлын тэмдэглэлийн загварыг бэлтгэн өгсөн. Хамтарсан багийн тайланг улирал, хагас жилээр авч дүгнэн ажиллаж байна. Гүүд нейборс олон улсын байгууллагатай хамтран хүүхдийн эрхийн сургалтыг бүх хороодын хамтарсан багийн гишүүдэд 6-р сарын 25-30-ны өдрүүдэд зохион байгуулав. 2015 оны 9-р сард Дэлхийн Зөн монгол Олон улсын байгууллагын Баянхошуу, Толгойт орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран нийт 20 хорооны хамтарсан багийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулав.	100.0
138		Гэр бүлийг дэмжих чиглэлээр “Гэр бүлээ сонсьё” аян зохион байгуулна.	“Гэр бүлээ сонсьё” аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: -Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг угтаж “Хүүхдээ сонсьё” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг дүүргийн асрамж халамжийн төвд амьдарч буй ахлах, дунд ангийн хүүхдүүдийн дунд 2015 оны 4-р сард зохион байгуулж, 21 хүүхэд	100.0

			<p>оролцлоо.</p> <p>-Монгол HD” телевизтэй хамтран дүүргийн шилдэг гэр бүл болох 9, 11, 28-р хорооны шилдэг гэр бүлүүдийг “Өнөө өглөө” хөтөлбөрийн шууд нэвтрүүлэгт оруулав.</p> <p>-Олон Улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан “Ээжтэйгээ авахуулсан зураг эрхэм”, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Аавтайгаа авахуулсан зураг эрхэм” фото зургийн үзэсгэлэн, хэлэлцүүлэг зохион байгуулж, Ирээдүй цогцолбор сургуулийн ахлах, дунд ангийн нийт 104 бүлгийн 2508 хүүхэд хамрагдав.</p> <p>-Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан шилдэг гэр бүлүүдийг алдаршуулж, хөгжөөнт тэмцээн, туршлага солилцох уулзалт, сургалтыг зохион байгуулж 900 гаруй иргэдийг оролцууллаа.</p> <p>-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж Алдарт эхийн 1,2 дугаар зэргийн одонг 15 ээжид гардуулж, урлаг спортоор тэргүүлсэн 20 хүүхдийг алдаршуулж гарын бэлэг өгсөн.</p> <p>-Зорилтод бүлгийн 1000 хүүхдийг үнэ төлбөргүй циркийн тоглолт үзүүлсэн.</p> <p>-Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагатай хамтран “Хамтдаа инээмсэглэе” уулзалт өдөрлөгийг зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдийг оролцуулав.</p>	
139	2.5.3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон эмзэг бүлгийн хүүхэд,	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асруулах, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох ажлыг зохион байгуулна.	Хүүхдийн эрх зөрчигдсөн, хүнд нөхцөлд байсан 48 хүүхдийг асрамж халамжийн төвд асруулж, 82 хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгон, асрамжийн газраас 10 хүүхдийг буцаан авч гэр бүлд нь эргүүлэн нэгтгэх захирамж гаргаж биелэлтэнд хяналт тавьж ажилласан.	100.0
140	залуучуудад нийгмийн ажлын үйлчилгээг хүргэнэ.	Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг нийгэмшүүлэх цуврал сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан “Илрүүлэлт” арга хэмжээг явуулж хороо бүр хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, мөн эрсдэл бүхий хүүхдүүдийн эцэг эх асран хамгаалагчдад сургалт нөлөөллийн ажлыг 560 иргэнд зохион байгуулсан. 2015 оны шинэчилсэн судалгаагаар дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэгч 44 хүүхэд бүртгэгдсэн. Хорооны нийгмийн ажилтан, Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэстэй хамтран илрүүлэлтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс сургууль завсардсан 12 хүүхэд байгаагаас 3 хүүхдийг	100.0

			Албан бус насан туршийн боловсрол олгох төвийн сургалтад хамруулав. “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг” олон улсын өдрийг угтан “ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТ ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЬЕ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛД ЗА ГЭЖ ХЭЛЬЕ” өдөрлөгийг 2015 оны 6-р сарын 11-ний өдөр дүүргийн хөдөлмөр эрхлэгч насанд хүрээгүй хүүхдүүд болон тэдний эцэг, эх мөн амьдарлын баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүд, эцэг, эхийг хамруулан нийт 20 хүүхэд, 40 эцэг, эхчүүдийг хамруулан зохион байгууллаа. 2015 оны 8-р сард хөдөлмөр эрхлэгч хүүхдэд хичээлийн шинэ жилийн мэнд хүргэж 30 хүүхдэд хичээлийн хэрэгсэл болон цүнх, сургуульд шинээр элссэн 3 хүүхдэд сурагчийн дүрэмт хувцас бэлэглэв. Хөдөлмөр эрхлэгч 24 хүүхдийн ар гэрт очиж, нөхцөл байдлын үнэлгээ судалгаа хийх ажлыг зохион байгуулж, эцэг, эх, асран хамгаалагчдад нь үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлэх талаар зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллаа.	
141	Зорилтот бүлгийн бичиг баримтгүй иргэд, хүүхдүүдийг бичиг баримтжуулах.	Бичиг баримтжуулах шаардлагатай 2 хүүхдийг Иргэний хэргийн анхан шатны 2-р шүүхэд нэхэмжлэл гарган, насыг нь тогтоолгон, бүрэн бичиг баримтжуулсан.	100.0	
142	Эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүдийг зусланд амраана.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн эрхийн бичгийн дагуу дүүргийн нэн ядуу айл өрхийн хараа хяналт сул, хөдөлмөр эрхэлдэг 20 хүүхдийг Сансар зусланд, Олон улсын хатагтай нарын нийгэмлэг, Хүүхэд хөгжлийн Нарс тулгуур төв ТББ-тай хамтран 16 хүүхдийг Нарс зусланд, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулсан “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг зусланд амраах” хөтөлбөрт хөдөлмөр эрхлэгч 3 хүүхдийг нийт 39 хүүхдийг зусланд амраасан.	100.0	
143	Хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, залуучуудыг эмчийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн хэмжээнд нийт 0-18 насны 677 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй /харааны бэрхшээлтэй-71, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй-69, хөдөлгөөний хомсдолтой-129, оюуны хөгжлийн бэрхшээлтэй-210, хавсарсан-80, бусад-140/ бөгөөд давхардсан тоогоор 1600 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамтруулж, 110 хүүхдэд халамж тогтоолгоод байна. 5-р сарын 30-аас 6-р сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Бид шинэ үеийн хүүхдүүд” үндэсний чуулга, уулзалтанд 2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулсан.	100.0	

144	2.5.4. Хүүхэд, залуучуудыг аливаа эрсдэл, хорт зуршил, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	Хүүхэд залуучуудыг осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүүхэд буруугүй”, “Ногоон гэрэл-Цагаан шугам” аян зохион байгуулж, гарын авлага, сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулна.	“Хүүхэд буруугүй” аяны хүрээнд 2015 оны 3-р сарын 25-нд 104-р сургуулийн 9-12-р ангийн нийт 160 хүүхдэд “Хүүхдийн эрх, үүрэг” болон “Хүүхдийн осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аяныг зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын 2015 оны А/21 дүгээр захирамжийн дагуу хороодтой хамтран 60 удаагийн сургалтыг 10.000 иргэдэд зохион байгуулсан. Засаг даргын 2015 оны А/392 дугаар захирамжаар ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнийг 10-р сард зохион байгууллаа. Тэмцээнийг 5-н төрлөөр явуулж, сурагчдад замын хөдөлгөөний дүрэм, хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн.	100.0
145		Цахим тоглоомын газар, интернэт төвүүдийн үйл ажиллагаанд холбогдох газруудтай хамтран хяналт тавьж, стандартыг мөрдүүлнэ.	Цахим тоглоомын газар, интернэт төвүүдийн үйл ажиллагаанд хороодын нийгмийн ажилтнууд, хэсгийн байцаагчид хяналт тавин ажиллаж байна. Хүүхдийг зодож шийтгэхгүй байх олон улсын өдрийг угтан 2015 оны 4-р сард “Цахим тоглоом, гар утасны хор хөнөөл” сэдэвт сургалт Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын Толгойт орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран ерөнхий боловсролын 9 сургуульд зохион явуулж 2845 сурагч хамрагдсан. Дүүргийн “Хүүхдийн анхдугаар чуулган”-ыг 2015 оны 4-р сард зохион байгуулав. Тус чуулганд дүүргийн ерөнхий боловсролын 16 сургуулийн 30 сурагчдыг төлөөлөл болгон оролцуулав. Нийслэлийн чуулганд дүүргийн төлөөлөл 5 хүүхэд “Компьютер тоглоомын хор хөнөөл болон донтолтоос сэргийлэх нь” сэдвээр илтгэл тавин оролцлоо.	90.0
146		Хараа хяналтгүй хүүхдүүд, архины хамааралтай иргэд, залуучуудыг нийгэмшүүлэх “Өөрчлөлт” төслийг үргэлжлүүлж, 3-аас доошгүй төвийг байгуулна.	Архины хамааралтай гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилгоор “Аз жаргалтай гэр бүл-2” өдөрлөгийг Ерөөгдсөн гэр бүл ТББ-тай хамтран 2015 оны 3-р сард зохион байгуулж 70 иргэнийг оролцууллаа. 5-р хороонд 2013 онд байгуулсан төвийн жишгээр тус дүүргийн 31-р хороонд сургалтын төв байгуулах, 21-р хороонд архины хамааралтай иргэдийг нийгэмшүүлэх вакуумжсан сургалтын орчин бий болгох зорилгоор газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад уламжлаад байна.	30.0

147	2.5.5. Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах ажлыг зохион байгуулна.	Хөгжлийн нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах, мэргэшүүлэх сертификатны сургалтанд хамруулна.	Хүүхдийн тусламжийн утас-108-ыг танилцуулах, утсанд ирсэн кейсүүдэд хариу үйлчилгээ үзүүлэх сургалтыг Хүүхдийн төлөө үндэсний газар, Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газартай хамтран дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн ажилтнууд, хороодын нийгмийн ажилтнуудад зохион байгуулав. 29 дүгээр тусгай сургуультай хамтран 4 дүгээр сард хорооны нийгмийн ажилтнуудыг дохионы хэлний сургалтанд хамруулж батламж олгов. Сэтгэцийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх үйлчилгээ” сэдэвт сургалтыг 2015 оны 10 дугаар сард, Монголын Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийгэмлэгтэй хамтран “Архины хор хөнөөл, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2015 оны 11 дүгээр сард тус тус зохион байгууллаа. “Стратегийн мэдээлэл харилцааны тухай ойлголт, арга хэрэгсэл” сургалт 2015 оны 11-р сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж 3 нийгмийн ажилтанд сертификат олгосон.	100.0
Гурав: Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.				
3.1. Дэд бүтэц				
148	3.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны хуучин барилгуудын инженерийн шугам сүлжээг сайжруулна.	Орон сууцны барилгуудын инженерийн гадна, дотор шугам сүлжээг сайжруулах ажлын жагсаалт гарган холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны хуучин барилгуудын инженерийн шугам сүлжээг сайжруулж, шинэчлэн солих их болон урсгал засварын судалгааг гарган, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, ОСНААУГ-тай хамтран дараах ажлуудыг төлөвлөн ажиллаа. Үүнд: ОСНААУГ-ын харъя ХҮТ-үүд орон сууцны 182 байр, ялтсан бойлер бүхий дулааны төвлөрсөн 12 узелийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн чанар ашиглалтын түвшинг тогтооход тоног төхөөрөмж инженерийн шугам сүлжээний ашиглалт 88,3 хувь, гадна болон усан хангамжийн сүлжээний ашиглалт 86%, төвлөрсөн бойлер болон узелийн ашиглалт 90%, цахилгаан болон тоноглолын ашиглалт 84,2%, холигч насосны ашиглалт 89,3% тус тус байна. Эдгээр инженерийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ашиглалт, гэмтэл засварыг арилгах ажлын хүрээнд УДДТ-2-ын харъяа 9-р байрны 1-3-р орцны халуун хүйтэн усны магистраль шугамыг	100.0

		<p>өргөтгөсөн. Урсгал засвараар нийт 19 ажил төлөвлөж бүрэн хийж дуусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэгцээний халуун хүйтэн усны 225 у/м шугам, халаалтын 440 у/м магистраль шугам, ариутгах татуургын 390 у/м магистраль шугамыг шинээр сольсон. - Механизмаар 16 систем узелийн дотор угаалга хийсэн, 123 систем узелийг шахаж шалгасан, 15 холигч узелийг шинээр сольсон, 303 шайбны узельд завсар үйлчилгээ хийсэн. - Төвлөрсөн узелийн халаалтын 15 ялтсан бойлерийг угааж, хэрэгцээний халуун усны 18 ялтсан бойлерийн засвар үйлчилгээг хийсэн. - 107 ширхэг узелийн хаалт засварлаж, 213 узелийн хог шүүгчийг цэвэрлэж, 105 узелийн хаалтыг сольж, 125 балансын хаалт шинээр суурилуулсан. - Усны даралтыг хэмжих хэрэгсэл 100 манометрийг сольсон. <p>Ариутгах татуургын 4548 у/м шугамыг угааж цэвэрлэн, 685 ш худгийг лайдаж, цэвэрлэсэн.</p>	
149	Газар доорх холбооны болон инженерийн шугам сүлжээний таг, нээлхийний бүрэн бус байдлыг хангаж, стандартын тагтай болгох ажлыг зохион байгуулна.	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн газар доорх инженерийн шугам сүлжээний стандартын таггүй 87 худгийг тагжуулах судалгааг гарган ОСНААУГ-ын Баруун түгээх төвд 2015 оны 06-р сарын 05-ны өдрийн 09/1328 дугаар албан тоотоор хүргүүлж ажилласнаар 19 таггүй худгийг тагжуулсан. Газар доорхи инженерийн байгууламжийн худгийн ашиглалтыг сайжруулах, болзошгүй эрсдлийг агуулж буй зөрчил, дутагдлыг таслан зогсоох зорилгоор хороодоос тусгай маягтын дагуу судалгааг нэгтгэн авч, эрүүл аюулгүй байдлын индексийн үзүүлэлттэй харьцуулсан судалгаа хийлээ. Судалгаагаар нийт 2173 худаг байгаагаас дулааны 344, цэвэр усны 477, бохир усны 1078, холбооны 172, борооны ус зайлуулах худаг буюу шүүр 90, бусад худаг 12 байна. Дулааны 17, цэвэр усны 13, бохир усны 38 нийт 68 худаг таггүй байсныг зохих байгууллагад мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласнаар одоогийн байдлаар 15 худгийг стандартын тагаар, 35</p>	100.0

			худгийг стандартын бус тагаар тагжуулсан.	
150	3.1.2. Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг үе шаттайгаар засварлаж шинэчилнэ.	Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг засварлаж, шинэчлэх ажлыг үргэлжүүлнэ.	Дүүргийн 9 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 28 СӨХ-дын 74 байрны 94603м2 дээврийн талбайг засварлуулах нэгдсэн судалгааг гарган нэгтгэж Барилга хот байгуулалтын яаманд 2015 оны 05-р сарын 19-ний өдрийн 02/1226 дугаар албан тоотоор хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2015 оны 01/1273 дугаар албан тоотоор Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газарт саналаа хүргүүлсэн. Засвар хийгдэх шаардлагатай 52 СӨХ-дод албан шаардлага хүргүүлж, 8440 м2 дээврийн хэсэгчилсэн засварын ажлыг 60,8 сая төгрөгөөр, 140 лифтний техникийн засвар үйлчилгээг тус тус хийсэн.	90.0
151	3.1.3. Замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор авто замуудыг шинээр барих, авто замын өргөтгөл хийх ажлыг зохион байгуулах, зам засварын ажлын чанарыг сайжруулна.	Нийтийн эзэмшлийн болон орон сууц, гэр хорооллын доторх авто зам, гүүрийг шинээр тавих, засварлах үргэлжлүүлнэ. /12-р хорооны орон сууцны хороолол доторхи авто замын шинэчлэлт, засвар, 15, 21, 30, 31-р хорооны гэр хорооллын хайрган хучилттай авто замуудын засвар, шинэчлэлт/	Нийслэлийн авто замын сангийн 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийгдэх 4 км замын шинэчлэлтийн ажлыг хийлгэхээр Нийслэлийн авто замын газарт хүргүүлж, дараах ажлуудыг гүйцэтгэн хүлээн авсан. Үүнд: - 65-р сургуулийн өмнө авто зам шинээр тавих /3-р хороо/, Москвагийн гудамжнаас “Их хөдөлгөөн” авто сургууль хүртэлх авто замын хучилт хийх /14-р хороо/, Залуус гудамжнаас Титэм плазагийн урдуур АНУ дэлгүүрийн зүүн тал хүртэлх авто замын хучилт хийх, СХД-ийн ЗДТГ-ын байрны арын зам шинээр тавих /27-р хороо/, Орчлон хорооллын уулзвараас, 35 б байрны баруун талаар “Ар Жанар” ХХК хүртэлх авто замын хучилт хийх /27-р хороо/ ажлуудыг “Төгс цас” ХХК 256,8 сая төгрөгөөр - Хувьсгалчдын гудамжнаас 127-р цэцэрлэг хүртэлх авто зам шинээр тавих /11-р хороо/, Нефтийн 1, 2, 3-р 30 айлын орон сууцны дундах авто замын хучилт хийх /20-р хороо/ ажлыг “Би би сервис” ХХК 310,0 сая төгрөгөөр, - Зүүн салааны авто замаас 170-р цэцэрлэг хүртэлх авто зам шинээр тавих /9-р хороо/ ажлыг “Ринг роуд” ХХК 177,6 сая төгрөгөөр, - 1-р хороололын, 34-р байрны арын авто зогсоолын талбайд хучилт хийх /17-р хороо/, Нарангийн голын авто замаас 81-р цэцэрлэг хүртэлх авто зам шинээр тавих /2-р хороо/ ажлыг “Отгон царам” ХХК 110,0 сая төгрөгөөр,	100.0

			- 21-р хороолол, 1-58, 8-58, 10-58 айл, Геологийн 3-30 айлын баруун талын авто замын хучилт хийх /19-р хороо, Залуус гудамжнаас 11-р байрны урд тал, Цагдаагийн 3-р хэлтэс хүртэлх авто замын хучилт хийх /13-р хороо/ ажлуудыг “Сезам” ХХК 108,0 сая төгрөгөөр, - 34-р байрны хойд гүүрээс хойш 21-р хорооллын гэрлэн дохиотой уулзвар хүртэлх авто зам шинээр тавих /23-р хороо/ ажлыг “Зэ Зэ Бэ” ХХК 288,0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	
152	Явган хүнд зориулсан нүхэн болон гүүрэн гарцын байршлыг судалж, тодорхойлон, барилга угсралтын ажлын саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.	Дүүргийн 29-р хорооны нутаг дэвсгэр Сүлжмэлийн үйлдвэрийн урд талын Москвагийн гудамж, 7-р хорооны нутаг дэвсгэр Баянхошууны гудамж, 8-р хорооны нутаг дэвсгэр Хувьсгачдын гудамж, 17-р хорооны нутаг дэвсгэрийн ХААН банкны урд талын замд явган хүний нүхэн гарц байгуулах боломжийг судалж байна.	70.0	
153	26-р хороо Арслантай гүүрнээс 780-р усан сан хүртлэх 800м асфальтан зам барих асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилна.	Нийслэлийн 2015 оны төсвийн тодотголд тусгуулахаар саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй болно. 2016 оны нийслэлийн авто замын хөрөнгөөр хийгдэх судалгаанд хамруулав.	100.0	
154	Орбитын уулзвараас-Толгойтын эцэс-Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хийнэ.	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөгдсөн боловч хөрөнгө санхүүгийн асуудлаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдон шийдвэрлэгдээгүй байна. Орбитын уулзвараас – Толгойтын эцэс – Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх 3,6 км авто зам, 2 гүүрийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр 2015 онд санхүүжих /7475,1 сая төгрөг/ ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавих эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2015 оны 08 сарын 19-ны А/682 дугаар хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай захирамжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр тендер нээж одоогийн байдлаар үнэлгээний ажил хийгдсэн. Шаардлага хангасан тендерийн материал ирээгүй.	-	

155	3.1.4. Ард Аюушийн гудамжийг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3.1 км замыг гүүрийн хамт барина	Ард Аюушийн гудамжийг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3.1 км замыг гүүрийн хамт барих ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар зохих байгууллага, албан тушаалтанд уламжилна.	Концессийн гэрээгээр хийх боломжийг судлан, хувийн хэвшлийн компаниудад ажлын зураг, төсвийг танилцуулж байна. Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газарт “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусгуулахаар саналаа 2015 оны 03-р сарын 26-ны өдрийн 01/754 албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтанд ороогүй тул концессын гэрээгээр хэрэгжих боломжгүй болсон. ОХУ, БНХАУ, Сингапур улсын хөрөнгө оруулалттай компаниудад хамтран ажиллах санал тавьсан боловч одоогийн байдлаар хариу ирээгүй байна.	30.0
156	3.1.5.Ашиглалтын шаардлага хангахгүй хуучин орон сууцны барилгуудын газрын эрхийг бүртгэлжүүлж, оршин суугчдын оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг концессын гэрээгээр хийж гүйцэтгэнэ.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудын “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөж, барилгажуулах журам” –ын дагуу оршин суугчдын саналыг авч, холбогдох газарт хүргүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны барилгуудын насжилт, газар хөдлөлтөнд тэсвэртэй байдлын судалгааг мэргэжлийн байгууллагаас авч, 19-р хорооны 2-20-р дан байр, 1-48-р орон сууц, Мах импексын үйлдвэрийн ажилчдын байр, 27-р хорооны тоосгоны 33-р байр, Тээврийн ажилчдын 12-1, 12-2-р байрыг “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаа”-нд хамруулах талаар иргэдийн уулзалт зохион байгуулж, нийт 91 айл өрхийн санал хүсэлтийг нэгтгэсэн. Мөн 18-р хорооны 5 шарын орон сууцны 18 иргэдээс ирүүлсэн өргөдлийн хамт НЕТГ-т хүсэлт гаргаснаар дээрх байршлуудаас НЕТГ-ын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтсээс 2015 онд дүүргийн нутаг дэвсгэрт тухайн барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэлтийн дүгнэлт гаргах судалгааны ажлын жагсаалтад орсон.	90.0
157	3.1.6. Иргэдийг хямд үнэтэй орон сууц, амины орон сууцаар хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд өмчлөлийн газраа орон сууцаар солих, амины орон сууц хэлбэрээр тохижуулах хүсэлтэй иргэдийн судалгаа гаргаж холбогдох байгууллагуудад уламжилна.	Улаанбаатар хотын Захирагчийн Баянхошуу дахь ажлын алба, Гэр хорооллын хөгжлийн газартай хамтран 28-р хороонд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч “ТОБ” групп ХХК-тай хамтран дахин төлөвлөлтөд хамрагдсан 50 гаруй иргэдэд төслийн хэрэгжилтийн явцыг танилцуулах, санал хүсэлт авах уулзалт зохион байгуулсан. 4-р сарын 20, 22, 24, 25-ны өдрүүдэд 1, 2, 5, 6, 7, 10, 20, 28-р хороонд хэрэгжиж буй гэр хорооллын дахин төлөвлөлтөнд хамрагдаж буй 1000 гаруй иргэдэд төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүд төслийн хэрэгжилт, явцын талаар	90.0

			<p>танилцуулах, иргэдтэй хэлэлцүүлэг хийх уулзалтыг зохион байгуулсан. Дүүргийн ИТХ-ын Ажлын алба, Улаанбаатар хотын Захирагчийн Наран дахь ажлын албатай хамтран 2015 оны 04 сарын 29-ний өдөр дүүргийн иргэний танхимд “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны явцыг мэдээлэх, төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус уулзалтад Тамгын газрын хобогдох хэлтэс алба, дахин төлөвлөлтөд хамрагдаж буй хороодын Засаг дарга, төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүд оролцсон. Мөн Газар шинэчлэн зохион байгуулалтын талаарх сургалтыг нийслэлийн Гэр хорооллыг орон сууцжуулах төслийн газартай хамтран дүүргийн иргэний танхимд зохион байгуулсан бөгөөд Сургалтад Тамгын газрын холбогдох албан тушаалтан, гэр хороодын Засаг дарга, иргэдийн төлөөлөл хамрагдсан. Нийслэлийн гэр хорооллын орон сууцжуулах төслийн газартай хамтран 04 сарын 16, 22-ний өдрүүдэд дүүргийн 27-р хорооны нийт 80 орчим иргэдэд иргэдийн оролцоотой газар шинэчлэн зохион байгуулалтын талаар сургалт, зөвлөгөө өгөх уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>3-р хорооны 300 орчим иргэдэд 2015 оны 08 дугаар сарын 22, 29, 09 дүгээр сарын 5, 12, 19-ний өдрүүдэд Газар шинэчлэн зохион байгуулалтын талаарх сургалтыг зохион байгуулснаар иргэдийн саналын дагуу тус хорооны 1, 5-р хэсгээс иргэдийн 2 бүлэг байгуулагдсан. 2015 оны 11 сарын 20-ний өдөр 17:25 цагт Нийслэлийн захирагчийн Баянхошуу дахь ажлын алба, ГХОСТГ-тай хамтран 11-р хорооны иргэний танхимд 15 айл өрхийн төлөөлөлд Газар шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагааны талаар уулзалт сургалт хийх, иргэдийн санал авах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Гэр хорооллын дахин төлөвлөн барилгажуулах ажлын талаар: 5, 6, 7-р хорооны нутаг дэвсгэр Ханын материал орчим төсөл хэрэгжүүлэгч “Хера пропертийз” ХХК нь 34 айлын 2.2 газыг бүрэн чөлөөлөн 2015 оны 4-р улиралд 332 айлын орон сууцны барилгыг ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн дээрх байршилд төсөл хэрэгжүүлэгч “Жи Ди” ХХК нь 23 айлын 2.0 га</p>	
--	--	--	---	--

			<p>газрыг бүрэн чөлөөлөн 2015 онд төслийн эхний ээлжийн 116 айлын 9 давхар 2 блок барилга, Улаанбаатар хотын нэгдсэн дэд бүтцийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлэн ажиллаж байна. 10-р хороо Арьс ширний ажилчдын байр орчим төсөл хэрэгжүүлэгч “Назу проперти” ХХК нь 56 айлын 2.0 газрыг бүрэн чөлөөлөн 2015 онд ашиглалтанд оруулахаар эхний ээлжийн 74 айлын 5 давхар 1 блок орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлэн Улаанбаатар хотын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг хийж гүйцэтгэж байна. 1, 2, 20-р хорооны Цэргийн хотхон орчим төсөл хэрэгжүүлэгч “Хас Харш” ХХК нь эхний ээлжийн 2 блок 12 давхар 288 айлын орон сууцыг барих төлөвлөгөөтэй, Улаанбаатар хотын нэгдсэн шугам сүлжээнд холбогдохоор зургын ажлыг гүйцэтгэж байна. Мөн дээрх байршилд төсөл хэрэгжүүлэгч “Стандарт проперти” ХХК нь 28 айлын 2.3 га газрыг бүрэн чөлөөлөн төслийн эхний ээлжийн 262 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн 2015 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Улаанбаатар хотын нэгдсэн шугам сүлжээнд холбогдохоор зургийн ажлыг гүйцэтгэж дууссан. Баянхошуу 28-р хороонд төсөл хэрэгжүүлэгч “ТОБ” ХХК-ний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулах, техникийн нөхцөл гаргуулах болон инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулагдах хийгдэж байгаа болно.</p>	
158	3.1.7. Гэр хорооллын өрхийн усны хүрэлцээ, хангамжийг сайжруулна.	1, 3, 7, 21, 22, 24, 25, 26, 32-р хороодод гүний худаг, усан сан байгуулна.	<p>Дүүргийн 7 хорооны 8 байршилд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөөврийн ус түгээх байр болон гүний худаг баригдсан. Зөөврийн ус түгээх байр:</p> <ul style="list-style-type: none"> - 3-р хорооны Баганарангийн 42, 43-р гудамжинд зөөврийн ус түгээх байр барих ажлыг “Инсепшн холдинг” ХХК, 24-р хорооны Зээлийн 16-р гудамжинд зөөврийн ус түгээх байр барих ажлыг “Ширээт тамир” ХХК, - 1-р хорооны Толгойтын 103-р гудамжинд зөөврийн ус түгээх байр барих ажлыг “Белит” ХХК, - 26-р хорооны Мандал овооны 17-р гудамж, Алтан овооны 16-р 	90.0

			<p>гудамжинд зөөврийн ус түгээх байр барих ажлыг “Баяжих галуут” ХХК-иуд тус тус хийж гүйцэтгэсэн.</p> <p>Гүний худаг:</p> <p>- 21-р хорооны 74-р сургуулийн хашаанд, 25-р хорооны Одонтын 24-р гудамжинд, 32-р хорооны Эмээлтийн баруун дэнжид гүний худаг барих ажлыг “Барилга импекс фирм” ХХК тус тус хийж гүйцэтгэсэн.</p>	
159	3.1.8. Гэр хорооллын эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг шинээр холбож, шаардлагатай газруудад хүчдэлийг сайжруулна.	10, 22, 26, 28, 30, 31, 32-р хороодод цахилгааны хүчдэл сайжруулах талаар холбогдох байгууллагуудад уламжилна.	10, 22, 26, 28, 30, 31, 32-р хороодод цахилгааны хүчдэл сайжруулах талаар НЕТГ-г хүсэлт гаргаж уламжилсан. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөний газар, Инженерийн байгууламжийн хэлтэстэй хамтран хүчдэл сайжруулах шаардлагатай гудамж, айл өрхүүдээр газар дээр нь очиж танилцан, гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд 6218 өрхийн цахилгаан хангамжийг сайжруулахаар зураг төсөв боловсруулах ажлыг 90,0 сая төгрөгөөр хийж байна.	100.0
160	хүчдэлийг сайжруулна.	1-р хорооны Толгойтын 77, 78-р гудамжны айл өрхийн цахилгааны хангамжийг сайжруулна.	1-р хорооны Толгойтын 77 дугаар гудамжны 15 өрх, 60 гаруй иргэд 2011 оноос хойш гэрэл цахилгаангүй байгаа бөгөөд ойр орчмын айлуудаас цахилгааныг салаалсаны улмаас байнгын хүчдлийн уналттай байдаг тул иргэд удаа дараа хүсэлт гаргасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2014 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн А/672 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Цахилгаан хангамжинд холбох” ажлын худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг дүүргийн Засаг даргад даалгасан. Дээрх захирамжийн дагуу Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн дагуу дүүргийн Засаг даргын 2014 оны 10-р сарын 30-ны өдрийн А/395 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулж, 11-р сарын 04-ний өдөр тендерийг зарласан. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, үнэлгээний дүгнэлтийг үндэслэн СХД/ЦА/А672-01/ тоот ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хамгийн сайн үнэлэгдсэн тендерт гэрээ байгуулах эрхийг “Юсэр” ХХК-д олгосон. Гэвч дээрх компанийг шаардлага хангахгүй байна гэдэг үндэслэлээр гэрээ байгуулахаас татгалзсан. Иймд энэ асуудлыг нягтлан үзэж, дээрх айл өрхийг цахилгаанд холбож өгөх хүсэлтийг УБ хотын ЗАА-ны даргад 2015 оны 1/988 дугаараар	30.0

			хүргүүлэв. Хөрөнгийн эх үүсвэргүй тул 2016 оны гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын судалгаанд хамруулав.	
161	3.1.9. Баянхошуу, Орбит, Толгойтод орчимд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий дулааны станц, бохир усны гол шугамыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Баянхошуу, Орбит, Толгойт орчимд гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлуудад инженерийн шугам сүлжээ байгуулах ажилд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Баянхошуу, Сэлбэ дэд төвийн төслийн хүрээнд нийслэлийн Засаг даргын А/259 дүгээр захирамжийн дагуу 7 буудал, Баянхошуу бохир усны гол коллекторын гүйцэтгэгчээр “Хүрд” ХХК, “Б-Софт” ХХК тус тус шалгарсан. Баянхошуу, Толгойт орчимд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж буй байршилд төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүдийн инженерийн шугам сүлжээний хийх ажлын талаар иргэдэд танилцуулах мэдээлэл өгөх уулзалтыг /04 сарын 20, 25-нд Баянхошуу, 04 сарын 22-нд Толгойт/ -д хорооны иргэний танхимд зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын А/175 дугаар захирамжаар “Сэлбэ, Баянхошууны дэд төвийн ариутгах шугам”-ын газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнд дүүргийн Засаг дарга орсон бөгөөд нөлөөлөлд өртсөн 4, 5, 7, 19, 26, 27 хороодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 77 нэгж талбарын судалгааг гарган төслийн багтай хамтран ажиллаж байна.	90.0
162	3.1.10. Гэр хороолол болон шинээр баригдах хороололд ахуйн үйлчилгээний цогцолбор барилга барина.	Гэр хороололд шинээр Ахуйн үйлчилгээний төв, халуун усны цэгүүдийг барихад концессын хуулиар зохицуулагдах хөрөнгө оруулалтын арга замыг судлана.	Концессын гэрээгээр ажил гүйцэтгэх хамтран ажиллах аж ахуйн нэгжийг судалж байна. Одоогоор тодорхой санал ирээгүй байна.	10.0
163	3.1.11. Иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны зогсоолын тоог нэмэгдүүлж, зогсоолыг стандартын шаардлагын дагуу бариулах ажлыг уламжлан шийдвэрлүүлнэ.	1-р хороололос 5 шар хүртэлх 4 автобусны зогсоолыг иж бүрэн тохижуулах саналыг нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлж, Худалдаа хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн.	100.0

164		Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдэд зорчигч урсгалын бодит судалгааг хийнэ.	Авто үйлчилгээний талаархи судалгаа гаргаж, нийтийн тээврийн үйлчилгээний автобусны чиглэлийн тоог нэмэгдүүлэх талаар иргэдээс гаргасан хүсэлтийг Нийслэлийн тээврийн газарт уламжилснаар М:60 буюу Баянхошууны уулзвар - 3, 4 дүгээр хороолол - 1 дүгээр хороолол/ хойгуур, М60 /Б/ буюу Баянхошууны уулзвар - 1 дүгээр хороолол - 3, 4 дүгээр хороолол чиглэлүүдийг шинээр нээж автобусны зогсоолуудыг нэмэгдүүлсэн.	100.0
165	3.1.13. Толгойт Сонсголонгийн замын уулзварт барих гүүрэн гарц барих ажлыг эхлүүлнэ.	Сонсголонгийн авто замын ажлыг дуусгана.	Сонсголонгийн авто замыг “Арц суварга” компани 23.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд тээврийн хэрэгсэл зорчих хэсгийг 16 метр өргөн, хажуугаараа дугуйн болон явган хүний замтай, суурийн үеэс гадна бетон хучилтын зузаан нь 26 см байхаар тооцож шинэ технологиор барьж буй 5,5 км даацын шинэ замын нээлтийг 2015 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хийсэн.	100.0
3.2 Тохижилт				
166	3.2.1. Иргэдийн ая тухтай амьдрах, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай газруудад бичил цэцэрлэг, усан оргилуур, тоглоомын талбай, нийтийн бие засах газар, явган хүний зам, гүүр, гарц барина.	5, 7, 19, 27, 28, 29-р хороодод хүүхдийн тоглоомын талбай байгуулна.	Дүүргийн 5-р хорооны цогцолбор байрны дэргэд хүүхдийн тоглоомын талбай /сагсан бөмбөгийн талбай/ байгуулах ажлыг “Чойсамбуу” ХХК 62,2 сая төгрөгөөр, 7-р хорооны Колонкийн 1-р гудамжинд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг “Ньюгранд технологи” ХХК 50,8 сая төгрөгөөр, 19-р хорооны 1-58, 2-58-р байрны баруун талд хүүхдийн тоглоомын талбайн ажлыг “Хорго групп” ХХК 52,2 сая төгрөгөөр, 29-р хорооны Москва хороололын 131/1 байрны урд талд тоглоомын талбайн ажлыг “Баяжих галуут” ХХК 64,5 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн. 27-р хорооны нутаг дэвсгэрт хийгдэх хүүхдийн тоглоомын талбайн ажлын тендерт “Люкс ландшафт” ХХК, 28-р хорооны нутаг дэвсгэрт баригдах хүүхдийн тоглоомын талбайн ажлыг “Бэст сивэл инженеринг” ХХК тус тус гүйцэтгэхээр тендерт шалгарсан боловч хүйтний улиралд хийх боломжгүй учраас 2016 оны хавар хийхээр гэрээг сунгасан.	90.0
167		10, 24-р хороодод сагсан бөмбөгийн талбай байгуулна.	Дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэрт сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг “Ноён барс” ХХК 24,9 сая төгрөгөөр хийхээр гэрээ байгуулсан боловч хүйтний улирал эхэлсэн тул 2016 оны хавар хийхээр гэрээг сунгасан. 10-р хорооны Зүүнбаян-Уулын 32-р гудамжны тоглоомын талбайн хажууд сагсан бөмбөгийн талбайн	90.0

			тохижилтын ажлыг “Мөнгөн оройт цамхаг” ХХК 49,9 сая төгрөгөөр хийж ашиглалтанд хүлээлгэж өгсөн. 24-р хорооны Зээлийн 29-р гудамжинд сагсан бөмбөгийн талбайн тохижилтын ажлыг “Вэлмот” ХХК 57,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	
168	5, 8, 9, 17, 19, 22, 30-р хороодод явган хүний зам, шат барьж, засварлана.		Дүүргийн 5-р хорооны Баянголын 14-р гудамжинд явган хүний зам тавих ажлыг 17,7 сая төгрөгөөр, 8-р хорооны Баянцагааны 1-р гудамж, Нуур, Булагтын нарийн гудамжинд явган зам тавих ажлыг 51 сая төгрөгөөр, 19-р хорооны нутаг дэвсгэрт явган хүний зам тавих ажлыг “Чанар”, “Амжилтын эхлэл”, “Прогресс” иргэдийн бүлгүүд 53,7 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн. 9-р хорооны Малчны 2-р гудамж, Уулын гудамжинд явган хүний зам тавих ажлыг “Чингисийн отог” ХХК 77,8 сая төгрөгөөр 2016 оны хавар хийж гүйцэтгэхээр гэрээгээ сунгасан. 17-р хороонд явган хүний зам тавих ажлын зураг, төсөв хийгдсэн. Үнэлгээ хийх шатандаа явж байна. 22, 30-р хороодод явган хүний зам барих ажлуудын хөрөнгийн асуудал шийдэгдээгүй тул хийгдээгүй.	70.0
169	7, 22, 26-р хороодод явган хүний гүүр барина.		7, 26-р хороодын нутаг дэвсгэрт баригдах явган хүний гүүрийн ажлуудын зургийн даалгавар, төсөв хийгдсэн. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарласан боловч шаардлага хангах материал ирээгүй тул үнэлгээний хороо шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэн дахин зарласан боловч аж ахуйн нэгжүүд материал ирүүлээгүй байна. Он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	30.0
170	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын газрын асуудлыг шийдвэрлэнэ.		-32-р хороо Эмээлтэд нийслэлийн төсвийн хөрөнгөөр малын гаралтай хог хаягдал устгах, боловсруулах үйлдвэр баригдахаар төлөвлөгдсөн газарт иргэн Батдэлгэр 300 метр урт хашаа барьсан байсныг хугацаатай шаардах хуудас өгч, хашааг буулган газар чөлөөлсөн болно. -Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус дүүргийн 32-р хороонд бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор баригдахаар төлөвлөгдөж барилгын ажлын трасст орсон 16 нэгж талбарын бүгдэд нь мэдэгдэл өгч, тухайн иргэдэд байршил өөрчлөж, газрыг чөлөөлсөн ба сургууль, цэцэрлэгийн барилга барих нөхцөл бололцоог хангасан болно. 22-ын товчооны уулзвараас мал бордох хүртлэх 1,7 км авто замын	90.0

			<p>трасст 27 нэгж талбар өртсөнөөс 3 иргэнтэй тохиролцож, үүнээс 2 иргэнд нь нөхөх олговор олгож, 1 аж ахуй нэгжийн нөхөх олговор олгох асуудал шийдвэрлэгдэхээр хянагдаж байгаа бөгөөд бусад иргэн, аж ахуйн нэгжтэй зөвшилцөж, баталгаажсан талбайнаас их газруудыг нөхөх олговоргүй татуулж, авто замын ажлыг саадгүй явуулж дууссан.</p> <p>6-р хорооны нутаг дэвсгэрт Гэр хорооллын дахин төлөвлөлтөөр Ханын материал орчмын барилгуудыг бохир ус татан зайлуулах ф500 мм-ийн шугам сүлжээтэй холбох угсралтын ажил хийгдэхэд трасст 14 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өртсөнөөс бүгдэдтэй нь тохиролцож, хашааг татуулж бохирын ус татан зайлуулах шугамыг саадгүй гүйцэтгүүлсэн болно.</p> <p>2013 оноос хойш он дамжин хийгдэж байгаа “Баянгол дэд станцаас Радио телевизийн дэд станц хүртэлх 24 км 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил”-ын нөлөөлөлд өртсөн СХД-ийн 25-р хороо, Зүүн салааны эцэст байрлах ДНДХ ХХК-ны захирал н.Батмагнайтай зөвшилцөн, тохиролцож цахилгааны Анкер босгох нүхийг ухуулж, суурилуулан цахилгаан дамжуулах агаарын шугамыг холбуулж уг ажлыг саадгүй явуулсан болно.</p> <p>“Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ-н захиалгаар Хангай захын уулзвараас 1 дүгээр хорооллын 34 дүгээр байрны арын гэр хорооллын зам хүртэл шинээр барих 1,3 км авто замын ажлын “Хангай” зах талаас 0,42 километр авто замыг “ЗЗБ” ХХК гүйцэтгээд байна. Дээрх хэсгийн авто замын трасст газар эзэмших эрхийн зөвшөөрөгдсөн талбайнаас илүү гарган блок болон банзаар барьсан нийт 2 нэгж талбарын хашааг нөхөх олговоргүй татуулж авто замын ажлыг саадгүй явагдах нөхцлөөр хангасан.</p>	
171	3.2.2. Дүүргийн томоохон гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийнэ.	2, 10, 24-р хороодын гадна орчныг тохижуулна.	<p>Дүүргийн 2-р хорооны байрны гадна тохижилтын ажлыг “Бид бүгдийг бүтээнэ” иргэдийн бүлэг 14,2 сая төгрөгөөр, 10-р хорооны гадна тохижилтын ажлыг “Хайрхан-25” иргэдийн бүлэг 18,1 сая төгрөгөөр, 24-р хорооны гадна тохижилтын ажлыг “Хамтын тэмүүлэл” иргэдийн бүлэг 17.0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэж ашиглалтанд хүлээлгэж өгсөн.</p>	100.0

172		2-р хороонд жишиг гудамж байгуулна.	2-р хорооны Орбитын 34-р гудамжинд 11,6 сая төгрөг, Орбитын 17-р гудамжинд 13,4 сая төгрөгөөр жишиг гудамж байгуулах ажлыг “Алтан багана” иргэдийн бүлэг, Орбитын 75-р гудамжинд Жишиг гудамж байгуулах ажлыг “Бүтээлч Сонгинохайрхан” иргэдийн бүлэг 18,9 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.	100.0
173		14, 20-р хороодод иргэдийн амрах талбай байгуулна.	14-р хорооны нутаг дэвсгэрийн 12-р байр болон 38-р байрны дэргэд нийтийн эзэмшлийн талбайд иргэдийн амрах талбайг “Юувокү” ХХК 49,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. 20-р хорооны шинэ цэргийн хотхоны 2, 6, 7-р байрны дунд иргэдийн амрах талбай байгуулах ажлыг “Баяжих галуут” ХХК 70,8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч хүйтний улирал эхэлсэн тул 2016 оны хавар хийхээр гэрээгээ сунгасан.	70.0
174		170-р цэцэрлэг рүү явдаг гудамжинд авто болон явган хүний зам тавихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж уламжилна.	Зүүн салааны авто замаас 170-р цэцэрлэг хүртэлх авто зам шинээр тавих ажлыг “Ринг роуд” ХХК 177,6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	100.0
175	3.2.3. Авто зам болон нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, дүүргийн нутаг дэвсгэр дэх рекламны байгууламжийг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан сайжруулан, орон сууц, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	Гэр болон орон сууцны хороололд нийслэлийн, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр гэрэлтүүлэг тавих ажлыг үргэлжлүүлнэ. /Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,3, 4, 22, 23, 25, 26, 30, 31-р хороодод/	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хорооны Толгойтын 97, 107-114-р гудамжуудад 53 ширхэг, 3-р хорооны Бага наран 45-7, 45-8, 39, 40-р гудамжуудад 40 ширхэг, 4-р хорооны Их нарангийн 11,16-р гудамжинд 36 ширхэг, 25-р хорооны Хайрханы 1, Хайрханы 1-ийн 51-97 тоот хүртэл Хайрханы 2-р гудамж, Хайрханы 2-ын 19-59, Хайрханы 2-ын 15-75а, Хайрханы 2-ын 214-250-р гудамжуудад 39 ширхэг, 30-р хорооны Хилчин хотхон А хэсэг, Хамба хэсгийн голоор 18 ширхэг, 31-р хорооны Дунд наран, Хайрхан гудамжуудад 57 ширхэг, 21-р хороонд 14 ширхэг гэрэлтүүлгүүдийг /536.2 сая төгрөг/ ашиглалтанд оруулсан. 26-р хороонд төлөвлөгдсөн 56.4 сая төгрөгийн 34 ширхэг гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэгчээр Хустайн шил ХХК шалгарсан боловч тендерээс татгалзан гэрээ байгуулаагүй байна. Гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан 2 компанид засвар үйлчилгээний зардалд 364.5 сая төгрөгийг гарган зарцуулсан байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 6.9 тэрбум төгрөгийн гэрэлтүүлгийн ажлын зураг хийгдсэн ба нийслэлийн 2016 оны нийгэм эдийн засгийн зорилтонд ажлыг гүйцэтгүүлэх хөрөнгийг тусгуулах саналаа хүргүүлсэн.	70.0

176	замаар асалтыг 95 хувьд хүргэнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийг орчин үеийн шийдэл бүхий өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй болгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	Нийслэлийн 2015 оны шилдэг тохижилт, ногоон байгууламжтай, цэмцгэр байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах уралдааны болзлын хүрээнд Москвагийн гудамж, ҮЭ-ийн гудамж зэрэг төв замын дагуу үйл ажиллагаа явуулдаг ААНБ-уудын гадна гэрэлтүүлэг реклам чимэглэлийг сайжруулах талаар дүүргийн Засаг даргын 05 дугаар албан даалгавар гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсанаар 90 гаруй хувь нь орчин үеийн шийдэл бүхий өнгө үзэмж сайтай гэрэлтүүлэгтэй болсон.	90.0
177		Орон сууцны хороолол, гэр хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, чимэглэлийн талаар мэдээллийн сангийн судалгааг цаг тухай бүр баяжуулна.	Энэ оны жилийн эцсийн байдлаар гэр хороололд 4463 ширхэг, орон сууцны хороололд 604 ширхэг, нийтийн эзэмшлийн зам талбайд 2324 ширхэг, нийт 7391 гудамжны гэрэлтүүлэгтэй байна. Гэрэлтүүлэг асалтын байдалд Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ болон дүүргийн Замын цагдаагийн тасагтай хамтран сард 2-оос доошгүй удаа үзлэг шалгалт явуулж ирсэний зэрэгцээ ашиглалтын хариуцдаг байгууллагуудын гэрэлтүүлэг асалтын мэдээг 7 хоног бүр авч, доголдож байгаа гудамж, замын гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг шуурхай гүйцэтгэн ажиллаж байгаагийн үр дүнд гэр хорооллын гэрэлтүүлгийн асалт 96.9 хувь, орон сууцны хорооллын гэрэлтүүлэгийн асалт 96.5 хувь, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн асалт 97.8 хувьд тус тус хүрсэн нь урьд оны мөн үеэс 1.2-2.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.	90.0
178		Толгойт хойгуурхи нийтийн эзэмшлийн замын гэрэлтүүлгийг шинэчлэн ЛЕД гэрэлтүүлэгчтэй болгоно.	Толгойт хойгуурхи замын гэрэлтүүлэг нь замын шинэчлэлийн ажилтай хамтатган хийгдэх бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2015 оны 8-р сарын 19-ны А/682 дугаар захирамжаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Гүйцэтгэгчийг шалгаруулах нээлттэй тендерийг 2015 оны 9-р сарын 2-ны өдөр зарлан 10-р сарын 5-ны өдөр нээж үнэлгээ хийхэд шаардлага хангасан материал ирүүлсэн аж ахуйн нэгж гараагүй байна.	-
179		Гудамж талбайд байрлуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн реклам, зар сурталчилгааны самбар, байгууламжид тавих хяналтыг сайжруулж, стандартын шаардлага	Дүүргийн Засаг даргын 2015 оны 3-р сарын 30-ны өдрийн А/95 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт 2015 онд мэдээлэл сурталчилгааны байгууламжаа байрлуулах 31 ААНБ-уудад зөвшөөрлийг олгон гэрээ хийснээр байгууламжийн хураамжаас дүүргийн төсвийн орлогод 114.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2015 оны 6-р сарын 11-ний өдрийн А/229	90.0

		хангасан хаягжилттай айл өрх, аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлнэ.	дүгээр захирамжаар нутаг дэвсгэр дэх стандарт бус, зөвшөөрөлгүй, хураамжаа төлөөгүй том, жижиг 78 байгууламж, хаягийг албадан буулгах арга хэмжээг дүүргийн Замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулсан. Нийслэлийн 2015 оны “Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай цэвэр цэмцгэр аж ахуй нэгж, байгууллага” шалгаруулах болзолт уралдааны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх аж ахуй нэгж байгууллагуудын 92 хувь нь стандартын шаардлагад нийцсэн хаягтай болсон гэсэн дүн мэдээ гарсан. Гэр хорооллын 11995 айл өрхийн хашаа, 940 гудамжны хаягжуулалтыг шинээр хийх судалгааг хороодоос авч нэгтгэн Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлсэн боловч хөрөнгийн асуудлаас шийдэгдээгүй байна.	
180	3.2.4. Автозам, орон сууцны доторхи зам, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд ахиц дэвшил гаргана.	Мэргэжлийн байгууллагын хүн, хүчийг нэмэгдүүлж, автозам болон орон сууцны хорооллын авто замуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд чанарын ахиц гаргана.	Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн 181350 м2 авто зам, 56120 м2 явган зам, хорооллын дундах 132269 м2 зам, 70770 м2 авто зогсоол, 537444 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээнд нийтийн эзэмшлийн зам талбайн 60 үйлчлэгч тогтмол ажиллаж байна. Цэвэрлэгээний байдалд 7-14 хоногт тогтмол хяналт тавин ажиллаж байна.	70.0
181	3.2.5. Тусгай зориулалтын зам, шат, хаалга байгуулах ажлыг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат хийнэ.	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат хийнэ.	Тамгын газрын байранд стандартын шаардлага хангасан налуу шатыг 4.2 сая төгрөгийн өртгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Сонгинохайрхан бие даан амьдрах төв”-өөр хийлгэсэн.	70.0
182	бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төвийн барилгын газрын асуудлыг шийдвэрлэнэ.	Тус дүүргийн 19-р хороонд “Сонгино” бие даан амьдрах төв хүсэлт гаргасныг дэмжин нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2015 оны 10-р сарын 12 –ны 1070 тоот албан бичгээр хүргүүлээд байна.	30.0
183	3.2.6. Дүүргийн цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.	13, 18-р хороодод цэцэрлэгт хүрээлэн байгуулж, тохижуулах замаар нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	13-р хороо 8,9-р байрны дунд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг “Хорго групп” ХХК 59,9 сая төгрөгөөр хийж ашиглалтанд хүлээлгэж өгсөн. 18-р хорооны цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын тендер зарлаж үнэлгээ хийсэн боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй байна.	70.0

184		Улаанчулуутын хогийн цэгийг суурьшлын бүсээс тусгаарлах цэцэрлэгт хүрээлэн байгуулах асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилна.	Хогийн цэгийг мод тарьж суурьшлын бүсээс тусгаарлах хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран судалж байна.	10.0
185		30, 31-р хороодын нутаг дэвсгэр Хамбын овооны орчим бичил цэцэрлэг байгуулна.	Нийслэлийн 2015 оны нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан 8, 23, 30, 31-р хороодын нутаг дэвсгэрийг хамарсан Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэнгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг, гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн боловч хөрөнгийн эх үүсвэр хүлээгдэж байна.	-
186	3.2.7. Тодорхой байршлуудад газар доорх болон давхар граж, авто зогсоол барих чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	Хүн амын нягтаршил ихтэй орон сууцны хороололд давхар граж, авто зогсоол барих боломжтой газрын байршлыг судлан, давхар граж, авто зогсоол барих чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	1-р хорооллын 19-р байрны ар талд давхар граж бүхий хүүхдийн тоглоомын талбай байгуулах тухай нийслэлийн Засаг даргын захирамж гарсан. Дүүргийн 15-р хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар иргэдийн дунд хэлэлцүүлэг хийсэн боловч дэмжлэг аваагүй. НИТХийн Тэргүүлэгчдийн тогтоолоор 2015 оны 10 сард журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдон тухайн ажил хойшилсон	30.0
Дөрөв. Экологи, байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана.				
187	4.1. Дулааны төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрээр хангах боломжгүй гэр хорооллын айл өрхүүдийг эрчим хүчний хэмнэлттэй зуух, боловсруулсан түлш болон утаа шүүгчээр хангаж халаалтын зуухнуудын тоног	100кв-аас дээш хүчин чадал бүхий усан халаалтын зуух ашиглаж буй зуух эзэмшигч иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад холбогдох байгууллагаас олгосон магадлан итгэмжилсэн дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулж, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 147 дугаар тогтоолоор батлагдсан “Халаалтын зуухны байгууламжийг магадлан итгэмжлэх тухай” журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрийн 24 аж ахуйн нэгжийн усан халаалтын зуухны байгууламжинд MNS5043-2001, MNS5041-2001, MNS5457-2005 стандартын дагуу “Магадлан итгэмжлэл олгох” хяналт шалгалтыг явууллаа. Шалгалтанд дүүргийн нутаг дэвсгэрт 100 кВт-аас дээш нэгж хүчин чадалтай усан халаалтын зуухны байгууламж ашиглаж буй төрийн өмчит ерөнхий боловсролын дунд сургууль - 10, цэцэрлэг - 5, худалдааны төв - 2, цэргийн анги - 4, Олон улсын хүүхдийн “Найрамдал” төв, “Улаанбаатар буян” ХХК, 7-р хорооны “Хилчин хотхон, “Ану сервис” ХХК, “Хоёулаа хүү” ХХК, “Талст эрчим” ХХК зэрэг нийт 24 иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа. Шалгалтын дүнгээс үзэхэд утааны хийн	90.0

	төхөөрөмжийг шинэчилнэ.		хэмжилт хангалтгүй 12, MNS5457:2005 стандартын 5.1.1-ийн заалтыг хангаагүй 9 болон бусад шалгуур үзүүлэлтийг хангаагүй халаалтын зуухны 7 аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж, зөрчлийг арилгуулсан. Сорьцийн цэг тавиагүй болон бусад үзүүлэлтээр “эрсдэлтэй” үнэлгээтэй үйл ажиллагаа явуулж байсан 1-р хорооны Ариун гүнгэрваа ХХК, 25-р хорооны Дагина эх ХХК, 7-р хорооны Хилчин хотхон, 107 дугаар сургууль зэрэг 4 аж ахуйн нэгжийг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын 2015 оны төлөвлөгөөт шалгалтанд дахин хамруулж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах шийдвэрийг ажлын хэсэг гаргалаа. 2015 оны 10 дугаар сард ажлын хэсэг дахин томилон ажиллуулж дүгнэлт гаргахад 5 аж ахуйн нэгж сорьцын цэг тавьсан бөгөөд судалгаа, хэмжилтийн баг ажиллуулж магадлан итгэмжлэх талаар дүгнэлт гаргуулах болно.	
188		Агаарын бохирдлын эх үүсвэрийг бий болгож буй цэгүүд, сайжруулсан зуухны хэрэглээнд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, сургалт сурталчилгаа зохион байгуулна.	НАЧА, МХГ-тай хамтран агаарын бохирдлын эх үүсвэрийг бий болгож буй ил галлагаатай дугуй засварын газрууд, ТҮЦ, павилонуудад хяналт шалгалтыг явуулж, 6 дугуй засварын газар, 2 ТҮЦ-д Мэргэжлийн хяналтын байгууллагаас хугацаатай албан мэдэгдэл өгч, зөрчлийг арилгуулсан. Хяналт шалгалтын дүнг үндэслэн зөрчил дутагдлыг цаашид гаргуулахгүй байх, гарч болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор 2015 оны 3-р сарын 2,3-ны өдрүүдэд “Зөвхөн Зуух” өдөрлөгийг Баянхошууны эцэс БОСА төвийн байранд “УБ-Цэвэр агаар” төслийн нэгж, Захирагчийн ажлын албаны Баянхошуу дахь албатай хамтран зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр зуухтай холбоотой асуудлаар Улаанбаатар цэвэр агаар төслийн ажилтнууд иргэдтэй нээлттэй ярилцлага хийж, мэдээ мэдээлэл, гэрээ байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, өргөдөл гомдол болон тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэсэн. “Халаатын зуухны байгууламжийг магадлан итгэмжлэх тухай” журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор нийслэлийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд зохион байгуулсан шалгалтаар албан шаардлага авсан ААНБ болон халаалтын зуух үйлдвэрлэгч нарт Нийслэлийн агаарын чанарын алба, Мэргэжлийн хяналтын алба, ЖАЙКА ОУБ-тай хамтран	90.0

			галлагааны горим, түүнээс улбаатай агаарын бохирдолд нөлөөлөх нөлөөллийг багасгах арга хэмжээний талаарх хэлэлцүүлгийг 2015 оны 4-р сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан судалгааны маягтын дагуу агаарын бохирдолтын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах журмын дагуу тоо бүртгэл явуулж дүнг нэгтгэсэн. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дулаан баригч бүтээгдэхүүнийг гэр хорооллын айл өрхүүдэд хөнгөлтэй үнээр борлуулахаар дүүргийн Засаг даргын Тамгын газар газар Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь салбартай “САНАМЖ БИЧИГ”-ийг байгуулж, 2015 онд хэрэгжүүлэх 14 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.	
189		Улаанбаатар-Цэвэр агаар төслийн 2014-2015 оны халаалтын улиралд хэрэгжүүлэх зуухны хөтөлбөрт зуухаа солиогүй үлдсэн айл өрхийг хамруулах ажлыг хороодтой хамтран зохион байгуулна.	Улаанбаатар-Цэвэр агаар төслийн 2014-2015 оны халаалтын улиралд хэрэгжүүлэх зуухны хөтөлбөрт 1, 2-р саруудад зуухаа солиогүй 317 айл өрхийг хамрууллаа. “Эко ресурс” ХХК-тай бүрэн шаталттай түлшний хэмнэлттэй зуухыг нийлүүлэх гэрээ байгуулж, хороодоос 2210 иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч, эхний ээлжинд 125 зуухыг нийлүүлээд байна.	90.0
190	4.2. Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий талбайд нөхөн сэргээлт, арчилгаа цэвэрлэгээ хийнэ.	Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий тодорхой талбайг нөхөн сэргээх, ойн арчилгаа цэвэрлэгээг хийх талаар мэргэжлийн байгууллагад санал хүргүүлж хамтран ажиллана.	21-р хорооны нутаг дэвсгэр Нарийны фермийн Хөндлөнгийн аманд ойн түймэр болон огтлолтонд өртсөн нарсан ойн 40 га талбайг ойжуулах 27.6 сая төгрөгийн санхүүжилт бүхий тендерт “Вэбтүүн” ХХК шалгарч Шинэс, нарс модны 2 настай тарьцыг 100000 ширхэг суулган намрын тооллого хийхэд 1 га-д 1910 ширхэг нийт 76400 ширхэг ургасныг тогтоож, нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газраас томилогдсон ойжуулалтын ажлыг шалгаж хүлээн авах комисс актаар хүлээж аваад байна.	100.0
191		22-ын товчооны орчим тарьсан модны арчилгаа, тордолгоонд анхаарч, хамгаалах зурвас хийх ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/109 дүгээр захирамжийн дагуу 1.5 сая төгрөгийн зардал гарган хавар, намрын цэнэг усалгаа хийж, хөрс сийрэгжүүлэх, тогоо гаргах зорилгоор хар шороогоор хучиж, хог ургамлыг устган зайлуулах ажлыг хийсэн. Уг байршилд тарьсан модыг хашиж хамгаалах, тордож ургуулах иргэдийн бүлэг ажиллуулах зорилгоор Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт “Ногоон хаалга” төсөл бичиж хүргүүлснээр уг	90.0

			төсөл шалгарч 9,7 сая төгрөгийн санхүүжилтээр хайс хамгаалалт хийсэн.	
192		Газар эзэмшигч, ашиглагч иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын эзэмшлээсээ 50 м хүртэл орчны нийтийн эзэмшлийн газрын тохижилт, цэвэрлэгээ, зам талбай, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг хариуцах үүргийг мөрдүүлж, хяналт тавьж ажиллана.	Дүүргийн нутаг дэвсгэрийн ААН, байгууллагуудтай байгуулсан Тохижилт цэвэрлэгээний гэрээний дагуу газар эзэмшигч, ашиглагч иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад 50 м хүртэл орчны нийтийн эзэмшлийн газрын тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ, ногоон байгууламжийн арчлалтыг хариуцуулж, түүнд хяналт тавин ажиллахын зэрэгцээ ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх арчилж тордох тухай дүүргийн Засаг даргын 2015 оны 05, 12 дугаар албан даалгавруудыг хүргүүлсэнээр нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагууд эзэмшил газартаа шинээр 19865м2 талбайг зүлэгжүүлж, 27500 ширхэг мод тарьсан.	100.0
193	4.3. Ногоон бүсийн хортон шавьж, өвчний тархалтын судалгаа хийж, хортон шавьж өвчний устгалыг 2000 га талбайд хийнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрийн ойн сан бүхий газарт ойн хөнөөлт хортон шавьж, өвчний тархалтанд мэргэжлийн байгууллагатай хамтран судалгаа хийж, устгалын ажлыг зохион байгуулна.	Ойн судалгаа хөгжлийн төвөөс дүүргийн нутаг дэвсгэрийн ойн сан бүхий тодорхой талбайд 04-р сарын 25-наас 06-р сарын 03-ны өдрүүдэд хөнөөлт хортон шавжийн тархалтын байдалд судалгаа хийсэн ба устгалын ажил хийх шаардлагагүй гэж үзсэн.	90.0
194	4.4. Нутаг дэвсгэрийн ногоон бүсийн тодорхой хэсгийг иргэдийн нөхөрлөлд хариуцуулах ажлыг судлан шийдвэрлэнэ.	21, 24, 25-р хороодын нутаг дэвсгэрийн ногоон бүсийн тодорхой хэсгийг хамгаалахаар иргэдээс ирүүлсэн санал, санаачлагыг судлан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал оруулан шийдвэрлүүлж, хамтран ажиллана.	Тухайн хороод, иргэдээс санал ирүүлээгүй байна.	-
195		Эзэмшил талбайдаа өөрийн хөрөнгөөр ногоон байгууламж хийж тохижуулсан аж ахуй нэгж, байгууллагыг олон нийтэд	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/115 дугаар захирамжаар “Шилдэг тохижилттой хороо, өрх, орон сууцны байр, гэр хорооллын гудамж” шалгаруулах 22.0 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдаан зарласны дагуу хийгдсэн ажлуудыг ажлын хэсэг дүгнэн “Шилдэг тохижилттой хороо”-гоор 9, 25, 29-р хороо, “Шилдэг	90.0

		сурталчлан урамшуулна.	тохижилттой өрх"-өөр 32-р хорооны иргэн Д. Болор, 25-р хорооны иргэн Л. Доржсамбуу, 7-р хорооны иргэн Д. Мижиддорж, "Шилдэг тохижилттой орон сууцны байр"-аар "Тохилог 21", "Итгэл", "Кремль СӨХ", "Шилдэг гэр хорооллын гудамж"-аар 25-р хорооны 9-р гудамж, 9-р хорооны 2-р гудамжнууд шалгарсан байна. Монголын ахмад багш нарын холбооноос бүх шатны боловсролын байгууллагуудын дунд зарласан болзолт уралдаанд орчноо цэцэрлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан 78, 84, 90, 101-р цэцэрлэгүүдийг дүүргийн зүгээс дэмжин Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт холбогдох мэдээ тайланг хүргэж шалгаруулалтанд оролцууллаа.	
196		Нийтийн эзэмшлийн талбай, сургуулийн орчинд тарьсан мод, зүлэг, цэцгийн мандал арчлах баг, "Эко бүлэг" –ийг ерөнхий боловсролын сургуулиудад байгуулан, зөвлөгөө өгч, хамтран ажиллана.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/322 дугаар захирамжаар Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сургууль орчмыг цэцэрлэгжүүлж, үлгэр жишээ тохижилттой, хоггүй цэвэр байлгах үйл ажиллагаанд хүүхэд залуучуудын идэвх оролцоо, санаачилгыг өрнүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөгөө өгөх үүрэг бүхий "Эко клуб"-ыг Ерөнхий боловсролын сургуулиудад байгуулж хамтран ажиллаж байна.	100.0
197		Туул голын дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт "Эко эргүүл" ажиллуулж, бохирдлоос хамгаална.	"Эко эргүүл" ажиллуулах ажлыг Нийслэлийн байгаль орчин ногоон хөгжлийн газраас зохион байгуулах байсан боловч хөрөнгийн асуудлаас шалтгаалан хэрэгжих боломжгүй гэж үзсэн байна.	-
198		Хашаандаа мод бут, сөөг өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан иргэнд урамшуулал олгох тогтолцоог хэрэгжүүлэн ажиллана.	Хашаандаа мод бут, сөөг өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан иргэдийн судалгааг гаргаж нийт 94 иргэний мэдээллийг Нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлэн хянуулж, 2.5 сая төгрөгийн урамшууллыг иргэдэд олгосон байна.	100.0
199	4.5. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах булаг, шанд, нуурын орчныг тохижуулж, хамгаалалтанд авах, ногоон бүс	8-р хорооны Гүнжийн нуурыг амралт, чөлөөт цагийн бүс болгох ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтарч байгалийн тогтоц, бүтцэд судалгаа хийж, хамгаалалтанд авах ажил	Газар зүй гео-экологийн хүрээлэнд 2015 оны 06-р сарын 17-ны өдрийн 01/1400 дугаар албан бичгээр судалгааны баг гаргаж хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн. "Төгс хурц консалтинг" ХХК 21-р хорооны Ар тахилтын амны булгийг шинээр тохижуулж, 25-р хорооны Ухнын амны булгийн хайс хашааг сэлбэж засварласан.	30.0

	бүхий уулын амуудад байгаль орчны орон тооны бус байцаагчийн тоог нэмэгдүүлнэ	зохион байгуулна. 21, 24, 25-р хороодын нутаг дэвсгэрийн ногоон бүс бүхий уулын амуудад байгаль хамгаалах зорилго бүхий морин эргүүл ажиллуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны 03-р сарын 24-ны өдрийн А/86 дугаар захирамжаар урамшуулалт 13 морин эргүүлүүдийг ногоон бүс бүхий 1, 21, 24, 25-р хороодын амуудад ажиллуулж ЗДТГ, дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран эргүүл хийж гүйцэтгэлээ.	100.0
201	4.6. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хайрга, шаврын орд ашигладаг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд жилбүр үзлэг, шалгалт явуулан, стандартад нийцэхгүй ордуудын үйл ажиллагааг зогсоох, нөхөн сэргээлтийг тусгай төлөвлөгөөний дагуу хийлгэнэ	Нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлэн хийж, мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллах, уулын дайрга хууль бусаар ашиглах үйл ажиллагааг таслан зогсоож холбогдох арга хэмжээ авна.	21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Хүй долоо худаг чиглэлийн 8,5 км авто зам тавихад авч ашигласан Төмөр замын 361 дүгээр гарамын баруун урд хэсгийн түр карьерийн 2,1 га талбай, Жаргалант-Батсүмбэр чиглэлийн 17 км хатуу хучилттай авто замын ажлын далангийн дүүргэлтэнд ашигласан 10,5 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийлгэж хүлээн авсан. НМХГ-ын даргын баталсан “Хайрга, дайрга, элс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-01/134 тоот удирдамжийн дагуу 3 аж ахуйн нэгжийг хяналт шалгалтанд хамруулаа. Үндэсний болон нийслэлийн Аудитын газруудтай хамтран 2015 оны төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүн”-д аудит хийлгэж дүгнэлт гаргаад байна. Дүүргийн МХХ, ТХ-үүдтэй хамтран аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан хяналт тавьж ажиллалаа. Дүүргийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа 16 аж ахуйн нэгж байгууллагуудаас 11 ААНБ хөрөнгө санхүү, бусад шалтгааны улмаас 2015 онд үйл ажиллагаагаа зогсоосон байна.	70.0
202		Дүүргийн нутаг дэвсгэр дэх түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулна.	Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/254 дүгээр захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасны дагуу нөхөн сэргээлтийн арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүүргийн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд	90.0

			байршуулж, ашигт малтмал ашигласны төлбөр 20,4 сая төгрөгийг дүүргийн 2601002819 дансанд оруулсан.	
203	4.7. Хөрс, ус, орчны бохирдлыг багасгахад	“Эрүүл орчин-Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилийн эцсийн байдлаар биелээгүй 5 заалт, 30 хувьтай 2, 50 хувьтай 19, 70 хувьтай 20, 100 хувьтай 11 заалт байна.	70.0
204	гадаадын төслийн дэмжлэг авч хамтран ажиллана.	Орчны бохирдлыг багасгах, гэр хорооллын хог хаягдлын менежментийг сайжруулах ажилд Азийн сан ТББ-тай хамтран ажиллан үр дүнг тооцож, олон нийтэд мэдээлнэ.	Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Азийн сан ТББ-тай хамтран Гэр хорооллын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн 2015 оны 4-р сар хүртэл хийсэн ажлын үр дүнг тооцож МҮТВ-ээр нэвтрүүлэг 1 удаа хийсэн. Азийн сантай хамтран хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудтай хийх гэрээг шинэчлэн хийж, гэр хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх иргэдийн 3 бүлгийг 55 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан 8-р сараас эхлэн ажиллуулж хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд сар тутам 38.2 сая төгрөгийн санхүүжилтийг нийслэлийн төсвөөс авч байна.	90.0
205		Гэр хорооллын хороодын бохирын цооног, 00-ыг ариутгалын ажилд хяналт хийж, холбогдох арга хэмжээ авна.	Улаанбаатар хотын ЗАА-ны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэстэй хамтран гэр хорооллын бохирын цооног, 00-ыг ариутгах, хөрсний ариутгал хийх ажлыг хийлгэхээр “Бакс анд”, “Орхон овоот” ХХК-ниудтай гэрээ байгуулж, 5, 7, 23 дугаар хороодын нутаг дэвсгэрийн 36817 м/кв талбайд хийж гүйцэтгэсэн.	90.0
206		Хог хаягдлыг ангилан ялгах тогтолцоог нэвтрүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, зориулалтын хогны уутны хэрэглээг хэвшүүлнэ.	Хог хаягдлын зориулалтын уутыг өрхөд тараах, хэрэглээг нэвтрүүлэх санхүүжилт зогссон тул 2015 онд хог хаягдлын зориулалтын уут өрхөд тараагдаагүй. Хог хаягдлын шинэ менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын уутанд хийж хэвшүүлэх ажил төрийн өмчит байгууллагуудад хийгдэж байна.	90.0
207		Зуслангийн хог хаягдлын цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах зорилгоор “Ам бүрт-эко үйлчлэгч” менежментийг үргэлжлүүлнэ.	Зуслангийн ногоон бүс, гэр хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлын цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах зорилгоор 2015 оны 8-р сарын 1-нээс эхлэн хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын дэргэд 55 хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлгийг байгуулан ажиллаж байна.	100.0
208	4.8. Хог хаягдлыг тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллагыг	Нийтлэг үйлчилгээний төвийн гражийн барилгын ажлыг дуусгана.	“Сонгинохайрхан” Нийтлэг үйлчилгээний төвийн гражийн барилгыг өөрийн хөрөнгөөр барьж барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Хөрөнгийн эх үүсвэргүйгээс шалтгаалан барилгын ажил дуусаагүй байна.	70.0

209	сонгон шалгаруулж, Тээвэрлэлт үйлчилгээний төв, Нийтлэг үйлчилгээний төв,	Хог тээврийн болон авто зам цэвэрлэгээ арчилгааны тусгай зориулалтын техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Хог тээврийн болон нийтийн эзэмшлийн зам талбай цэвэрлэх зориулалтаар дүүргийн хэмжээнд хог тээврийн машинд өөрөө ачих төхөөрөмж 20, цинкен хогийн сав 200, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний техник хэрэгсэл 12 ширхэгийг авах судалгаа тооцоо гарган Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.	30.0
210	Тохижилт үйлчилгээний компаний	Гэр хорооллын айл өрхийн хогийг сард 2 удаа хашаанаас нь авах ажлыг хэвшүүлнэ.	Гэр хорооллын өрхийн хог хаягдлыг хашаанаас нь сард 1,75 удаагийн давтамжтайгаар авч байна.	90.0
211	материаллаг баазыг нэмэгдүүлэн хур хогийн цэггүй дүүрэг болно.	Хог хаягдал үүсдэг болон үүсч болзошгүй газруудыг камержуулах ажлыг эхлүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хог хаягдал үүсдэг 13 байршлын судалгааг гаргасан. Судалгаанд үндэслэн 20-р хорооны нутаг дэвсгэрт Төгс зуурмаг ХХК-ны зүүн талын 100 м/кв талбайн хог хаягдлыг Улаанбаатар шинэчлэл ХХК-аар цэвэрлүүлэн камержуулах ажил хийгдсэн.	50.0
212		Нарангийн энгэрийн хогийн цэгт аюултай хог хаягдал устгах, саармагжуулах байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	"Эрүүл мэндийн салбар хөгжлийн хөтөлбөр-5" төсөл дээр ажиллаж байгаа Канадын зөвлөхөөс эмнэлгийн хог хаягдлыг устгах, саармагжуулах байгууламжийн тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хүчин чадал, ерөнхий шаардлагыг гаргаж өгөөгүй байгаа учраас Архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулах боломжгүй байгаа болно.	-
213		Хог хаяхгүй байх ухамсрыг төлөвшүүлэх талаар иргэд олон нийт, хувийн хэвшлийнхэнд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион явуулна.	Хороодын нутаг дэвсгэрт тохижилт, хог хаягдлын чиглэлээр хяналт тавьж, хууль журмын хэрэгжилтийг хангуулж ажиллах Тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагчид болон хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн дунд хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх сургалт, сурталчилгааны ажлыг 156 удаа зохион байгуулж, нийт 2600 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна.	100.0
Тав. Нутгийн захиргааны байгууллагын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоно.				
214	5.1. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод байлган, иргэдэд	Хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах ажлыг тухай бүр зохион байгуулж, дүүргийн эрх зүйн нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, үйл ажиллагаандаа	Дүүргийн Засаг даргын 490 захирамжийг www.ublegal.mn мэдээллийн цахим хуудсанд байршуулж, эрх зүйн нэгдсэн мэдээллийн сан үүсгэн, иргэд, албан тушаалтнууд үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна. Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр 194 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, 56 иргэнд хууль эрх зүйн сангаас хууль, тогтоомжийн лавлагааг	90.0

	хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэн, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрт иргэдийн санал бодлыг	ашиглана.	олшруулан хүргэсэн. Нийслэлийн өмгөөлөгчийн холбоотой хамтран "Өмгөөлөгч-танд тусалъя" арга хэмжээг зохион байгуулж, 68 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгсөн. "Захиргааны ерөнхий хууль"-ийн төслийн хэлэлцүүлгийг Их Засаг их сургуулийн багш нартай хамтран төрийн байгууллагуудын 28 дарга, эрхлэгч, 35 иргэнд зохион байгуулж, гарсан саналыг нэгтгэн Хууль зүйн яаманд хүргүүлсэн.	
215	тусган хэрэгжүүлж, төрийн боломжит зарим үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлан ажиллана.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадтай холбогдолтой мэдээллийг төрөлжүүлэн, хувийн хэргийн сан үүсгэнэ.	Дүүргийн Засаг даргын дэргэдэх 30 хэлтэс, албадад хувийн хэргийн сан үүсгэж, байгууллагын танилцуулга, албан тушаалтнуудын судалгаа, мэдээлэл, үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт дээд шатны байгууллагаас ирсэн тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилт, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт, бусад цаг үеийн холбогдолтой нийслэл, дүүргийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтүүдийг байршуулсан нэг жигд хавтас нээж, төрөлжүүлсэн.	100.0
216		Дүүргийн мэдээллийн цахим хуудсаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа болон төрийн үйлчилгээний талаар санал, асуулга явуулна.	Дүүргийн www.shd.mn цахим хуудсаар Нэг цонхны үйлчилгээний чанар хүртээмжийн талаар санал асуулга явуулахад нийт хэрэглэгчийн хандалтын тоо 44471. Үүнээс "Та манай нэг цонхны үйлчилгээнээс хүссэн үйлчилгээгээ цаг хугацаандаа авч чадаж байна уу" гэсэн санал асуулгад оролцогсодын 58,3 хувь нь "Тийм" 9,9 хувь нь "Мэдэхгүй", 31,8 хувь "Үгүй" гэж хариулсан байна. Мөн 129 иргэнээс Нэг цонхны үйлчилгээний чанар хүртээмжийн талаар судалгаа авахад оролцогсодын 80,8 хувь нь хүссэн үйлчилгээг цаг хугацаа хэмнэн, ая тухтай нөхцөлд авч чадаж байгаагаа илэрхийлсэн бол 19,2 хувь нь "үгүй" гэсэн хариулт өгсөн. Судалгааг 14 хоногт 1 удаа нэгтгэн, дүүргийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар танилцуулж, үр дүнг тооцон ажиллаж байна.	90.0
217		Ажлаа иргэдэд сурталчлах, тайлагнах зорилгоор нутгийн захиргааны байгууллагуудын "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх 27 хэлтэс, албад, 32 хороод иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилж, тайлагнах зорилготой нийт 12000 гаруй иргэн, 120 орчим аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулсан "Иргэдийн баяр-2015" баяр наадмын арга хэмжээг 6-р сарын 20-ны өдөр Хүй долоон худагт зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэж, өргөдөл, гомдол, хүсэлтийг барагдуулах ажлыг давхар зохион байгуулсан. Хувийн	90.0

			<p>хэвшлийн байгууллагууд болох “Талх чихэр” ХХК, “Эбридигм Монголиа” ХХК, “Хишиг арвин индустриал” ХХК, “ХКҮ” ХХК, “Илч хангай” ХХК-иуд баяр наадмын үйл ажиллагааг хамтран зохион байгуулж оролцлоо. Дүүргийн Хөдөлмөрийн хэлтсээс үйл ажиллагаагаа сурталчилан “Ажилтай, орлоготой Сонгинохайрханчууд” тайлант өдөрлөг зохион байгуулж, нийт 250 иргэнд мэдээлэл түгээж, 63 иргэнд зуучлалын мэдэгдэл өгч, ажилд зуучлан, 54 иргэнийг мэргэжлийн ур чадвар олгох түр сургалтанд бүртгэв. Мөн 10 аж ахуйн нэгж, байгууллага хүний нөөцийн бүрдүүлэлт хийж хамтран ажилласан. Өдөрлөгийн үеэр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд амжилттай сайн нэвтрүүлсэн “Сүү” ХК, “Хаан Хүнс” ХХК, “Тэсо” ХХК-иудыг, дүүргийн Засаг даргын нэрэмжит өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулав. Бүртгэлийн хэлтсээс “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 4 удаа зохион байгуулж, 684 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, 586 иргэнд гарын авлага, материал тарааж ажиллав. “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй явуулж, иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 6-р сард Цагдаагийн 1-р хэлтэс “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 18, 19-р хорооны нутаг дэвсгэрт 2 үе шаттай зохион байгуулж, 230 гаруй иргэнийг хамруулан, төрийн үйлчилгээг хүргэв. Хууль зүйн яам, дүүргийн ИТХ, Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэстэй хамтран 2015 оны 9-р сарын 9-ний өдөр “Соёмбо кино театрын урд талбайд “Иргэн ба хууль” арга хэмжээг зохион байгуулж, 400 гаруй иргэдийн төлөөлөл оролцсон</p>	
218	Архивын захирамжлалын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэн, нээлттэй ил тод хэлбэрээр Тамгын газрын цахим хуудсанд байрлуулах ажиллагааг тогтмолжуулна.	Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтанд цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамжийн хүрээнд 2003-2012 оны захирамжуудыг цахим хэлбэрт шилжүүлж, нийслэлийн Архивын газарт хүргүүлэв. 1992-2002, 2013, 2014, 2015 оны захирамжуудыг www.lavlagaa.ub.gov.mn болон shd.mn сайтад байршуулсан.	90.0	
219	Дүүргийн төрөлжсөн архивыг байгуулж, өрөө, тасалгааны багтаамжийг нэмэгдүүлж,	Хадгаламжийн санг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн архивын өрөөний засварын ажлыг 3.6 сая төгрөгийн өртөгтэй хийж гүйцэтгэн, 26 м ² талбай бүхий нэмэлт өрөөг шинээр гаргаж тохижуулан	100.0	

	шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.	хадгаламжийн сангийн зориулалтаар ашиглаж байна. Дүүргийн архивт шаардлагатай тоног төхөөрөмжүүд болох нягтруулсан шүүгээ 10 ш, үзүүлэлт өндөртэй /15-тай/ компьютер 1 ш, зөөврийн шат зэрэг нийт 8,6 сая төгрөгийн өртөг бүхий стандартад нийцсэн техник хэрэгслээр хангасан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны А/238 дугаар тушаалаар 8 хэсэг 96 заалттай архивын зааврыг боловсруулж батлуулан 2015 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.	
220	1, 14, 15, 17-р хороодын иргэний танхимыг тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хороонд 13.0, 14-р хороонд 10,7, 15-р хороонд 12.0, 17-р хороонд 48,7, нийт 84,5 сая төгрөгийн өртөгтэй иргэний танхимд шаардагдах техник, тоног төхөөрмжийг нийлүүлсэн. Мөн тендэрт шалгарсан “Жавхлан хүслэн” ХХК, ЗДТГ-тай байгуулсан № 03, 04 тоот гэрээний хүрээнд, 3, 4, 26-р хороонд утасгүй интернэт, 1, 8-р хороонд иргэний танхим тохижуулах тоног төхөөрөмж, 10-р хороонд чийрэгжүүлэлтийн танхим, 2-р хороонд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг тус тус нийлүүлсэн.	100.0
221	Нутгийн захиргааны байгууллагуудын иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.	Цагдаагийн I, II хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Замын цагдаагийн тасаг, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төв, Өмч, газрын харилцааны алба, Хөдөлмөрийн хэлтэс зэрэг 8 байгууллагуудын өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гарган зөвлөмж хүргүүлээ.	100.0
222	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөнт машинаар алслагдсан байршлын иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлнэ.	Төрийн үйлчилгээний Нэг цэгийн хөдөлгөөнт машины тоног төхөөрөмжийн болон үнийн судалгааг “МХМ” авто центр болон бусад алслагдсан дүүргүүд дээр хийж, үнийн санал авсан боловч хөрөнгө мөнгөний боломжгүй болсон тул уг ажлыг хойшлуулсан болно.	10.0
223	Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машины тоог нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилна.	2014 оны жилийн эцсийн хүн амын судалгааг үндэслэн хүн ам ихтэй, алслагдсан 10, 24-р хороодод шинээр ТҮЦ машин тавих, дүүргийн ЗДТГ-ын байранд 1 ТҮЦ машин нэмж байршуулах талаар Үндэсний дата төвд албан бичгээр хандсан бөгөөд тус төвөөс 6-р сарын 12-ны өдөр ЗДТГ-ын байранд 1 ТҮЦ машин нэмж байрлууллаа. Нийт 11 ТҮЦ машин ажиллаж байгаа бөгөөд иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн 16 нэр төрлийн лавлагааг 313000	100.0

			иргэнд хүргэж үйлчилсэн байна.	
224		Хороодын (4, 9, 16, 25, 29, 32) иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цонхны хэлбэрт бүрэн шилжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Хороодоос иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нэг цонхны үйлчилгээний хэлбэрт шилжүүлэх судалгааг шинэчлэн гаргаж нийслэлийн Иргэдийг хүлээн авах төвд хүргүүлэв. 4, 9, 25, 32 -р хороод өөрсдийн нөөц бололцоог ашиглан төрийн үйлчилгээг нэг цонхны хэлбэрт шилжүүлэн, ажиллаж эхэлсэн. Хороодоос иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавьж, хороодыг нэг цонхны үйлчилгээний шинэлэг хэлбэрт шилжүүлэх ажил 87,5 хувьтай хэрэгжиж байна.	90.0
225		Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилна.	Дүүргийн ЗДТГ болон нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулсан арга хэмжээ, цаг үеийн хобогдолтой нийт 195 мэдээ мэдээллийг бэлтгэн shd.mn сайтад байршуулсан бөгөөд 98 мэдээ мэдээлэл бэлтгэн 12 телевиз, 6 сонин, 19 сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилж ажилласан. Засаг даргын 2013-2016 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2013, 2014 оны явцын талаар 20 минутын нэвтрүүлэг бэлтгэн Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалтуудын үеэр иргэд, олон нийтэд танилцуулсан. Дүүргийн Засаг даргаар ахлуулсан төлөөлөгчдийн Япон Улсын Изүнокүни хотод хийсэн айлчлалын талаар 20 минутын тайлан нэвтрүүлэг бэлтгэн дүүргийн ЗДТГ-ын байрны урд талын дэлгэц, shd.mn сайт, Ухаалаг дэлгэцээр иргэд олон нийтэд сурталчилан ажиллав. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд, хэлтэс албад, хороодын уялдаа холбоог сайжруулах, мэдээллээр хангах зорилготой “Дүүргийн мэдээ” мэдээллийн хуудас нийт 26 дугаарын мэдээ мэдээллийг боловсруулан А-4 хэмжээтэй, 4 нүүрээр эхийг бэлтгэж, тус бүр 100 ширхэгээр хэвлүүлэн тараалаа. Facebook хуудсыг тогтмол хөтлөн өдөр тутам мэдээ, мэдээлэлээр баяжуулж ажилласан. Иргэдээс вэб сайт болон Facebook хуудсаар ирүүлсэн 387 санал хүсэлтийг хүлээн авч холбогдох хэлтэс албадад хүргүүлэн, хариу өгсөн байна.	100.0
226	5.2. Шинээр дүүрэг байгуулах асуудлыг боловсруулан саналыг холбогдох байгууллагуудад	Шинээр дүүрэг байгуулах саналыг холбогдох дээд газарт уламжилна.	Дүүрэг хуваах асуудлыг дэмжих эсэх талаар 32 хорооны 31.4 мянга орчим иргэдийн дунд асуулга зохион байгуулахад 74.8 % нь тийм, 25.2 хувь нь үгүй гэсэн санал өгсөн байна. Шинээр дүүрэг байгуулахад шаардагдах төсөв зардлын тооцоо, өрх, хүн амын тоог харгалзан 2 хувилбар боловсруулан дүүргийн ИТХ-ын Ажлын	100.0

	тавьж шийдвэр- лүүлнэ.		албанд хүргүүлсэн.	
227	5.3. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ.	9, 10, 11, 28, 30, 31-р хороодыг өндөр хурдны шилэн кабельд холбоно.	Нийслэлийн мэдээллийн технологийн газар болон Улаанбаатар хотын хороодын шилэн кабель засварын тендерт шалгарсан МТМК компанитай хамтран дүүргийн 9, 10, 11, 28-р хороодыг шилэн кабельд холбох ажлыг энэ оны 6-р сард хийж гүйцэтгэлээ. 4-р сард 30 болон 31-р хороодод бага зардлаар, найдвартай шилэн кабель хэрхэн татах судалгааг мэргэжлийн байгууллагын багийнхантай хамтран гүйцэтгэж, Нийслэлийн мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Уг судалгаанд үндэслэн 10-р сард 30, 31-р хорооны шилэн кабель татах ажлыг Нийслэлийн мэдээллийн технологийн газартай хамтран хийж гүйцэтгэлээ.	100.0
228		www.shd.mn цахим хуудасны технологийг шинэчлэн сайжруулж, мэдээ мэдээлэл оруулах ажлыг хялбаршуулна	Төрийн байгууллагын цахим хуудсанд тавих шаардлага болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад тогтоол шийдвэрийг судлаж өөрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах ерөнхий шаардлагыг боловсруулан дотоод нөөц бололцоог ашиглан технологийн өөрчлөлт болон цахим хуудасны бүтэц агууллагыг шинэчлэн сайжруулсан. 2015 онд шилэн дансны тухай хууль хэрэгжиж цахим хуудасны үндсэн цэсэнд байршуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын нөөц хөрөнгө, Төрийн сан зэрэг линкүүдийг холбож өгсөн. Цахим хуудсанд байршиж буй цэсүүдийн нэршлийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэршлээр буюу ойлгомжтой байдлаар өөрчилсөн. Өргөдөл гомдол, санал хүсэлтийг зөвхөн цахим хуудсаар авах нь хязгаарлагдмал байсан тул Нийслэлийн иргэд хүлээн авах төвийн өргөдөл гомдол, санал хүсэлтийн цахим систем рүү хандах боломжтой болгосон. Мөн цахим хуудасны админы удирдлагын түвшинд дэд админууд файл upload хийх боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Ингэснээр дэд админууд их хэмжээний хүснэгтэн файл зэргийг цахим хуудас руу оруулахад заавал FTP account –аар нэвтэрч файл хуулах шаардлагагүй болсон. Ингэснээр мэдээлэл оруулах ажлыг хөнгөвчилж, ойлгомжтой болгосон.	100.0

229		Шилэн кабельд холбогдсон хороодыг онлайн сүлжээд холбон иргэний гэр бүлийн байдлын зарим үйлчилгээг иргэдэд хүргэнэ.	Иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хорооноос үзүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, дүүргийн 28 хороодыг иргэний бүртгэлийн онлайн систем болон бусад цахим сүлжээнд холбож үзүүлэх үйлчилгээний төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлэн ажиллаж байна. Ингэснээр шилжилт хөдөлгөөний, гэрлэсний, гэрлэлт цуцалсны /шүүхийн журмаар/, гэрлэлт сэргээсний, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээний дахин олголтын, иргэний үнэмлэхийн, оршин суугаа хаягийн лавлагааны зэрэг 10 төрлийн үйлчилгээг эхний ээлжинд хорооны түвшинд бүртгэлийн үйлчилгээг цахим сангаас иргэнд шуурхай үзүүлж байна.	90.0
230		Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэлийн зарим лавлагааг хорооноос олгоно.	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн лавлагааг хорооноос олгох ажлын техник тоног төхөөрөмж, програм хангамжийн судалгаа хийгдэж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Засгийн газрын 212 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Үндэсний дата төв” УТҮГ-т шилжүүлэн байршуулсан иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл солилцох нөхцлийг бүрдүүлж дүүргийн нутаг дэвсгэрт ажиллаж буй 11 ширхэг ТҮЦ машинаар дамжуулан иргэний бүртгэлийн, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй эсэх лавлагаа, иргэний үнэмлэх дахин авах хүсэлт илгээх зэрэг үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	70.0
231	5.4. Дүүргийн нутгийн захиргааны ордон барина.	Нутгийн захиргааны ордон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжилна.	Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 9-р хуралдаанаар дүүргийн цагдаагийн 1-р хэлтсийн өмнөх эрүүлжүүлэх байрыг буулгаж, барихад шаардагдах 410 сая төгрөгийг шийдвэрлэж баталсан. Нутгийн захиргааны ордны зураг төсвийг хийлгэх зөвлөх үйлчилгээний тендерийг сонгон шалгаруулж, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2015 оны 1-р сарын 16-нд хүргүүлсэн бөгөөд төсөв мөнгөгүй шалтгаанаар тендер буцаагдсан. нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын төсөлд тусгуулахаар саналаа дүүргийн Засаг даргын 2015 оны 01/1273 тоот бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын төсөлд тусгуулахаар саналаа дүүргийн Засаг даргын 2015 оны 01/1273	100.0

			тоот бичгээр хүргүүлсэн.	
232	5.5. Бүх хороодыг цогцолбор байртай болгоно.	8-р хорооны байрыг ашиглалтад оруулна. 6,16-р хороодын цогцолбор байр барих хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилна.	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд нийт 481.3 м ² барилгажих талбайтай, 50 айлын орон сууц, 8-р хорооны цогцолбор байрны тендэр зарлагдан, “Эх тэргүүн” ХХК шалгарч, барилгын гүйцэтгэл 90 гаруй хувьтай явагдаж байна. Цогцолбор барилгыг энэ оны 12-р сард дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2015 оны 3-р сарын 13-ны өдрийн А/78 дугаар захирамжаар “Дүүхээ-2” төвийн хойд талд байршилтай 0,05 га газрыг 6-р хорооны цогцолбор байр барих зориулалтаар газрын зөвшөөрөл олгосон. 16-р хорооны цогцолбор байрны асуудлыг УИХ-ын гишүүдэд уламжилж, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилт, улс, нийслэлийн хөрөнгө оруулалтанд тусгуулахаар саналаа дүүргийн Засаг даргын 2015 оны 01/1273 тоот бичгээр хүргүүлсэн	70.0
233	5.6. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг	Албан хаагчдыг мэргэшүүлэх, урт, богино хугацааны гадаад, дотоодын сургалтанд хамруулна.	Төрийн албаны зөвлөл, салбарын яамд, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төслийн байгууллагуудын мэргэжлийн болон мэргэшүүлэх урт, богино хугацааны сургалтанд давхардсан тоогоор 1200 гаруй албан хаагчдыг хамруулсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх урт хугацааны сургалтанд 4, богино хугацааны мэргэшсэн сургалтанд ЗДТГ-аас сургалтын зардлыг шийдвэрлэж 7, архивын чиглэлээр ОХУ-д 1, Япон улсад туршлага судлахаар 8, Хайлаар хоттой хамтран ажиллах гэрээ байгуулан туршлага судлахаар 4 албан хаагчийг тус тус хамруулсан.	90.0
234	сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх талаар сургалт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Авлига, ёс зүйн талаар сургалт, сурталчилгаа явуулах, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх ажлыг зохион байгуулна.	УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг дүүргийн төрийн албан хаагчдад Тамгын газрын мэдээллийн цагт болон мэдээллийн самбараар танилцуулж, www.shd.mn цахим хуудсанд байршуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны тухай “ХАСХОМ мэдүүлэгчдэд зориулсан сургалт”, “Шударга монгол хүний 7 дадал” сэдэвт сургалт, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, холбогдох журмын талаар хийгдсэн 5 удаагийн сургалтанд Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албадын 110 хаагчдыг хамруулж гарын авлага, хэвлэмэл хуудсыг тараан өгсөн. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2015 оны 4-р сарын	100.0

			21-ний өдөр холбогдох хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах зорилгоор дүүргийн төсвийн байгууллагуудын 32 албан хаагчдын дунд Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын эсрэг хамтдаа-2015” АХА тэмцээнийг зохион байгуулсан. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолыг албан хаагчдад танилцуулж, www.shd.mn цахим хуудсанд байршуулав. Дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”, Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, төрийн байгууллагуудад зөвлөмж гаргасан.	
235		Дүүргийн ёс зүйн зөвлөл болон ёс зүйн хорооны үйл ажиллагааны талаар дүүргийн цахим хуудсанд тухай бүр байршуулан ажиллана.	Дүүргийн ёс зүйн зөвлөлийн хурлыг 1 удаа хуралдуулж, 6 төрийн албан хаагчийн асуудлыг хэлэлцэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвлөмж хүргүүлж ажиллав. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 136 албан хаагчаас ёс зүйн баталгаа гаргуулж авсан. Шинээр ажилд томилогдсон төрийн захиргааны 11 албан хаагчид төрийн албан хаагчдын эрмэлзэх 9 зүйл, ёс зүйн дүрмийг танилцуулж, www.shd.mn цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.	90.0
236	5.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, дээрх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмын эргүүлд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Цагдаагийн 3-р хэлтэстэй хамтран Өнөр бүсийн хороодын төрийн албан хаагчид, иргэд, “Монос”, “Чингэс соосэ” дээд сургуулийн төгсөх ангийн нийт 36 оюутны оролцоотой “Оюутан эргүүл”, “Ач” анагаах ухааны их сургуулийн 300 оюутан сурагчдтай хамтран “Хүүхэд хамгаалал” эргүүл, хяналтын арга хэмжээг тус тус зохион байгуулав. Нийслэлийн ИТХ-ын 2015 оны 7-р сарын 3-нд батлагдсан “Хөршийн хяналтын хөтөлбөр, Хөршийн хяналтын журам”-ыг иргэд олон нийтэд сурталчлах, туршлага хуваалцах, харилцан мэдээлэл солилцох нөхцөл бололцоог бүрдүүлэхийн зэрэгцээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчлан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой Цагдаагийн 3-р хэлтэстэй хамтран “Хөршийн өдөр” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд “Хөршийн хяналтын хөтөлбөр”, “Хөршийн хяналтын журам”-ыг иргэд олон нийтэд сурталчлан зурагт хуудас, санамж, зөвлөмж тараав. Арга хэмжээнд 32 хороодын 256 алба хаагчид, хэсгийн ахлагч нартай хамтарч, сурталчилгааны 3875	100.0

			<p>ширхэг материалыг иргэдэд тараан өгч, нийт 1536 иргэн хамрагдав. Оролцсон иргэдийн дунд шатар, даам, олс таталт, явган аялал, Аха зэрэг уралдаант тэмцээнийг зохион байгуулж олны танил иргэдийг урьж, яриа хийлгэн хороо хариуцсан мөрдөн байцаагч, хэсгийн байцаагч нар эрх зүйн зөвлөгөө өгч, явц, үр дүнг ТВ-5, Монгол телевизээр сурталчилж, дүүргийн цахим хуудсанд байршуулсан. Иргэд оршин суудаг хороо, хэсгийнхээ гэмт хэрэг зөрчлийн дүн мэдээтэй танилцаж, иргэдийн сайн дурын санаачилгаар 1, 2, 4, 18, 19, 20, 21, 26, 27, 32-р хороодод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий иргэдийн сайн дурын 36 бүлгэмийг шинээр байгууллаа. Дүүргийн Цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж байгаа хулгай, танхайн гэмт хэргийг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн өмч хөрөнгөө хамгаалах ухамсарыг дээшлүүлэх, хөршийн холбоо хамгаалалтыг шинээр бий болгох, гэмт хэрэг гарч буй цэгүүдэд эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлж иргэдтэй хамтран ажиллах зорилгоор хороодын дунд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт 3.0 сая төгрөгийн шагналын сан бүхий болзолт уралдааныг 2015 оны 4-р сарын 06-ны өдрөөс 6-р сарын 1-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Аяны хүрээнд давхардсан тоогоор 39 чиглэлд 32 аж ахуйн нэгж, байгууллага, 1206 иргэн эргүүлийн үүрэг гүйцэтгээд байна.</p>	
237		<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай оролцсон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгоно.</p>	<p>Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эргүүлийн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг оролцоог нэмэгдүүлэх нь” 2 сарын болзолт уралдааныг зарлан, давхардсан тоогоор 450 чиглэлд нийт 2300 иргэн, 250 аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж хулгайн болон бусад төрлийн гэмт хэрэг буурсан 4, 18, 26-р хороодын Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, Хэсгийн байцаагч нарыг шалгаруулсан. Мөнгөн урамшуулалд дүүргийн Засаг даргын 2015 оны А/369, А/370 дугаар захирамжаар 4.1 сая төгрөгийг зарцуулсан. Цаашид уг арга хэмжээг жил бүр уламжлал болгон</p>	90.0

			зохион байгуулахаар тогтов.	
238	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албан бус сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа саун массажны газар, зочид буудал, караоке баар зэрэг үйлчилгээний газруудад “Хяналт”, “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээг тус тус зохион явуулав. “Хөршийн хяналт холбоо” хөтөлбөрийн төсөлд санал өгөх зорилгоор 800 гаруй иргэнийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нийслэлийн ажлын хэсэгт хүргүүлсэн. Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нартай хамтарч 2015 оны 6-р сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Иргэдийн баяр-2015” арга хэмжээгээр үйл ажиллагаагаа сурталчилж, 58 иргэнд холбогдох хууль тогтоомжуудын талаар зөвлөгөө өглөө. Хууль зүйн яам, дүүргийн ИТХ, Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэстэй хамтран, эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээний холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, танилцуулга, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор 2015 оны 9-р сарын 9-ний өдөр “Соёмбо кино театрын урд талбайд “Иргэн ба хууль” арга хэмжээг зохион байгуулж, 122 иргэний санал, хүсэлтийг бичгээр хүлээн авч, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” ,Гэр бүл хүчирхийллийн тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Тамхины хяналтын тухай хууль” болон гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 10 төрлийн 1600 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж, гарын авлагыг иргэдэд тараалаа.	90.0	
239	Цагдаагийн 3-р хэлтсийн барилгын өргөтгөл барих асуудлыг холбогдох газарт уламжилна.	Цагдаагийн 3-р хэлтсийн барилгын өргөтгөл барих саналыг нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилт, улс, нийслэлийн хөрөнгө оруулалтанд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 2015 оны 01/1272, 01/1273 тоот бичгээр тус тус хүргүүлэв.	90.0	
240	ЕБС-ийн сурагчид, их дээд сургуулийн оюутнуудын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулна.	Ерөнхий боловсролын 12, 65, 86, 105-р сургуулийн ахлах ангийн 563 сурагчдад “Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах” сургалт зохион байгуулсан. “School police” эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ЕБС-ийн захирал, сурагчдын зөвлөлийн дарга нартай хамтран ажиллах гурвалсан гэрээний дагуу эцэг эхчүүдийг, сургуулийн орчимд ажиллах журмын хүрээнд хорооны хэсгийн байцаагч нар өдөр тутам мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган ажиллаж байна. “Чингэс Соосо” дээд сургуулийн 137 оюутанд “Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах”	70.0	

			сэдэвт сургалт, Цагдаагийн 3-р хэлтэстэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “АХА” тэмцээнийг Мандах бүртгэл дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулав. “Архигүй баасан гариг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10-р сарын 8-ны өдөр дүүргийн их, дээд сургуулиудийн оюутнуудын дунд зохион байгуулагдсан “Архи, тамхигүй ирээдүй-бидний оролцоо” сэдэвт илтгэлийн уралдаанд “Мандах бүртгэл” дээд сургуулийн оюутнуудын илтгэл шалгарсан.	
241	Саппоро үйлчилгээний төвийн орчим 24 цагаар иргэдэд үйлчлэх төв /цагдаагийн кабон/-ийн барилга барих асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.	Саппоро үйлчилгээний төвийн орчимд 24 цагаар иргэдэд үйлчлэх төвийн барилгын төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх саналаа нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтод тусгуулахаар дүүргийн Засаг даргын 2015 оны 8/1934 тоот бичгээр уламжилсан. Цагдаагийн кабоны барилгыг зөөврийн зөөврийн сууц хэлбэрээр барихаар төсөв, хөрөнгийг дүүргийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэж, үнэлгээ хийгдэж байна.	70.0	
242	Хорихоос өөр төрлийн ялтай болон хугацаанаас өмнө суллагдсан, тэнсэн харгалзах ялтай иргэдийн нийгэмших, хөдөлмөр эрхлэх явцад дэмжлэг тусалцаа үзүүлнэ.	“Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, хорих газраас суллагдсан иргэдэд тавих хяналтыг эрчимжүүлье” сэдэвт 45 хоногийн аяны хүрээнд хяналтанд байдаг хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй болон хорих газраас хугацаанаас өмнө суллагдсан 198 иргэний нарийвчилсан судалгааг шинэчлэн гаргасан. Дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, Иргэний бүртгэлийн хэлтэс, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнтэй хамтран хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй болон хорих газраас суллагдсан нийт 77 иргэнийг хөдөлмөрт зуучлах, бүртгэлжүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулав. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/450 дугаар захирамжийн хүрээнд Өршөөл үзүүлэх тухай хуулиар суллагдсан 277 иргэдийг 2015 оны 10-р сард Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн Халамж Үйлчилгээний хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Улаан загалмайн хороо, Бүртгэлийн хэлтэстэй хамтарч бүртгэлжүүлэх, нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах, сэтгэлзүйн зөвлөгөө өгч, ажил хөдөлмөрт зуучлах, байршуулах ажлыг зохион байгуулсан.	90.0	

243		Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн ам, өрхийн тоог харгалзан, олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэх саналыг зохих байгууллагад хүргүүлнэ.	Хороодын хүн амын нягтаршил, газар нутгийн онцлог, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан 3, 7, 8, 9, 10, 11, 12, 20, 23, 25, 29, 30, 31-р хороодод олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэх, ажлын ачаалал их, нөхцөл хүнд байдлыг харгалзан урамшууллыг нэмэгдүүлэх саналыг дүүргийн Засаг даргын 2015 оны 6-р сарын 29-ний өдрийн 02/1479, 10-р сарын 23-ны өдрийн 01/2158 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Цагдаагийн газарт тус тус хүргүүлсэн.	100.0
244	5.8. “Архигүй баасан гараг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	“Архигүй Баасан гараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	Дүүргийн “Архигүй Баасан гараг” дэд хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 бүлэг, 24 заалттайгаар боловсруулан батлуулж хэрэгжилтийг тооцоход 86.5 хувьтай байна. “Архигүй баасан гараг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 12-17, 23, 29-р хороодын Засаг дарга нартай хамтран Баянхошуу, Толгойт, Төв, Өнөр бүсийн 145 иргэн, дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 185 аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудад “Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах нь” сэдэвт нэгдсэн сургалт зохион байгуулж, гарын авлага материал тараав. 2015 оны 3-р сарын 13-ны өдөр дүүргийн хороодын Засаг дарга нар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 91, Цагдаагийн хэлтсийн 59, нийт 150 гаруй албан хаагчид, 33 чиглэлд нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж, 27 зөрчил илрүүлэн, 108,000 төгрөгөөр торгож, 12 иргэнийг түр саатуулан, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 49 аж ахуйн нэгжид цагийн хуваарь баримтлан ажиллах талаар үүрэг өгч ажилласан. Хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2015 оны 11-р сарын 19-ний өдрийн А/462 дугаар захирамжаар дүүргийн ГХУСАЗЗ, Цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран 1, 2, 22, 26-р хороодын 30 чиглэлд нийтийн хэв журам хамгаалах 60 эргүүлийг гарган ажиллууллаа.	90.0
245		Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын дунд харилцан санал солилцох,	“Архидалт, мансууралын эсрэг ассоциац” ТББ-тай хамтран 12-17, 23, 29, 30, 31-р хороодын Засаг дарга, ИНХ-ын дарга нартай 2015 онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөний төслийн уулзалт зохион байгуулсан. Засаг даргын Тамгын газар, “Ерөөгдсөн гэр бүл” ТББ-	90.0

		зөвлөлдөх уулзалт өдөрлөгийг зохион байгуулна.	тай хамтран “Аз жаргалтай гэр бүл” өдөрлөг зохион байгууллаа. Засаг даргын 2015 оны А/463 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт 2015 оны 11-р сарын 27-ны өдрөөс 12-р сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд долоо хоног бүрийн баасан гариг бүр төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын албан хаагчдын оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхээр, нийгмийн хэв журам сахиулах эргүүлийг 32 хорооны 83 чиглэлд хийж байна. 2015 оны 3-р сарын 31-ны өдөр “Драгон” төвийн их танхимд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, худалдаа эрхлэгчдийн зөвлөгөөнийг “ Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг биелүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг оролцоо” сэдвээр хийж, 188 аж ахуйн нэгж, байгууллагын 210 төлөөлөл оролцож, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг хэрэгжүүлэх талаар тайлбарлан таниулж, аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхааруулсан зөвлөмж, гарын авлага тараасан.	
246	5.9. Замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, автын осол, түүнээс учрах хохирлыг бууруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, автын осол, түүнээс учрах хор хохирлыг олон нийтэд таниулж, шаардлагатай байршлуудад мэдээллийн самбар байрлуулна.	Автобусны буудал дээр нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулан зогсож байгаа тээврийн хэрэгслүүдийн фото зургийг баримтжуулан, удаа дараалан зөрчил гаргасан жолооч нарын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах арга хэмжээ авч, сэрэмжлүүлэг болгох үүднээс эрх хассан шийтгэвэр, зөрчлийн фото зургийг ЗЦГ-ын Paparazzi+Traffic mongolia цахим хуудсанд байршуулав. Хамгаалах бүс, малгай, хүүхдийн хамгаалалтын суудлын ач холбогдол, согтууруулах ундааны хор уршиг, хурд хэтрүүлэх, уур бухимдлын хор уршгийн талаар 8 төрлийн 450 ширхэг тараах материал, санамж, богино хэмжээний 3 шторк бэлтгэн тус тасгаар үйлчлүүлж байгаа иргэд, жолооч нарт тараалаа. Хууль зүйн яамтай хамтран 300 гаруй иргэдийг оролцуулсан “Хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээ” сэдэвт болон дүүргийн ГХУСАЗЗ, Цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран Ерөнхий боловсролын 5 сургуулийн Нийгмийн ажилтан, багш, ажилтнууд, эцэг, эхийн төлөөлөлд зохион байгуулсан хууль сурталчлах арга хэмжээгээр шинэчлэн батлагдсан ЗХАБТХ, эцэг,	90.0

			<p>эх, сургууль, багш ажилтнуудын эрх үүрэг, цагдаагийн байгууллагаас хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл өгч, 54 жолоочид эрх хасагдсан талаарх лавлагаа олгон 650 ширхэг тараах материал, санамжийг хүргэв. Дүүргийн ЗДТГ, Замын цагдаагийн тасгийн байрны хүлээлгийн танхимд байрлах нээлттэй дэлгэцээр “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн талаар иргэдэд ойлгомжтой хэлбэрээр бэлтгэсэн шторкуудыг 2015 оны 8-р сарын 15-ны өдрөөс эхлэн сурталчилж, 9-р сарын 10-ны өдөр Үндэсний олон нийтийн радиогийн “Тэнхлэг” шууд нэвтрүүлгээр дүүргийн замын хөдөлгөөний онцлог, нөхцөл байдал, хууль тогтоомжуудын талаар мэдээлэл хийж, иргэдийн асуусан асуултанд хариулт өглөө. 2015 оны тээврийн хэрэгслийн татвараа хугацаанд нь төлөхийг сануулсан 1500 ширхэг, “Замын хөдөлгөөний соёл”, “Хамгаалах бүс”, “Бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж явах” зэрэг 4 төрлийн 300 ширхэг санамж, тараах материалыг иргэд, жолооч нарт тараав. Энэ ажлын хүрээнд “Талх чихэр” ХХК-ний түгээлтийн 25, “ТЭСО” ХХК-ний 18, “Цахилгаан тээвэр” ХХК-ний 2 троллейбус, “Сутайн буянт” ХХК-ны 10 автобусны урд “Хотын соёл-Замын хөдөлгөөнд соёлтой оролцоцгооё” сэдэвт анонсыг хэвлүүлэн 14 хоногийн турш байршуулж сурталчилсан. 1-р хороо Орбитын уулзварын хойд болон зүүн талд “Жолооны ард утсаар бүү ярь, бүү оролд”, “Хамгаалах бүс хэрэглэж хэвшье”, 8-р хороо хувьсгалчдын гудамж, Баянхошууны хуучин эцсийн баруун талд “Бидний ирээдүй жолооч таны гарт байна, та хурдаа тохируул” бичээстэй 2 талтай 3 ширхэг самбарыг тус тус байрлуулсан. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн мэдээлэл, хор уршиг, замын хөдөлгөөний нөхцөл байдал, хот хооронд зорчиход анхаарах зүйлс мөн “Нийтийн тээвэр”, “Автобусны зогсоол”, “Сар шинэ”, “Согтуу”, нэгдсэн арга хэмжээний талаар SBN, Royal HD, ТВ-5, Royal HD телевизүүдээр мэдээлэл өгч, www.medee.mn, www.news.mn, www.zaluu.com мэдээллийн сайтуудад байршуулсан.</p>	
--	--	--	---	--

247		<p>Дүүргийн нутаг дэвсгэрт, шаардлагатай байршлуудад авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио болон явган зорчигчийн хөдөлгөөн хязгаарласан механик хаалт хийлгэх саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.</p>	<p>Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогчдыг аюулгүй, ая тухтай зорчуулах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн замын зохион байгуулалтыг шинэчлэн зохион байгуулах, үрэгдэж, алга болсон тэмдгүүдийг нөхөн суурилуулах, сэргээн засварлахаар анхааруулах тэмдэг 56 ширхэг, дарааллын тэмдэг 23 ширхэг, мэдээлэх тэмдэг 31, нийт 110 тэмдэг, 42, 65, 106, 107, 123-р сургуулиудын ойр орчимд 88 метр хурд сааруулагчийг суурилуулахаар нийслэлийн АЗГ-т саналаа хүргүүлсэн бөгөөд 58 тэмдэгийг шинээр болон нөхөн суурилуулсан. 2015 онд 1-р хорооллын 34-р байрны хойд замаас 32-р байрны уулзвар хүртэл тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн хөдөлгөөнийг хязгаарласан зорчих хэсгийн голын үргэлжилсэн тэмдэглэлийн дагуу Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлээр 150 метр хайс суурилуулсан. Ерөнхий боловсролын 15 сургуулийн 16 байршилд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иж бүрэн тэмдэг, тэмдэглэл, стандартын шаардлага хангасан хурд сааруулагчийг холбогдох байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн.</p>	100.0
248		<p>Замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхэд багачуудын дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнүүдийг зохион байгуулна.</p>	<p>Сургуулийн өмнөх насны хүүхэд, багачуудыг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний мэдлэг дадлага олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлах, энэ ажилд эцэг, эхчүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнийг 2015 оны 4, 10-р сард дүүргийн Засаг даргын 2015 оны А/392 дугаар захирамжаар 15 цэцэрлэгийн 192 хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын 24 сургуулийн 3-5 дугаар ангийн 360 сурагчдын дунд зохион байгуулж, 2.3 сая төгрөгийг зарцуулав. ТВ-25, ТВ-5, SBN телевизүүдээр тэмцээний ач холбогдлыг олон нийтэд сурталчилсан.</p>	100.0
249		<p>21-р хорооллын гэрэл дохиотой уулзварыг шинээр сэргээн засварлах саналыг холбогдох байгууллагуудад</p>	<p>21-р хорооллын уулзварыг 4 замын уулзвар болгон өөрчлөн зохион байгуулж, уулзварын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор эгнээний тоог нэмэгдүүлэх санал, судалгаа, захиалгыг нийслэлийн Авто замын газарт хүргүүлсэн. Хөрөнгө мөнгөний асуудал</p>	30.0

		хүргүүлж, шийдвэрлүүлнэ.	шийдэгдээгүй шалтгаанаар хойшлогдсон.	
250		Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн хүүхдүүдийг хичээлд ирэх, тарах үед бага дунд оврын нийтийн тээврийн хэрэгслээр зөөвөрлөх ажлыг зохион байгуулна.	Ирээдүй цогцолбор сургуулийн сурагч, эцэг эхчүүд, 23-р хорооны иргэдийн ирүүлсэн хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан 34-р байрнаас Баянхошууны Суваргын хооронд бага оврын нийтийн тээврийн автобус явуулах талаар тус хорооны ИНХ, нийслэлийн Тээврийн газартай хамтарч саналаа солилцсон. Дүүргийн төрийн өмчийн 3, төрийн бус өмчийн 1, ЕБС-ийн бага ангийн хүүхдүүд тээвэрлэх 3 тээврийн хэрэгслийн стандартын шаардлага хангасан эсэхийг шалгаж, улсын дугаарын гэрэлтүүлэх хэрэгсэл, тормосны гэрэл асахгүй 2 зөрчил, жолоочийн даатгалын хугацаа дууссан 1 зөрчил илрүүлж, арилгуулах арга хэмжээ авсан. Мөн дүүргийн ЕБС-иудын хүүхэд тээвэрлэх автобусуудад хяналт шалгалт хийж, стандартын шаардлага хангасан 67-р сургуулийн Каунти маркийн 2867 УНУ улсын дугаартай дунд оврын автобусанд “Хүүхдийн автобус” зөвшөөрөл олгосон.	90.0
251	5.10. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад	Гамшгаас хамгаалах команд штабын болон бусад төлөвлөгөөт бүх төрлийн сургалт дадлагыг зохион байгуулна.	Дүүргийн төр захиргааны болон аж ахуй, нэгж байгууллагуудад Онцгой комиссын 2015 оны № 01, 02, 03 тоот “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, зарлан мэдээллийн дадлага, сургалт зохион байгуулах тухай” албан бичгийг хүргүүлж, танхимын болон дадлага сургалтанд нийт 37531 иргэнийг хамруулав. Мөн дүүргийн гамшгаас хамгаалах 8 албаны 123 албан хаагч, 32 хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нар, 60 гаруй мэргэжлийн ангийн 4500 албан хаагчдад гамшгаас хамгаалах сургалтыг 2015 оны 5, 9, 10-р саруудад 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 4832 хүнийг хамруулав.	100.0
252	учрах хохирлыг бууруулна.	Дүүргийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг нутаг дэвсгэрийн 100 аж ахуйн нэгж, байгууллагуудад явуулна.	Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран 2015 оны 10-р сарын 26-30-ны өдрүүдэд дүүргийн 100 аж ахуйн нэгж байгууллагад Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад ерөнхий үнэлгээгээр 82.1 хувь буюу “В” үнэлгээтэй шалгагдсан. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн үйл ажиллагаа, явцын талаарх мэдээллийг олон нийтийн телевиз, www.shd.mn цахим хуудсаар сурталчилсан.	100.0
253		Хороо тус бүрт гамшгаас хамгаалах загвар төлөвлөгөө боловсруулан батлуулна.	Тохиолдож болзошгүй байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, тэжээвэр болон зэрлэг мал, амьтан, ургамлын гоц халдварт өвчнөөс хүн болон хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, хамгаалах,	90.0

			гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу зохион байгуулж гүйцэтгэх үед мөрдөн ажиллах загвар төлөвлөгөөг 32 хороо тус бүрт хүргүүлсэн. Дүүргийн Гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө, 32 хороодын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулсан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх аргачлалын талаарх сургалтыг 2015 оны 6, 8-р сард 2 удаа зохион байгуулж, 96 хүн хамрагдсан.	
254	Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, үерийн хамгаалалтын далан суваг, ус зайлуулах хоолойг цэвэрлэх ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Онцгой комиссын даргын 2015 оны “Далан сувгийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” 02 дугаар тушаалаар шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Дүүргийн 32 хороодод албан шаардлага хүргүүлж, нутаг дэвсгэрт байрлах гуу жалга, үерийн далан, сувгийг цэвэрлэх ажлыг Тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний төвтэй хамтран зохион байгуулж, 4,3 км далан сувгийн 5.8 куб.м хогийг ачуулж тээвэрлүүлэв. 2015 оны 6-р сард үерийн аманд буусан 940 айл, өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, мэдэгдэл хүргүүлсэн. 2015 оны 7-р сард дүүргийн нийт гэр хорооллын 10 хороо, “Буян Хөхий” мал эмнэлэгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн багтай хамтран хөрсний бохирдол ихтэй 13000 м ² талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийсэн	90.0	
255	Онцгой байдлын хэлтсийн техник, хэрэгслийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.	Шаардлагатай техник хэрэгслэлийн судалгааг гаргаж, саналыг нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллаж, гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах, бэлтгэл байдлыг дээшлүүлэх зорилгоор 72.0 сая төгрөгийн өртөг бүхий Газел авто машин, дагалдах аврах багаж хэрэгслийг албан хэрэгцээнд өгсөн. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/314 дүгээр захирамжаар үерийн аюулын үед ашиглах 2.9 сая төгрөгийн өртөг бүхий ус соруулах усан шахуурга, /мотопомп/ хоёрыг шийдвэрлүүлсэн. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, дадлага, сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн 23.5 сая төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас шийдвэрлүүлсэн.	100.0	

256	5.11. Аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтыг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.	Хүнсний болон барилгын материалын үйлдвэрлэлд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2-оос доошгүй үлгэр жишээ сургалтын бааз бий болгоно.	Эрэл” тоосгоны үйлдвэрийн захиргаатай хамтран жишиг сургалтын танхим байгуулсан.	50.0
257	5.12. Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавин иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.	Цэрэг халалт, татлага, цэргийн насны залуучуудын эрүүлжилтийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/110, А/397 дугаар захирамжийн дагуу 2015 оны нэг, хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанаас халагдаж ирсэн дайчдыг 2015 оны 05-р сарын 01, 02, 10-р сарын 15-ны өдрүүдэд, цэргийн жинхэнэ албаны татлага, гэрээт цэргийн албанд иргэдийг элсүүлэх ажлыг 2015 оны 05-р сарын 08-10, 10-р сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж, нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн тоон даалгаврыг бүрэн биелүүллээ. Цэргийн жинхэнэ албаны татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийн нэрийг хороо тус бүрээр гаргаж хорооны Өрхийн эрүүл мэндийн төв, дүүргийн Эрүүл мэндийн төвд хүргүүлэн, 1-р ээлжийн цэрэг татлагаар өвчнөөр чөлөөлөгдөн богино хугацааны хяналтанд орсон 150 иргэдээс 55 иргэн эрүүлжэн цэргийн жинхэнэ албанд татагдсан. Монгол Улсын Батлан хамгаалах, Хууль зүй, дотоод хэрэг, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2010 оны 115/58/103 дугаар тушаал “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчдын эрүүл мэндэд дүгнэлт гаргахад баримтлах журам”-ын 2.1.5 дахь заалт, дүүргийн Засаг даргын 2015 оны А/208 дугаар захирамжийг хэрэгжүүлэн цэргийн насны залуучуудийг	100.0

			эрүүлжүүлэх хэлэлцүүлгийг 2015 оны 11 дүгээр сарын 09-нд дүүргийн болон Эрүүл мэндийн төвийн удирдлага, нарийн мэргэжлийн эмч нар, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, хорооны Засаг дарга нарыг хамруулан зохион байгуулав. Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх ажлын үр дүнг сайжруулах зорилгоор 2.500.000 төгрөгийн сан бүхий болзолт уралдаан зарласан.	
258	Дайчилгааны бэлэн байдлын бэлтгэлжилтийг нэмэгдүүлж, дайчилгааны даалгавар биелүүлнэ.	Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө түүний хавсралтуудад хийх тодотголыг 2015 оны 02 дугаар сарын 12-нд Цэргийн штабын томилогдсон офицерууд зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын “Тодотгол явуулах тухай” 2015 оны н/04 дүгээр тушаал, 2015 оны бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдийн тоо бүртгэлийн дүнг үндэслэн дайчилгааны даалгавартай 12 ангийн 21 командаас 10 ангийн 17 командыг биечлэн, 2 ангийн 4 командтай эчнээ тодотгол явуулахаар Зэвсэгт хүчний Жанжин штабын шууданд тараах дансанд гарын үсэг зуруулан хүлээлгэн өгсөн. 2015 оны 02-р сарын 05, 09 дүгээр сарын 08-ны өдөр дотоодын, 2015 оны 06 дугаар сарын 15, 09 дугаар сарын 07-ны өдөр нийслэлээс өгөгдсөн зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, дүүргийн дайчилгаа удирдах бүлэг, хороод, цугларах, шилжүүлэх байруудад зарлан мэдээлэл явуулан, үүрэг гүйцэтгэх боломж, бэлэн байдлыг шалгаж, зарлан мэдээллийн дохиогоор ажилласан тэмдэглэлийг табель маягтаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргэсэн. 2015 оны 09-р сарын 08-20-ны өдрүүдэд дайчилгаатай команд-штабын болон тусгай тактикийн хээрийн сургуульд оролцож, өгөгдсөн дайчилгааны даалгаварыг цаг хугацаанд бүрэн биелүүлэв.	100.0	
259	Орон нутагт Батлан хамгаалах хууль, тогтоомж сурталчилж иргэн-цэргийн харилцааг бэхжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалган туслах ажлыг дүүргийн нутаг дэвсгэрийн 12 аж ахуй нэгж, байгууллагад зохион байгуулж явуулсан. Энэхүү шалган туслах ажлаар нийт 453 цэргийн үүрэгтэн хамрагдан үүнээс цэргийн тоо бүртгэлд хамрагдаагүй 61, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 35, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй	100.0	

			<p>28, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 112 иргэнийг тогтоон илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч, батлан хамгаалах хууль тогтоомжийг байгууллагын удирдлага, цэргийн үүрэгтнүүдэд тайлбарлан таниулах, гарын авлага тараах ажлыг зохион байгуулав. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын “Дөл” тоглолтыг 2015 оны 03-р сарын 09-ний өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн байрлалд зохион байгуулж явуулав. Цэрэг спортын “Дөл” тоглолтод дүүргийн Ерөнхий боловсролын 15 сургуулийн 180 сурагч, багш дасгалжуулагчид хамрагдан, батлагдсан удирдамж, зааврын дагуу 9 төрөлд хурд хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдөж, 67-р сургуулийн “Супер дайчид” баг тэргүүн байр, 105-р сургуулийн “Соёмбо” баг дэд байр, 122-р сургуулийн “Дөл” баг гутгаар байр эзлэн “Өргөмжлөл”, медаль, мөнгөн шагналаар шагнагдлаа. 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдөр соёлын төв өргөөнд зохион байгуулагдсан “Бидний ажил” сэдэвт нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабуудын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд ажлаа танилцуулах өдөрлөгийн арга хэмжээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын үйл ажиллагааг сурталчилсан хулдаасан хэвлэл, зурагт самбар-14 ширхэг, батлан хамгаалах хууль тогтоомжийн танилцуулга нугалбар-400 ширхэгийг тус тус шинээр хэвлүүлэн бэлтгэж оролцов. Тус өдөрлөгийн арга хэмжээнд дүүргийн 32 хорооноос 200 гаруй ахмад дайчин, бэлтгэл офицер, ерөнхий боловсролын сургуулийн 50 сурагчид оролцож, 3 үеийн уулзалт баярын арга хэмжээ, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудын үйл ажиллагаагаа сурталчилсан мэдээлэл, танилцуулга, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчдийн тоглолтыг үзэж сонирхсон. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын нэрэмжит “Цэргийн алдар” спорт тэмцээн 2015 оны 03-р сарын 14-нд Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн спорт зааланд явагдаж, гар бөмбөг, сагсан бөмбөг, дардасын төрлүүдээр 9 хэлтэс, албад, хороодын 4 бүсийн 130 гаруй тамирчид өрсөлдөн, багийн дүнгээр Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эдийн засаг төлөвлөлтийн хэлтсийн хамтарсан баг тэргүүн</p>	
--	--	--	---	--

			байр, Өмч, газрын харилцаа, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны баг 2, 3-р байр эзлэн өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнагдсан. Монгол цэргийн өдрийг угтсан арга хэмжээний хүрээнд 2015 оны 03-р сарын 12-ны өдөр Соёмбо кино театрт дүүргийн иргэд, хүүхэд залуучууд, Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиудын оролцоотой “Эр цэрэг эгэл амьдрал” сэдэвт 5 үеийн төлөөлөл оролцсон уулзалт цэрэг, урлаг соёлын баярын арга хэмжээг зохион байгуулж явуулав. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 94 жилийн ойг тохиолдуулан дүүргийн 67-р сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-эх оронч үзэл, бахархал төлөвшүүлэх “Бид эх орны ирээдүй” сэдэвт уулзалт ярилцлагын ажиллагааг 2015 оны 03 дугаар сарын 10-нд зохион байгуулж явуулсан. 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд дүүргийн Засаг даргын 2015 оны А/353 дугаар захирамжийн дагуу ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу ахмад дайчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, Төрийн одон, медаль, Засаг дарга гарын бэлгээ гардуулсан.	
260	Цэргийн жинхэнэ алба хааж байгаа цэргийн алба хаагчдын ар гэрт дэмжлэг тусламж үзүүлж, цэргийн албанаас халагдан ирж байгаа цэргийн алба хаагчдад мэргэжлийн байгууллагатай хамтран ажлын байранд зуучлах, мэргэжил олгох сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.	Цэргийн жинхэнэ албанд татагдсан хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийг судлан ажилд зуучилсан 71, мэргэжил олгох сургалтанд 24, эрүүл мэндийн үзлэгт 39, эд материалын тусламж үзүүлсэн 21, 7 иргэнд 1274000 төгрөгийн мөнгөн тусламж, 19 иргэнд 13,05 тонн нүүрсний тусламжид тус тус хамруулах ажлыг зохион байгуулж ажиллав. Дүүргээс 2014 оны 1,2-р ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдан алба хаах хугацаагаа дуусган халагдаж ирсэн цэргийн алба хаагчдыг хүлээн авах ажиллагааг дүүргийн хороод, Хөдөлмөрийн хэлтсийн ажилд зуучлах үйлчилгээний мэргэжилтэн, хороо хариуцсан мэргэжилтэнүүдтэй хамтран зохион байгуулж нийт 103 иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааг сурталчилсан 8 төрлийн гарын авлага материал 240 ширхэгийг тарааж, 79 иргэнийг идэвхтэй ажил хайгчаар бүртгэж сул чөлөөтэй ажлын байранд зуучлан, мэргэжил олгох сургалтанд 22, эд материалын тусламжид 20 халагдсан дайчдыг хамруулав.	100.0	

261	5.13. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлж, өндөр хөгжилтэй орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоон, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг татаж ажиллана.	Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргүүдтэй үйл ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын Тамгын газраас шинээр харилцаа хамтын ажиллагаа тогтоож буй Япон Улсын Шизүока мужийн Изүнокүни хотод 2015 оны 5-р сарын 11-нээс 15-ны өдрүүдэд албан айлчлал хийлээ. Уг айлчлалаар хоёр талын хамтын ажиллагааны чиглэлүүдийг хэлэлцэж, Санамж бичиг байгуулах талаар ярилцан, төслийг албан ёсоор гардууллаа. Дүүргийн Засаг даргын А/262 дугаар захирамжийн дагуу харилцаа, хамтын ажиллагаатай Хайлаар хотод зохион байгуулдаг Хятад, Монгол, Орос гурван улсын Эдийн засгийн форум, үзэсгэлэн яармаг худалдаанд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 15 иргэн, төрийн байгууллагуудын төлөөлөл 5 албан хаагч оролцлоо. Энэхүү арга хэмжээний үеэр дүүргийн жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг Хайлаар хотод борлуулах “Сонгинохайрханд үйлдвэрлэв” худалдааны цэг нээхээр Санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн Хайлаар хотын захиргаа, дүүргийн ЗДТГ-ын хооронд Ногоон байгууламж, хүнсний ногоо тариалалтын тал дээр хамтарч ажиллах Санамж бичгийг үзэглэлээ. 2015 оны 8-р сарын 06-наас 09-ний өдрүүдэд Шизүока мужийн Захирагч Кавакацү Хэйта, Изүнокүни хотын дарга Оно Тошико нарын тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатар хотноо айлчлан ирж Хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурсан. Тус Санамж бичигт заасны дагуу хоёр тал Боловсрол, Эрүүл мэнд, Хөдөө аж ахуйн чиглэлүүдэд түлхүү хамтарч ажиллана.	100.0
262	5.14. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ХЭАХН, ШӨХТГ-тай хамтран ажиллана.	Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	ШУТИС-ийн Шим тэжээл судлалын төвтэй хамтарч “Зохистой хоол-эрүүл мэнд” сэдэвт, дүүргийн ЭМН, “Өнөр” бүсийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран “Эрүүл аюулгүй хүнс-жирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолт” сэдэвт өдөрлөгүүдийг тус тус зохион байгуулав. Нийслэлийн ЭМГ, “With” ТББ-ын хөрөнгө оруулалтаар “Хоол шим тэжээлийн боловсрол олгох төв”-ийг дүүргийн ЭМН-ийн харъяалалд шилжүүлсэнээр эрүүл бус хооллолтын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хооллолтын зөв дадалтай болгох нийтийг хамарсан ажлуудад чухал түлхэц боллоо. “Эрүүл зөв хооллолт”-ын тухай үндсэн ойлголт, ач холбогдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэн, “Хүн бүр хооллолтын зөв дадал хэвшил эзэмшиж, эрүүл бие саруул ухаантай байцгаая” сэдэвт сурталчилгааны	70.0

			<p>1,5x2,0 харьцаатай хулдаасан анонсыг, “Драгон терминал” худалдааны цогцолборын 1-р давхрын автовокзалын талбай, ЗДТГ-ын дэргэд тус тус байрлуулсан. Энэ уриалгатай холбогдсон цуврал зөвлөмж, мэдээллүүдийг “Сонгинохайрхан” сонин, www.hereglegch.rlm.mn” цахим хуудсаар сурталчилсан. Энэ хугацаанд хэрэглэгчдээс бичгээр 1, утсаар 16 санал гомдлуудыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэж, 4 хэрэглэгчийн 630,0 мянган төгрөгний хохиролыг шүүхийн өмнөх шатанд нь барагдуулав. Төлөвлөсөн 12 ажил бүрэн гүйцэтгэлтэй, төсвийн санхүүжилтийн хүлээгдлээр 9 ажил хэрэгжих шатандаа, 2 ажил биелээгүй байна. ХЭАХН-ээс үсчин гоо сайхан, гар утасны худалдаа, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хүнсний бөөний захуудад хяналт тандалтын ажлыг хийж, холбогдох байгууллагуудад зөвлөмж, санал хүргүүлсэн.</p>	
--	--	--	--	--

---000---